Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

BUILDING & CONSTRUCTION MONGOLIA 2013
MINING 2013 MONGOLIA
POWER & RENEWABLE ENERGY MONGOLIA 2013

2013 оны 9 сарын 19 – 21

Буянт-Ухаа спорт цогцолбор, Улаанбаатар хот

www.miningandconstructionmongolia.com

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл 2013. 9 сар. №16 (050) www.mongolianeconomy.mn

УУЛ УУРХАЙН УНАЛТ БА ЭДИЙН ЗАСГИЙН ДОРГИЛТ



Шог зургийг А.Амарсайхан

INTERNATIONAL®

ХҮЧ ЧАДЛЫГ СОРЬСОН АЖИЛД ХҮЧ ЧАДЛАА ХАРУУЛСАН МАШИН...



9900-8757, 9999-1723, 9910-3827
trucks@wagnerasia.com

WAGNER
ASIA INDUSTRIAL LLC

30th Азийн Банкны Холбооны ЧУУЛГАН-ХХХ

Ази, Номхон далайн бүс нутгийн санхүү, банкны салбарын төлөөлөл, мэргэжилтнүүд

“АЗИ: ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ХӨДӨЛГҮҮР”

УРИАН ДОР ЧУУЛНА

Platinum Sponsors

GOLOMT BANK — Committed to and Investing in Excellence
KHAN BANK — YOUR TRUSTED FRIEND
TDB — TRADE & DEVELOPMENT BANK
XacBank — Right Bank

Gold Sponsors

CAPITAL BANK — THE FIRST COMMERCIAL BANK OF MONGOLIA
CapitronBank — Your success is our benchmark
CHINGGIS KHAAN BANK
STATE BANK
ULAANBAATAR CITY BANK
GrapeCity Mongolia
ORACLE FINANCIAL SERVICES
DELL
intel

Silver Sponsors

CREDITBANK — BUILDING CONFIDENCE TOGERTHER
NIBank
ERELBANK — For Excellence in Service
TransBank

Media Partners

Bloomberg TV MONGOLIA
EAGLE news tv
MONGOLIAN ECONOMY

Institutional Partners

THE BUSINESS COUNCIL OF MONGOLIA
OXFORD BUSINESS GROUP — THE INSIDE EDGE
IFC — International Finance Corporation — World Bank Group

2013 оны 9 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд , Блю Скай Тауэр

Нөгөөн хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800-6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс
ОРЧУУЛАГЧ: Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД: Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Э.Зоригт
Х.Хулан

ДИЗАЙНЕР: Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР: Д.Барианжав /9409-2904/
Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР: М.Хишигтогтох /9409-2906/

“ECONOMY” ТВ СТУДИ
РЕДАКТОР: Б.Үүрийнтуяа

ХАЯГ:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:
"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Фреско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mall" салбарууд

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ



ЭДИЙН ЗАСАГ

10 Доргилттой эдийн засаг

12 Төсвийн хямрал

15 “Өмдгүй” эдийн засаг

17 Бид нүүрсний үнээс биш, өөрсдөөсөө болж хямарлаа

20 Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв

23 Монголын эдийн засгийн 2013 оны төлөв

26 Экспортын зөвлөх үйлчилгээ



“Чингис” бонд хөрөнгө оруулагчдад таалагдахаа больсон 27

29 Улаанбаатар хотод энэ сард зохиогдох арга хэмжээнүүд

32 Банкны салбарын нийт хөрөнгө нь ДНБ-ий 85 хувийг дангаараа бүрдүүлдэг

УУЛУУРХАЙ

34 Уул уурхайн шийдэл юу байх вэ

36 Төрийн дон

38 Татаасын тогтолцоо



41 Бид өвджээ

42 Монгол Улс хөрөнгө оруулагчидгүйгээр уул уурхайгаа ашиглаж чадах уу

44 Дэлхийг хөдөлгөгч Африк

48 Гүний уурхай Монголд

50 Давхар цохилт

52 Үндэсний стандарт

54 Нийгмийн хариуцлага уул уурхайн салбарт

Монголд

Дэлхийн банк Монгол Улсын эдийн засгийг 2013 оны төгсгөлд 13 хувиар өсөлт үзүүлнэ гэж тооцож байгаа ч хөрөнгө оруулалтын болон бусад тодорхойгүй байдал эдийн засагт тогтворгүй байдал авчирч байна. Экспортын өсөлт саарч, гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал огцом багассан нь БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт нэгдүгээр улиралд удаашралтай байсантай холбоотой гэж үзжээ.



Инфляци 2012 оноос хойш хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэж байсан бол энэ оны гуравдугаар сард 9.8 хувь болж буурсан. Тэгвэл Үндэсний статистикийн хорооны мэдээллээр долоодугаар сард инфляци 8.3 хувьд хүрчээ. Гэхдээ мөнгөний бодлого богино хугацааны зээлийн хүүг бууруулах замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих горимд шилжиж, төсвийн бодлогын тэлэлт үргэлжилж байгаа энэ нөхцөлд инфляцийн бууралт он дуустал үргэлжлэх эсэх нь тодорхойгүй байна.

ЭЗХЯ болон Монголбанкны мэдээллээс үзэхэд Монгол Улсад энэ оны эхний хагаст нийт 961 сая ам.долларын шууд хөрөнгө оруулалт бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43 хувиар буурсан дүн юм. Үүнээс уул уурхайн олборлох салбарын хөрөнгө оруулалт 32 хувиар буурчээ. Бусад садбарын шууд хөрөнгө оруулалт 50 ба түүнээс дээш хувиар багассан





байна. Эндээс харахад хөрөнгө оруулалт татарч байгаа нь зөвхөн уул уурхайн салбарын хүндрэл биш, нийт эдийн засгийг хамарсан үзэгдэл болоод байна.

Монгол Улс энэ оны эхний долоон сарын байдлаар нийт найман сая гаруй тонн нүүрс экспортолж, 582 сая ам.долларын орлого олжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын орлого 20 гаруй хувиар буурсан үзүүлэлт юм. Мөн дэлхийн зах зээлд нүүрсний үнэ хоёр дахин унасан. Уул уурхайн яамны мэрэгжилтнүүдийн тооцоолсноор энэ онд уул уурхайн өртөг зардлыг бууруулахын тулд тодорхой арга хэмжээ /гүнийн гааль, захиргаа, гаднын оператор/ авч байгаа ажээ.

“Эрдэнэс Тавантолгой” ХК энэ оны наймдугаар сарын байдлаар 2.6 сая тонн нүүрс олборлоод байна. Тус компани энэ онд Зүүн Цанхийн уурхайгаас 4.5 сая тонн, Баруун Цанхиас гурван сая тонн нүүрс олборлох боломжтой аж. Энэ нь өмнөх оныхоос гурав дахин их гэсэн үг. Баруун цанхийг эдийн засгийн эргэлтэд оруулснаар Хятадын талд төлөх өрийн үлдэгдэл болох 170 сая ам.долларыг барагдуулах бөгөөд 200 гаруй сая ам.долларын экспортын орлого олох боломжтой гэнэ.

ТООН МЭДЭЭЛЭЛ

Уул уурхайн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, татварын орлогын гүйцэтгэл (2013 оны эхний хагас жилийн байдлаар)

	Үйлдвэрлэл биет хэмжээгээр	Татварын орлого (тэрбум төгрөгөөр)	2013 оны төлөвлөгөө
Зэс (мян.тонн)	1..568	1.568	0.6%
Нүүрс (сая.тонн)	35	28	-21.1%
Молибден (тонн)	8.859	7.643	-13.7%
Алт (кг)	2.199	1.956	-11.1%
Жонш (мян.тонн)	2.400	2.192	-8.7%
Төмөр (мян.тонн)	26.183	22.943	-12.4%
Цайр (мян.тонн)	31.157	24.740	-28.2%
Нийт дүн	59.350	51.512	-13.2%

Эх сурвалж: Уул уурхайн яам

Гол нэр төрлийн ашигт малтмалын дэлхийн зах зээлийн дундаж үнэ (ам.доллараар)

Ашигт малтмалын төрөл	Үйлдвэрлэл биет хэмжээгээр	Татварын орлого (тэрбум төгрөгөөр)	2013 оны төлөвлөгөө
Алт (унци)	1.568	1.568	0.6%
Мөнгө (унци)	35	28	-21.1%
Зэс (тонн)	8.859	7.643	-13.7%
Цайр (тонн)	2.199	1.956	-11.1%
Хар тугалга (тонн)	2.400	2.192	-8.7%
Цагаан тугалга (тонн)	26.183	22.943	-12.4%
Молибдени (тонн)	31.157	24.740	-28.2%
Гянтболд (тонн)	59.350	51.512	-13.2%
Төмрийн хүдэр (тонн)	168	146	-13.1%
Нүүрс (тонн)	209	127	-39.1%

Эх сурвалж: Уул уурхайн яам

Дэлхий дахинд



Шинэ Зеландын “Fronterra” компани сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлогч дэлхийн хамгийн том компани бөгөөд бүтээгдэхүүнд нь ботулизм хэмээх хорт бодис үүсгэгч бактери агуулагдаагүй болохыг тус улсын Үйлдвэрийн сайд мэдэгдлээ. Дээрх асуудлын улмаас тус компани бүтээгдэхүүнээ их хэмжээгээр буцаан татах, импортын хориг тавигдах асуудалтай тулгараад буй. Бактерийн хувьд ботулизм үүсгэдэггүй өөр төрлийн нян болохыг туршилтаар нотолжээ.



Евробүс жил хагасын турш хямралтай байсны эцэст энэ оны хоёрдугаар улиралд хямралаас гарчээ. Бүсийн орнуудын ДНБ энэ оны хоёрдугаар улиралд 0.3 хувиар өссөн нь таамаглаж байснаас ялимгүй дээгүүр үзүүлэлт болохыг “Eurostat” агентлаг мэдээлэв. Энэ хугацаанд Германы эдийн засаг 0.7 хувиар, Франц 0.5 хувиар, мөн евробүсэд хамгийн бага өсөлттэйд тооцогдох Португалийн эдийн засаг 1.1 хувиар өсчээ.


АНУ-д өнгөрсөн зургадугаар сард орон сууцны үнэ огцом өссөн нь жилийн өмнөх үеийнхээс 12.1 хувиар нэмэгдсэн үзүүлэлт болохыг “The Standard & Poor’s”-ийн үнэлгээний индекс харуулжээ. Уг индексийг гаргахдаа тус улсын 20 гаруй хотын айл өрхүүдийн дунд хийсэн судалгааг үндэслэжээ. Дээрх өсөлт нь өнгөрсөн тавдугаар сарын өсөлтөөс ялимгүй доогуур үзүүлэлттэй аж. Лас Вегас, Сан Франциско хотод орон сууцны үнэ 25 хувиар нэмэгдсэн байна.






Хонконгод ирэх аравдугаар сарын 7-нд дэлхийд хамгийн том алмазыг дуудлага худалдаанд оруулах гэж буйг “Bloomberg” агентлаг мэдээлэв. Өмнөд Африкийн Претория гэх газраас олдсон уг эрдэнэсийн дуудах үнэ 19 сая ам.доллар бөгөөд жин нь 7.59 карат аж. Үнэлгээг АНУ-ын Үнэт чулууны хүрээлэнгээс гаргажээ.

БНХАУ цахим худалдаагаараа АНУ-ыг тэргүүлэхэд тун ойрхон байна. “Bain & Co” зөвлөх компанийн судалгаагаар урд хөршид онлайн худалдаа жилд дунджаар 32 хувиар өсч байгаа бөгөөд 2015 он гэхэд 3.3 их наяд юань буюу 539 тэрбум ам.долларт хүрэх ажээ. Уг судалгааг олон хот, сууринд янз бүрийн орлоготой, боловсролын түвшин, насны ангилал харилцан адилгүй 1300 орчим худалдан авагчийн дунд явуулжээ. ■



А.Амарсайханы булан




TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

УДАХГҮЙ таны УТСАНД

mPOS

iOS





1 ЧИП карт

2 СОРОНЗОН туузтай карт

ШИНЭЛЭГ
→ ТӨЛБӨР ТООЦООНЫ ДЭВШИЛТЭТ ШИЙДЭЛ

ХӨДӨЛГӨӨНТ
→ ХААНА Ч ХЭРЭГЛЭХЭД ТОХИРОМЖТОЙ

ЭНГИЙН
→ ХЭРЭГЛЭХЭД ХЯЛБАР

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:

1977 www.tdbm.mn info@tdbm.mn

MINING 2013 MONGOLIA

POWER & RENEWABLE ENERGY MONGOLIA 2013

2013 ОНЫ 9 САРЫН 19-21-НД

БУЯНТ-УХАА СПОРТ ЦОГЦОЛБОРТ

IPAD2 ХОЖИХ БОЛОМЖ



Яг одоо онлайнаар бүртгүүлээд үнэ төлбөргүй үзэсгэлэн үзэх зочны мандат шуудангаар хүлээж авах төдийгүй таны бүртгэл автоматаар **2** *шүрхэг iPad2-ын нэгийг хожих азын сугалаанд оролцох эрхтэй болно. 2013 оны 9-р сарын 19, 20 ны өдрүүдэд тус бүр* **1**, *нийт* **2** *азтан iPad2-ын эзэн болох болно.*



Яг одоо
www.miningandconstructionmongolia.com
хаягаар бүртгүүлнэ үү.

ГАЙХАЛТАЙ БОЛОМЖУУДАД ХҮРГЭХ УРИЛГА

3 өдрийн турш шинэ нөөц бололцоо, шинэ санаа,

18 орны 120 компани
уул уурхай, барилга, цахилгаан эрчим хүчний салбарт салбарт зориулсан технологи, үйлчилгээгээ урд өмнө нь Монголд болж байгаагүй өргөн цар хүрээнд дэлгэн үзүүлэх болно.



ҮЗЭСГЭЛЭНГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

2013 оны 9-р сарын 19-20	**10:00-17:00**
2013 оны 9-р сарын 21	**10:00-16:00**

Болох газар: БУЯНТ-УХАА СПОРТ ЦОГЦОЛБОР

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД

GOVERNMENT OF MONGOLIA УУЛ УУРХАЙН ЯАМ
GOVERNMENT OF MONGOLIA ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМ
GOVERNMENT OF MONGOLIA БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
MONGOLIAN NATIONAL CHAMBER OF COMMERCE AND INDUSTRY
THE BUSINESS COUNCIL OF MONGOLIA
AN ALLWORLD EXHIBITIONS EVENT
AWED
MONGOLIAN ECONOMY

www.miningandconstructionmongolia.com

Утас: 976-11-344488 цахим шуудан: sales@lookmongolia.com

ДОРГИЛТТОЙ ЭДИЙН ЗАСАГ



И.ОТГОНЖАРГАЛ

Цовоо цолгин зангаараа сүүлийн жилүүдэд дэлхийн анхаарлыг татаж байсан Монголын эдийн засаг өнөөдөр нэг л туниа муутай байна. Хүнээр бол тархи нь доргисон гэсэн үг. Тархины доргилтыг цаг алдахгүй эмчлэхгүй бол удах тусам дээшээ огиж, доошоо суулгах байдлаар хүндэрдэг аюултай. Хэдэн жилийн өмнөөс уул уурхай хэмээх аварга машинд тухалж, цагт 100 км цагаас дээш хурдтай давхиж байсан Монголын эдийн засаг энэ оны эхний хагаст гэнэт хүч алдав. Өндөр өсөлттэй эдийн засгийн зүтгэх хүч нь байсан нүүрсний үнэ, экспорт огцом уруудсан учраас ийнхүү хүч алдахад хүрсэн хэрэг. Алт, зэс, жонш, төмөр, уран, газрын ховор элемент гээд уул уурхайн олон бүтээгдэхүүн дотроос экспортын орлогоороо тун богинохон хугацаанд цойлж гарч ирсэн нүүрсний орлого буурсан гэсэн дан ганц шалтгаан нь эдийн засгийн доргилт бий болгосон уу гэвэл үгүй. Үүнээс ч илүү хүчтэй нөлөө үзүүлсэн байж болох хөндлөнгийн шалтгаанууд бас бий. Үүнд улс төрийн тогтворгүй байдал, “Оюутолгой” болон хөрөнгө оруулалттай холбоотой асуудал багтана.

Өнөөдөр улсын төсвийн орлого төлөвлөснөөс 30 гаруй хувиар тасраад байна. Энэ оны эцэс гэхэд төсвийн орлого нийт 1.5 их наяд төгрөгөөр тасрахаар байгааг Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал хэлсэн. Төсвийн орлого ингэж их хэмжээгээр тасарч байгаад гайхах зүйл бага. Учир нь Засгийн газар 2013 оны төсвийг дэндүү өөдрөг баталсны уршиг одоо гарч байгаа хэрэг. Жишээ нь нүүрсний экспортыг л гэхэд 30.0 сая тоннд хүргэж, улмаар Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулаад, 445.8 тэрбум төгрөгийн орлого олно гэж төсөөлсөн нь өнөөдөр талаар болох нь. Гэтэл Төсвийн тогтвортой байдлын тухай хууль энэ оноос хэрэгжиж байгаа тул төсвийн алдагдлыг ДНБ-ий хоёр хувиас хэтрүүлэхгүй гэсэн хуулийн заалттай. Эдийн засагчдын санааг зовоож буй энэ асуудлын талаар өнөөдөр улстөрчдийн түвшинд ам

нээхээс ч эмээж буй. Өөрөөр хэлбэл, батлаад бүтэн хоёр жил хүлээн байж төсөвт нэлээд сахилга бат авчирна гэсэн итгэл найдвар тээн хэрэгжүүлсэн дээрх хуулийн хамгийн чухал заалт ийнхүү хог дээр үсрэхэд хүрэв. Эдийн засгийн хямрал гэсэн үг сүүлийн үед сонин хэвлэлийн хуудаснаас салахаа больсон. Хямрал болоогүй, болсон гэж яригдаж байгаа ч эдийн засагч, улстөрчдийн олонх нь хямрал хараахан болчихоогүй байна. Харин эдийн засгийн өсөлт саарч, хямралын өмнөх шинж тэмдэг ажиглагдаж байна хэмээн тайлбарлаж буй. Манайх ч гэсэн мэргэжлийн сэтгүүлийн хувьд одоогоор хямрал гэдэг үгнээс зайлсхийж, доргилттой эдийн засаг гэж үзэж байгаа юм. Харин төсөвт бол хэдийнэ хямрал нүүрлэсэн. 2011 онд Оюутолгойг оролцуулахгүйгээр 2.5 тэрбум ам.долларт хүрч байсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өдгөө тав дахин агшчихаад байна. Эдийн засгийн тулгуур нь болсон уул уурхайн салбарт ажлын байртайгаа тэсэж үлдэнэ гэдэг том асуудал болоод буй энэ үед төр, засгаас цаг алдахгүй тодорхой арга хэмжээ авахгүй бол хямрал хаалга тогшоод зогсож байгаа нь яахын аргагүй үнэн. Хэдийгээр ажилгүйдлийн түвшин нэмэгдсэн тухай тоо баримт одоогоор хараахан дуулдахгүй байгаа ч Оюутолгойгоос 2000 орчим хүн ажлын байргүй болсон, жижиг уурхайнууд хаалгаа барьсан, Өмнөговь аймгийн чиглэлд хувийн авиа компаниуд долоо хоногт 10 удаа нислэг хийдэг байсан бол өнөөдөр дөнгөн данган таван удаа нисэж байгаа. Тавантолгой, Цогтцэций чиглэлд уурхайчин залуусыг өдөр бүр зөөдөг байсан хот хоорондын автобусны тоо ч эрс цөөрсөн тухай уул уурхайнхан хэлж байна. Энэ нь Өмнийн говийн цөөнгүй уурхай хаагдсаныг илтгэж буй хэрэг. За тэгээд оны эхэнд нэг төгрөгтэй харьцах ам.долларын ханш 1300 гаруйтай байсан бол өнөөдөр 1600 гараад талийсан, санхүүгийн салбарт нэг л өглөө босоход “Хадгаламж” банкийг төрийн мэдлийн банктай нэгтгэсэн, “Нарантуул” олон улсын худалдааны төвийн хүнсний тасаг шатсанаас хойш чихэр, сахар, будаа гэх мэт өргөн хэрэглээний хүнсний үнэ нэмэгдээд эхэлсэн тухай иргэд ярих болов.

Удтал чимээгүй суусан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга О.Магнай такси компаниудын үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах үүднээс эхний нэг км-ийн үнийг 1500 төгрөгөөс эхэлж, дараагийн км-ээс нь 1000 төгрөгийн үнэ мөрдөнө гэсэн бүтэхгүй мэдэгдэл хийж, олон нийтийг багагүй бухимдуулаад амжив. Энэ мэт зөвхөн уул уурхай гэлтгүй эдийн засгийн бусад салбарт ч иргэдийн санааг зовоосон асуудлууд нүүрлэв. Гэтэл нөгөө талд орон сууцны найман хувийн зээл хэрэгжиж эхэлсэн, Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн үр дүн сайн байгаа, инфляци 2010 оноос хойш анх удаа нэг оронтой тоотой гарлаа гээд чихэнд чимэгтэй мэдээнүүд байгаа нь сайхан л байна. Гэхдээ эдгээр нь иргэдийн итгэлийг баттай олохоосоо илүүтэй цаашаа хэрхэх бол, хэр урт настай хөтөлбөрүүд байх билээ гэсэн болгоомжлолыг байнга төрүүлж буй нь нууц биш. Арга ч үгүй. Угтаа бол иргэдээ орон сууцжуулахаас эхлээд Засгийн газар дангаараа 100 хувь хэрэгжүүлээд явах ёстой хөтөлбөр байтал Төвбанкны санхүүжилттэй хэрэгжиж байгаа нь санаа зовоож, болгоомжлоход хүргэж буй. Түүнчлэн зах зээлийнхээ жамаар үнэ нь тогтох ёстой валютын захад Монголбанкны зохицуулалт байсаар байгаа нь нөхцөл байдал өнөөдийнхөөс хүндэрсэн нөхцөлд Төвбанкны валютын нөөц шавхагдсан байх вий дээ гэсэн болгоомжлол ч эдийн засагчдад буй. Угтаа бол эдийн засагчид Монголбанкийг Засгийн газраас хараат бус бие даасан байдалтай байж гэмээнэ өөрийн үндсэн үүргээ биелүүлэх учиртай гэдгийг байнга учирладаг.

Тэгвэл эдийн засагт эмчилгээ хэрэгтэй болсон энэ цаг үед яах вэ гэсэн асуулт гарч байна. Эдийн засаг эвгүйтэж байгаа хангалттай баримт нотолгоо байхад улстөрчид хямарсан, хямраагүй гээд маргасаар суух уу. Нэгэнт нүүрлэсэн эдийн засгийн доргилт энэ байдлаараа удаан үргэлжилбэл бүтээн байгуулалтын ажлууд, томоохон төслүүд хэвийн явж, цалин, тэтгэвэр тэтгэмжээ ч цагтаа тавьж чадахгүйд хүрэх нь ойлгомжтой.

“Mongolian Economy” сэтгүүл есдүгээр сарын шинэхэн дугаарынхаа гол агуулгыг эдийн засагт үүсээд буй хүндхэн нөхцөл байдал, түүнийг хэрхэн хүндрүүлэхгүйгээр даван туулах арга хэмжээ авах вэ гэдэгт чиглүүллээ. Эдийн засгийн бодит байдлыг хөндөхдөө дотоод, гадаадтай нь харьцуулан жишсэн мэдээлэл хүргэхийг хичээлээ. Түүнчлэн оны төгсгөл гэхэд Монголын эдийн засаг ямар байх талаар залуу эдийн засагч-шинжээчдийн шижигнэсэн багтай “Мандал Ассест менежмент” компанийн урьдчилан таамагласан эдийн засгийн төлөвийг сонирхуулж байна. УИХ-ын гишүүн Р.Амаржаргалын бичсэн “Бид нүүрсний үнээс биш, өөрсдөөсөө болж хямралаа” гэсэн гашуун үнэнийг, гарц шийдэлтэй нь өгүүлсэн нийтлэлийг сэтгүүлийнхээ уншигчдад сонирхуулж байна.

Түүнчлэн эдийн засгийн доргилтод нөлөөлсөн ашигт малтмалын салбарыг хууль эрх зүйн орчин, татвар, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, компанийн нийгмийн хариуцлага гээд тал талаас нь гарц шийдэл эрэлхийлж хөндсөн болно. Түүнчлэн манай сэтгүүлтэй хамтран ажилладаг “Frontier Securities” компанийн гүйцэтгэх захирал Маса Игата Улаанбаатар хотод энэ сард болох томоохон арга хэмжээнүүдийн сонирхолтой зарыг хүргэхийн сацуу хүлээж болох үр дүнгийн талаар ч эдийн засагчийн болоод гадаадын хөрөнгө оруулагчийн нүдээр бичсэн байгаа.


ЦАГ ҮЕ

ТӨСВИЙН ХЯМРАЛ

Б.БАЯРТОГТОХ

Монгол Улсын нийт мөнгөний 40 хувийг эзэлдэг төсвийн орлого энэ оны эцэс гэхэд 1.5 их наяд төгрөгийн алдагдал хүлээхээр байгааг Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал өгүүллээ. Түүний хэлснээр төсөв дээрх хэмжээний алдагдал хүлээсэн тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа зөрчиж байгаа хэрэг юм. Өөрөөр хэлбэл, төсвийн алдагдлыг ДНБ-ий хоёр хувиас хэтрүүлэхгүй гэсэн хуулийн заалт зөвхөн билгэдэл төдий зүйл болно гэсэн үг. Эхний жилдээ хэрэгжиж буй тус хууль гараагаа амжилт муутайхан эхэлж байна. Зөвхөн Төвбанк ч бус Дэлхийн банк, Нээлттэй нийгэм форумаас төсвийн орлого хүндрэх эрсдэл өндөр байгааг өмнө нь сануулж байлаа. Энэ оны эхний найман сарын байдлаар төсвийн алдагдал нэг их наяд төгрөгт хүрээд байгаа аж. Уг нь энэ жилийн төсвийн алдагдлыг ДНБ-ий хоёр хувьд хазаарлаж, 360.9 тэрбум төгрөгийн алдагдалтай баталсан. ИБУИНВУ-ын Велфаст хотын Хатан хааны их сургуулийн эдийн засгийн профессор Г.Рагчаасүрэн “Эдийн засагт Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үзүүлэх нөлөө” гэсэн судалгаандаа “Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн гол зорилго нь Засгийн газрын нийт зардлын өсөлтийг тогтворжуулахад оршдог. Засгийн

Нэгдсэн төсвийн нийт орлого



Эх сурвалж:

газар илүү гарсан аливаа орлогыг Төсвийн тогтворжуулалтын санд хадгалсанаар улсын хадгаламжид дэмжлэг болох боломжтой. Уг сан нь хамгийн багадаа ДНБ-ий таван хувьтай дүйцэхүйц хуримлалтай байх бөгөөд 10 хувиас давсан тохиолдолд инфляци зэрэг тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан Хөгжлийн банк болон Хүний хөгжлийн сангаар дамжуулан эдийн засаг руу хөрөнгө оруулалт хийх боломжтой” хэмээн онцолсон.

Бүсээ чангалах уу...

Дэлхийн банкнаас гаргасан Монголын эдийн засгийн төлөв “2010 онд төсөв ДНБ-ий 0.5 хувьтай тэнцэх хэмжээний багахан ашигтай гарснаас хойш төсвийн тэнцэл үлэмж муудсан” хэмээн тэмдэглэжээ. Төсвийн тэнцэл 2011 онд 4.8 хувийн алдагдалтай болсон бол 2012 онд улам доройтож, долоон хувийн алдагдалтай гарч, сүүлийн 13 жилийн түүхэн дэх хамгийн муу үзүүлэлт болсон. Тэгвэл 2013 оны төсвийн алдагдал дээрх рекордыг эвдэх нь нэгэнт тодорхой боллоо.

Хүлээгдэж буй орлого нэгэнт бүрдэхгүйгээс төсөвт хэмнэлтийн сэтгэлгээг төлөвшүүлэх, үр ашиг багатай урсгал зардлыг танах асуудлыг хөндөөд эхэллээ. Мөн төсөвт хийхээр тусгасан нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг ирэх онд шилжүүлж, дараа оны төсөвт



ачаалал үүрүүлэх бололтой. Түүнчлэн төсвийн хөрөнгө оруулалтад эрэмбэ тогтоож, амин чухал гэсэн үйл ажиллагааг дэмжих аж. Цаашид төсвөөр санхүүжүүлж буй хөрөнгө оруулалтын үр ашигт хяналт тавьж, төсвийн хийдүүлэлт үүсгэхгүй байхыг Засгийн газар анхааралдаа авчээ. Нөгөө талаас хөрөнгө оруулалтын шингээх чадварт үндэслэн төсвөө зохиох, батлах шаардлага үүсч байгаа нь тэр. Төсөвт сууж, энэ онд хэрэгжих учиртай 150 гаруй тендерийг одоогоор зарлаагүй байна. Энэ нь төсвийн орлого гэхээс илүүтэй хөрөнгө оруулалтын зохисгүй төлөвлөлттэй холбоотой аж.

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш Л.Оюун “Баталсан төсөвт тодотгол хийхээс илүүтэй зардлаа хумих, гамнах ухаанд суралцах нь оновчтой. Төсөв бол хууль. Тиймээс тодотгол гэх нэрээр засах нь буруу. Тиймээс алдагдлыг нөхөх хөрөнгө оруулалтыг эрэлхийлэх хэрэгтэй” гэв. Засгийн газар төсөвт тодотгол хийх тохиолдолд уг асуудлыг ирэх намрын чуулганд хэлэлцэх юм. Одоогийн байдлаар төсвийн нөхцөл байдал хүндэрсэн ч Засгийн газар тодотголыг хараахан ярьж эхлээгүй байна. Харин төсөвт хэмнэлт хийх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахыг төрийн албадад үүрэг болгоод буй.

Өсөлт бус зогсолт

УИХ-ын гишүүн Р.Амаржаргал “Ямар ч тооцоогүй төсөв” хэмээн 2013 оны төсвийг цөөн үгээр дүгнэсэн юм. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд төсвийн нийт зарлага 41 хувиар нэмэгдсэн бол орлого 27 хувиар өссөн байдаг. Уул уурхайн эдийн засаг тэлэхийн хэрээр улсын төсвийн орлого хүрээгээ улам тэлсэн юм. Энэ оны төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь 40.2 хувь. Хэт өөдрөг төсөв гэсэн шүүмжийг ч хүртэж байв. Гэтэл төсөв хамраараа газар хатгаж, улсын эдийн засаг уруудах боллоо. Нүүрсний үнэ 30 хүртэлх хувиар унаж, зэсийн итгэлийн индекс нурлаа. Төсвийн орлогын багагүй хувийг бүрдүүлэх төрийн компани “Эрдэнэс Тавантолгой” албан бусаар дампуурлаа зарлаж, “Оюутолгой”-н хөрөнгө оруулалтын гэрээнд онцын өөрчлөлт гарсангүй. Тухайлбал, “Эрдэнэс Тавантолгой”-н нүүрсний олборлолт энэ онд хоёр дахин нэмэгдэнэ гэж төсвийн орлогод тооцсон юм. Түүнчлэн нүүрсний экспорт 30 орчим сая тонн-д хүрч, үүнээс 10 сая тонн нь угаасан нүүрс байхаар “хар зураг” гарсан. Гэсэн ч нүүрсний зах зээл дотоод, гадаад цөөнгүй хүчин зүйлийн нөлөөгөөр зогсонги байдалд оров. Тавантолгойгоос хүүдийлэх 55 тэрбум төгрөгийн орлого замхарч, Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулах замаар төсөвт татах 445.8 тэрбум төгрөг “гол гарлаа”. Энэ онд эдийн засаг 18.5 хувиар өсч, ДНБ-ий хэмжээ 17.6 их наяд төгрөгт хүрэх нь сэрүүн зүүд болов.

Тэнхээ мэднэ

Төсвийн орлого 540.4 тэрбум төгрөгөөр тасарчээ. Экспорт болон төсвийн орлогод зэсийн өмнө гишгэж байсан нүүрснээс 300 гаруй тэрбум төгрөгийн орлого олно гэж төлөвлөсөн ч байдал бишдэв. Уг нь төсөвт зааснаар 28.8 сая тонн нүүрс экспортолно гэж тусгасан ч хагас жилийн байдлаар нийт 6.3 сая тонн нүүрс экспортлоод байна. Нүүрсний экспортын дундаж үнэ өмнөх оныхоос дунджаар 35 хувиар буурсан нь бүр ч нэрмээс болов. Энэ нь төсвийн 50 орчим тэрбум төгрөгийн орлоготой тэнцээд буй. Мөн нэг том гацаа нь Оюутолгойн далд уурхайн хөрөнгө оруулалтад “Рио Тинто” хориг тавьж, эдийн засагт хүлээлт бий болов. “Чингис” бондын хөрөнгөөр төсвийн хөрөнгө оруулалтыг “нүд хуурах” төдий аргацааж буй Засгийн газар мөнгөний эрэлд мордож магадгүй нь. “Төсвийн орлогыг хэт өөдрөг төсөөлж, эдийн засгийнхаа чадамжаас давсан үр ашиг багатай, маш их хэмжээний зарлага үйлдвэрлэж байгаа нь төсвийн бус төрийн хариуцлагын хямрал” гэж “Эдийн засгийн бодлогын хүрээлэн”-гийн захирал А.Жаргалсайхан тайлбарласан юм.

“Их ол, эс бөгөөс бага үр”

Энэ үгийг төр засагтаа даймаар. Энэ оны төсвийн нийт орлогын 91 хувь нь татварын орлого, есөн хувь татварын бус урсгал орлогоос бүрдэхээр байгаа. Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь жил бүр хэлбэлзэх ч сүүлийн арван жилийн хандлага өсөх чиглэлтэй байна. Энэ хугацаанд төсвийн зарлага хамгийн багадаа ДНБ-ий 33


хувь, хамгийн ихдээ 48.5 хувь хүрч байсныг эргэн сануулъя. Өмнө нь эрдэс бүтээгдэхүүний үнийн гэнэтийн савлагаа төсөвт цочрол болж, 2009 онд төсөв уналтад орж байсан билээ. Дэлхийн банкны тайланд “Төсвийн орлого тасарч, зарлага санхүүжилтийг танаж зохицуулах амаргүй шийдвэр гаргах шаардлага үүсэх бөгөөд энэ нь эргээд эдийн засгийг улам хумих болно” хэмээн өгүүлжээ.

Төсөвт эзлэх Засгийн газрын нийт зардлын 65.4 хувь урсгал зардал, 33.4 хувийг хөрөнгийн зардал бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллагын үйл ажиллагааны зардал өндөр байгааг харж болохоор. Мөн Засгийн газрын тусгай сан нэрээр багагүй мөнгө төсвөөс гадагшлуулж буй. Энэ оны төсөвт 23 тусгай сангаар дамжин нэгдсэн төсвийн нийт зарлагын 29 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг орлогоос зарцуулах юм.


А.Жаргалсайхан “Төсвийн орлого тааруу бүрдэж байгаа нөхцөлд төрийн данхайсан бүтцийг аль болох бага зардлаар ажиллуулах хэрэгтэй. Мөн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон олон төрлийн урамшуулал төрөөс үзүүлэх эсэхийг эргэж харах нь оновчтой. Мөн иргэд, аж ахуйн нэгж хуулийн өмнө хүлээсэн татвар төлөх үүргээ шударгаар биелүүлэх учиртай. Улсын эдийн засагт иргэн бүрийн оролцоо чухал” гэлээ. Гэхдээ татвар төлөгчдийн мөнгийг үрэн таран хийж буй төрийнхөнд шүүмжлэлтэй хандаж, ширүүн харц чулуудах эрх иргэдэд бий.

Монгол Улсын нүүрсний орлогоос олох валютын орлого энэ оны эхний найман сарын байдлаар 55, зэсийнх 40 хувиар тус тус буураад байна. Оюутолгойгоос бусад гаднын шууд хөрөнгө оруулалт өнгөрсөн онтой харьцуулахад 49 хувиар багасжээ. 2011 онд Оюутолгойгоос гадна Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалт 2.5 тэрбум ам.долларт хүрсэн байсан. Гэтэл өнөөдөр хөрөнгө оруулалтын дээрх хэмжээ 500 сая ам.доллар буюу тав дахин агшаад байна. Хэмнэлт, бас дахин хэмнэлт хийвээс Монголын Улсын төсөв алзахгүй гэх. Харин олж байгаагаа буруу шингээж, амин чухал хэрэгцээгээ хангаж эс чадваас жинхэнэ хямрах аж. ■

Зэсийн экспортын хэмжээ, үнэ буурсаар байна



Нүүрсний экспортын хэмжээ, үнэ буурсаар байна



БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч байна



Эх сурвалж:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

“ӨМДГҮЙ” ЭДИЙН ЗАСАГ

Э.ТАМИР


Төрийн савласан бодлогын уршгаар Монголын хөрөнгө оруулалтын орчин муудсантай холбоотой хэсэгчилсэн хямрал буюу салбарын уналтууд хэдийнэ ажиглагдаад эхэлжээ. Энэ байдал удаан үргэлжилбэл Монголын эдийн засаг өмдгүй болж магадгүй. ОХУ-ын эдийн засагч Борис Панкиний “Уналт гэдэг бүсээ чангалахыг хэлнэ. Харин хямрал бол өмдгүй болохыг хэлнэ” гэж хэлсэн удаатай.

Хүүхдийн тоглоом биш

Хөрөнгө оруулалтын орчин муудсан гэх дөрвөн үг Монголын эдийн засагт заналхийлээд удаж байна. Өнгөрсөн онд Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль батлаж, Монголыг зорин ирэх хөрөнгө оруулагчдад гэнэтийн бэлэг барьсан. Гэнэтийн бэлгэнд дургүй хөрөнгө оруулагчид Монголд хөрөнгө оруулахаа зогсоож, сонирхсон нэг нь нүүр буруулсан. Тухайлбал, гадаадын шууд хөрөнгө оруулалт энэ оны эхний хагаст өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43 хувиар буурчээ. Гал дээр тос гэдэг шиг Оюутолгойн гэрээг өөрчлөх, Ашигт малтмалын тухай шинэ хууль гаргах зэрэг асуудал яригдаж эхэлсэн нь үрэгсэн хөрөнгө оруулагчдыг зугтахад хүргэчихээд байна. Хэдийгээр Уул уурхайн яам болон Эдийн засгийн хөгжлийн яамнаас “Гадаадын хөрөнгө оруулалт зогсоогүй” гэх боловч уул уурхайн бизнесийн салбарт хүч үзэж байгаа хувийн хэвшлийнхэн хөрөнгө оруулалт зогсчихсон гэдэгтэй санал нэг байна. МІН группын ерөнхийлөгч Д.Жаргалсайхан “Би бизнесийн халуун тогоонд байгаа хүний хувьд хэлэхэд гадаадын хөрөнгө оруулалт зогсчихоод байна. Тухайлбал, манай нэг компани хаалгаа барьж, хоёр компанийн үйл ажиллагаа түр зогсчихоод байгаа. Үүний гол шалтгаан нь нөгөө л хөрөнгө оруулалт буурсантай холбоотой” гэсэн юм.

Хөгжлийг бий болгох хоёр арга байдаг гэдэг. Нэг нь мөнгө зээлэх буюу бонд гаргах. Нөгөө нь хөрөнгө оруулалт татах. Монголын эдийн засгийн өсөлт, бүтээн байгуулалт ид өрнөж байгаа энэ үед санхүүжилтийн хэрэгцээ байгаа нь ойлгомжтой. Манай улсын нэн шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөлд нийт 45-68 тэрбум ам.доллар буюу 95 их наяд төгрөг шаардлагатай гэх судалгаа бий. /Дэлгэрэнгүйг графикаас харна уу/ Энэ их мөнгийг монголчууд дотоодын хөрөнгө оруулагч аль эсвэл Засгийн газрын халааснаас гаргачихаж чадахгүй. Эдгээр ажлын эхний ээлжийн хөрөнгө оруулалтыг Чингис бондоос санхүүжүүлж эхэлсэн. Гэхдээ Чингис бондоос аль нэг төслийг 100 хувь санхүүжүүлэхгүй. “Хүннү коал” компанийн гүйцэтгэх захирал Т.Лхагвадорж “Төрийн зүгээс савчсан бодлого бариад байвал Монголд хөрөнгө оруулалт орж ирэхгүй. Хэдий чанга бодлоготой байлаа ч урт хугацаанд тухайн хууль

Гадаадын шууд хөрөнгө оруулалт



эрх зүйн орчин нь тогтвортой бол хөрөнгө оруулагчид итгэл үзүүлэн хөрөнгөө оруулахад хүрдэг. Гэтэл өнөөдөр хөрөнгө оруулагчдыг “Манай хөрөнгө оруулалтын орчин тааламжтай, хөнгөлөлт үзүүлнэ ороод ир” хэмээн өөрсдөө дууддаг. Харин орж ирээд орд нээхээр нь “Миний юм, улсын өмч” гээд л өмчирхөнө. Тэгээд нөгөө хөрөнгө оруулагчид нь гараад явчихаар өө та нар ямар тоглоом даадаггүй юм бэ, буцаад хүрээд ир, одоо сайхан болгоод өгнө гэдэг. Хүүхдийн тоглоом биш шүү дээ” гэсэн юм.

Хэрвээ байдал энэ мэт удаан үргэлжилбэл олон улсад нэр хүндээ худалдан байж өр тавин хөрөнгө оруулалтыг нь эхлүүлсэн томоохон төслүүд хөрөнгө оруулалтгүй зогсож, бага чулуугаар том чулуу доргионо гэдэг Засгийн газрын мөрөөдөл замхарч болзошгүй. Хэрвээ мөрөөдөл замхарч Монголын томоохон төслүүд мөнгөгүй болоод ирвэл юун эдийн засгийн хөгжил. Энэ оны эхний улиралд 7.2 хувийн өсөлттэй гарсан манай улсын эдийн засаг элгээрээ хэвтэж, гал түлэх тулга ч үгүй, цай чанах тогоо ч үгүй болох үе хаяанд тулжээ. ■

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (салбараар)

/сая ам.доллараар/

Салбарын нэр	2012 06 30	2013 06 30	өөрчлөлт
Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт, газрын тосны салбар	1.271.025.318.1	863.384.068.0	-32.07%
Худалдаа, нийтийн хоол	339.702.150.7	87.376.854.4	-74.28
Банк санхүүгийн	16.858.502.1	970.000.0	-94.25
Инженерийн барилга байгууламж барлгын материалын үйлдвэрлэл	23.097.168.4	1.736.631.6	-92.48
Тээвэр	9.493.190.1	3.614.066.8	-61.93
Аялал жуулчлал	11.698.038.8	175.351.0	-98.50
Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл	330.426.8	123.000.0	-62.78
Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ	745.241.8	60.500.0	-91.88
ХАА, газар тариалан, МАА	229.925.0	40.000.0	-82.60
Бусад	14.496.844.4	2.590.300.0	-82.13
Нийт гадаадын шууд хөрөнгө оруулалт	1.688.133.071.2	960.917.120.7	-43.08

Эх сурвалж: ЭЗХЯ

Хөрөнгө оруулалтын төсөл

/тэрбум ам.доллараар/

Салбар	Мөнгөн дүн
Уул уурхай	12-20
Дэд бүтэц	8-12
Хотын хөгжил	6-8
ХАА	1-2
Аж үйлдвэр	15-20
Байгаль орчин	1-2
Нийгэм	1-2
Санхүүгийн салбар	1-2
Нийт	45-68

Эх сурвалж: ХХБ

Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалт

/сая ам.доллараар/

Улс	2013 оны I улирал Мөнгөн дүн	2013/2012 Өөрчлөлт /хувиар/
БНХАУ	65.2	-47%
Өмнөд Солонгос	13.9	-20%
Канад	25.7	-17%
Хонконг	564.0	+4 %
Япон	10.7	-64%
ОХУ	7.1	
Англи	4.8	-93%
АНУ	83.0	-53%
Европ тив /Англи, ХБНГУ-аас бусад/	4.4	
Австрали	32.2	40%
ХБНГУ	3.6	
Сингапур	28.4	-20%
Бусад	27.9	-87%
Нийт	870.8	-315

Эх сурвалж: Монголбанк

Хөрөнгө санхүүгийн тэнцэл

/сая ам.доллараар/

Үзүүлэлт	1-р улирал		Өөрчлөлт	
	2012	2013	Дүн	Хувь
Хөрөнгө санхүүгийн тэнцэл	1.862.9	475.3	-1.387.6	-74%
А. Хөрөнгийн данс	42.2	24.7	-17.5	-42%
Б. Санхүүгийн данс	1,820.6	450.6	-1,370.1	-75%
а. Шууд хөрөнгө оруулалт	1.263.3	868.1	-395.2	-31%
Гадагш хийсэн	-5.7	-2.7	3.0	-52%
Монгол Улсад орсон	1,269.0	870.8	-398.2	-31%
б. Багцын хөрөнгө оруулалт	582.2	8.0	-574.3	-99%
в. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0.0	0.0	0.0	
г. Бусад хөрөнгө оруулалт	-24.9	-425.5	-400.6	1612%
Үүнээс: Худалдааны зээл	44.7	61.6	16.9	38%
Бэлэн мөнгө харилцах	-527.5	-521.7	5.8	-1%

Эх сурвалж: Монголбанк

ҮЗЭЛ БОДОЛ

БИД НҮҮРСНИЙ ҮНЭЭС БИШ, ӨӨРСДӨӨСӨӨ БОЛЖ ХЯМАРЛАА



Р.АМАРЖАРГАЛ /УИХ-ын гишүүн/

“Тогтворгүй” хэмээх үгээр зөвхөн өнөөгийн валютын ханшийн хөдөлгөөн, эдийн засгийг бүхэлд нь тодорхойлоод зогсохгүй бусад салбарт ч төрийн бодлого ямархүү байгааг илэрхийлжээ.

- *“Тогтворгүй”-эл байдал бараг жил хагас үргэлжилж цаашлаад улам бүр тэлэх хандлагатай байгааг бид анзаарахгүй л байна. Жишээ нь:*
- *Оюутолгой удаа дараа хойшилсон (санаатай санамсаргүй)*
- *Тавантолгой урагшлахгүй байгаа (17 тэрбумын асуудал)*
- *Оюутолгой гүний уурхайн асуудал ойлгомжгүй байгаа*
- *Ямар ч тооцоогүй төсөв*
- *Хий хоосон хүлээлт үүсгэсэн дарга нарын мэдэгдэл, амлалтууд*
- *“Хадгаламж” банкны дампуурал (залгаад хэд ч дампуурах юм билээ бүү мэд) зэрэг нь сэтгэл түгшээж байна.*

Ямар ч болсон Монголын улс төр, эдийн засгийн лидерүүд, бизнесийнхэн дараах цоо шинэ орчин, бодит байдалтай учирлаа.

- Дэлхийн банк эдийн засгийн өсөлтийг 16-аас 13 хувь хүртэл бууруулсан прогноз гаргалаа (өнгөрсөн дөрвөн сард эл дохиог анзаарсангүй)
- Эхний улиралд бодит ДНБ-ий өсөлт ердөө 7.2 хувь байна гэж ОУВС тооцсон.

Нөлөөлсөн гадаад болон дотоод хүчин зүйлс

Гадаад хүчин зүйлийн тухайд Хятадын эдийн засгийн өсөлт саарсан, түүхий эдийн үнэ унасан гэдгээр ам таглах янзтай. Гэвч бодит байдалд дараах нөхцөл үүсээд байна. Үүнд:

- Хятад. Эдийн засгийн өсөлт нь эхний хоёр улиралд буурсан. Гэхдээ манай эдийн засгийг “сүйтгэх” хэмжээнд юу ч болоогүй. Бүх юм л Хятадаас болоод байгаа мэт сурталчилгаа ч үндэслэлгүй юм.
- Манай экспортын бүтээгдэхүүний 80-хувийг бүрдүүлдэг түүхий эдийн үнэ унаж байна гэх юм. Гэхдээ манай эдийн засгийг сүйтгэх хэмжээнд үнэ унаагүй. Зэсийн үнэ л гэхэд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал долоон хувиар л буурчээ. Нүүрсний үнэ 20 гаруй хувиар хямдарсан ч Монгол Улсын төсөвт халтай болох хэмжээнд хүрээгүй. Харин бид угаасан нүүрсний үнийг нэг тонныг нь 131.50, коксжсон бол 80.20, хүрэн бол 65.50 ам.доллар зэргээр төсөвтөө хэт өндөр дүнгээр өөрсдөө л тусгасан юм. Хамгийн хүнд цохилт бол үнэ гэхээсээ илүү олборлолт болоод байна. Цагтаа импортын 80 хувийг бүрдүүлж байсан нүүрс одоо ердөө л 28 хувь хүрэхгүй байна. Энэхүү шатдаг металлын экспортоос орох орлого бараг 50 хувь буурсан болоод л бид сандраад байна.
- Дотоод хүчин зүйл гэхээр л өмнөх Засгийн газар бөөн өр тавьсан мэтээр ярьж буй нь шинэ зүйл биш л дээ. 2000 онд Ч.Улаан бас нэг иймэрхүү юм яриад, одоо яригдаад байгаа төвлөрлийг сааруулах орон нутгийн санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх гэх мэт нэн чухал шинэтгэлийн чанартай ажлыг 12-13 жилээр таслан зогсоож чадсан юм.
- Дотоод гэдэгт гадаадын хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулагчдыг үргэсэн харалган үйлдлүүдийг нэрлэнэ. Энэ оны эхний таван сарын байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалт 1.21 тэрбум ам.доллар болжээ. Өөрөөр хэлбэл, өмнөх оны мөн үеийнхээсээ 17.7 хувиар буурсан хэрэг. 2011 онд энэ дүн дөрвөн млрд ам.доллар давж байсан юм. Стратегийн хөрөнгө оруулалтын тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн шинэ төсөл гээд ямар ч утгагүй хэлэлцүүлэг гэх мэт Ерөнхийлөгч, УИХ-ын үйлдлүүд нь хөрөнгө оруулагчдыг үргээхээс өөр ид шидийг үзүүлсэнгүй.
- Дотоодын бизнесээ дэмжиж буй мэт тогтворжуулах хөтөлбөр »

гэгчид хоёр их наяд төгрөг цацжээ. Гэвч энэ нь цаанаа: Мөнгөний тэлсэн бодлого, явдаггүй, өсдөггүй экспорт зэрэг нь өнгөрсөн сард худалдааны алдагдлыг 1202.49 сая ам.долларт хүргэв.

1. Ялгаварлан гадуурхсан шинжтэй

2. Үр дүн нь туйлын эргэлзээтэй

3. Сонгуульд зориулсан – 0.23=2 их наяд төгрөг

• Зарим шинжээч төсвийн алдагдал 7-10 хувьд хүрсэн, төсвийн тогтворгүй байдал улам гүнзгийрнэ хэмээн үзэж байгаа. Бид чинь энэ оны төсвийг боловсруулахдаа орлогоо эдийн засгийн өсөлтөөсөө бараг хоёр дахин илүү төлөвлөсөн ухаантнууд шүү дээ. Ийм их хурал, Засгийн газарт итгэх итгэл саарна уу гэхээс нэмэгдэх учиргүй.

Хамгийн том асуудал итгэл даах. Тэгвэл Монголд итгэх үү, үгүй юү?

• Засгийн газар, яаманд итгэх итгэл алга гэж хөрөнгө оруулагчид дуугарч байна. Лицензийг нь хураах, буцаах, хууль бусаар олгоод өөрсдөө булталд алга болох ердийн үзэгдэл болоод байна. Тухайлбал, АМГ-ын дарга асан Д.Батхуягийн хэрэг.

• Эрчим хүчний төслүүд зогссон. Энэ өвөл Улаанбаатарынхан харанхуй, хөлдүү өвөлжихдөө хүрвэл гайхах зүйлгүй. V цахилгаан станцын тухай 20 жил ярилаа. Шийдэж чаддаггүй ээ. Яагаад гэж үү, техник технологийн шардлага хангасан нь том даргын сэтгэлд хүрэхгүй, том даргын зөвшөөрсөн нь нь техникийн шаардлага хангахгүй. Түүнийг нь залгаад эцэс төгсгөлгүй тендер.

• Хөгжлийн банкаар дамжуулан мөнгө гаргаж тараасан Тавантолгойн шуугиан. Өнгөрсөн онд Хятадад нүүрс нийлүүлэлтээр тэргүүлсэн Монгол Улс энэ жил эхний 6-д ч багтаагүй шүү дээ.

• “Эрдэнэс Тавантолгой” компанийн үйл ажиллагааны хөрөнгийг бүрдүүлэх зорилтоор мөнгө босгох гэсэн бүтэлгүй оролдлого

• Монголчуудыг 50-100 жил тэжээх учиртай Тавантолгой дампуурсан тухай Ерөнхий сайдын сүржин мэдэгдэл

• Тоо нь алдарсан тусгай сангууд

• Төсвөөс гадуур эргэлдэж буй мөнгө, ямар ч хяналтгүй дансууд


• Валютын нөөц арвижсан ч тэр хэрээр улсын өрийг нэмсэн, хаана юунд зарцуулагдаж байгааг ганц хүнээс өөр хэн ч мэдэхгүй Чингис нэртэй өрийн бичиг. Товчхондоо, гунигт дүр төрх. Энэ бонд анх 4.125 хувийн хүүтэй, таван жилийн хугацаатай байсан бол өнөөдөр 92.837 центээр арилжаалагдаж зургаан хувь болсон байна. 10 жилийн өрийн бичиг нь бүүр аймаар. 87.245 центээр арилжаалагдаж хүү нь 5.125 ээс долоон хувьд хүрч өссөн. Ингэснээр Монголын Засгийн газарт итгэж бондыг нь худалдан авсан хөрөнгө оруулагчдыг их хэмжээний алдагдалд түлхэж орхилоо. Хариуд нь тэд бидэнд талархахгүй нь ойлгомжтой. Энэ их өрийг Ч.Улаан, Н.Батбаяр сайд нар төлөхгүй, иргэдийн нуруунд үрүүлэх нь харин ойлгомжтой.

Санхүүгийн байдал ямар байна вэ?

• Асуудлыг бүр хүндрүүлэх гэсэн юм шиг, эсвэл Монголын санхүүгийн системд итгэх аргагүй шүү гэж байгаа юм шиг гэнэт гарч ирсэн “Хадгаламж” банкны дампуурал.

• Монголын банк санхүүгийн систем тогтвортой эсэхэд гадаадын, бас дотоодын ч хөрөнгө оруулагчид эргэлзэж эхлэв.

• Монголд компанийн\банкны засаглал гэж юм байна уу гэдэгт эргэлзээ төрж байна. Чанаргүй зээл нь өөрийн хөрөнгөөс хэд дахин даваад,



эзэд нь ямар ч хяналтгүй аашилж байхад компанийн засаглалын тухай хууль хаана яаж үйлчилж байсан юм бол. Энд улс төрийн хүчин зүйл үйлчлээд л байна гэж би таамаглаж байна.

- Жил болгон нэг банк залгидаг Төвбанктай болов. "Хадгаламж" 2013, "Зоос" 2009, "Анод" 2008 онд гээд л жагсаалт үргэлжилж байна.
- Валютын ханш 1600 давж донсолгоон үүсгэв. Засгийн газар нь үнэ ханш Монголбанкны асуудал хэмээн булталж, Монголбанк нь бодит салбарын урагшгүй байдлаас санхүүгийн "ханиад" сэдрэв хэмээн Засгийн газар руугаа чихэв.
- Сандраад нөөцөө гөвөх аюул. Гэтэл хэдэн сарын дараа байдал хүндэрвэл нөөцгүй сууж байх уу, байдал муудахгүй гэдгийг УИХ, Засгийн газар баталж чадахгүй шүү дээ.
- Өнгөрсөн тавдугаар сард Moody's "Голомт", ХААН, ХХБ, "Хас" банкны рейтингийг Ba3-аас B1 хүртэл буулгасан. Харин дээдчүүл нь үүнийг мэдсэн ч мэдээгүй юм шиг царай гаргаад өнгөрсөн. Гэтэл тэдний дүгнэлтэд "a bank's rating ultimately cannot be completely insulated from the credit quality of the government's creditworthiness." "Mongolia's economy is transforming because of the rapid development of its natural resources industries. While this is having a strongly positive effect on the economy's growth rates, it does create the risk of an overheating of the economy, inflationary pressure, and, ultimately, the risk that boom could be followed by bust," гэсэн үг өгүүлбэр байсан. Энэ мэт дүгнэлтийг хэн анзаарч, анхаарч ажиллах ёстой юм бэ.

"Хадгаламж"-ийг ганц шөнийн дотор "цэвэрхэн шийдсэн" гээд байгаа ч манай санхүүгийн систем, түүний Төвбанкинд итгэх итгэл дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын дунд эргэлзээ түрүүлсэн нь үнэн. Хар жагсаалтад тэмдэглэгдсэн дараагийнх нь хэн бол гэсэн хүлээлт, айдас ч байгаа. Энэ "цэвэрхэн шийдсэн"-ий төлбөрийг иргэд л хариуцна. Төрийн банкны дүрмийн санг 85 тэрбумаар нэмэгдүүлэх Засгийн газрын шийдвэр нь дөнгөж "цэцэг нь, жимс нь еще болоогүй байна" л гэж ойлгох хэрэгтэй.

Эдийн засгийн өсөлт удаашран унаж эхэлбэл манай банкууд дийлэхгүй шүү.

Нийт 7-8 тэрбум ам.долларын активтай банкны салбарт компанийн засаглалыг бэхжүүлэх, асуудал байвал хугацаа алдахгүй, улс төрийн шахалт дарамтад орж харзнахгүй шууд л шийдээд явахгүй бол хэцүүднэ. Уг нь 90-ээд оны эхэн болон дунд үеийн давалгаалсан банкны хямрал, дамуурал нэлээн сургамж өгч, нэг хэсэг овоо гайгүй явсан юмсан. Одоо мартагдаж эхэлсэн бололтой.

Монголын эдийн засгийг бүхэлд нь сүйтгэж буй үйлдэл нь Оюутолгой тойрсон шуугиан дуулиан юм. Сайд, дарга нар нь өдөр алсахгүй эсрэг тэсрэг мэдэгдэл хийх юм.

Төсөлд мөнгө босгох, тасралтгүй үйл ажиллагаа явуулах нь чадалтай, хөгжилтэй улсад ч бэрх даваа. Гэтэл дөнгөж эхэлж буй бид бусдын ажлыг санаатай, санамсаргүй тасалдуулан буй нь буруу.

Зардал нь өсөхөөр манайд ногдох өр нэмэгдэх гэх мэт нь ойлгомжтой. Гэхдээ саалийн үнээгээ "төхөөрч" болохгүй шүү дээ. ОТ Phase II эхлэх ёстой бөгөөд ингэж байж л Оюутолгой манай эдийн засгийн 30 хувийн өсөлтөд хүргэх зорилт хэрэгжинэ.

Хэрэлдэж боож хааж байгаад хэдэн ам.доллар төсөвт оруулах бололцоо бий. Гэхдээ хэдэн модны цаана ой байгаа. Монголчуудынхаа төлөө стратегийн том төсөл хэрэгжүүлэх чадвартай гэдгээ харуулах нь чухал юм.

Тавантолгой ялгаагүй монголчуудын ухаан, сүр хүчийг харуулах төсөл шүү дээ.

Цаашид яах вэ

Монголын Засгийн газар итгэл даах чадвартай гэдгийг хоёр уншигдахааргүй харуулж, итгүүлэх хэрэгтэй.

- Төсвийн сахилгыг хангах
- ОТ Phase II-ийг яаралтай явуулах
- 1.5 тэрбум ам.долларын өрийн бичгийн үр ашгийг хангаж чадсанаа нотлох
- Компанийн болоод банкны засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах замаар санхүүгийн системийг эрүүлжүүлэх
- Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд яаралтай өөрчлөлт хийх. Ингэхдээ цаг үеийн зорилтыг хангахуйц байх учиртай.
- Төрийн удирдлагын механизмд гүнзгий, Үндсэн хуулийн хэмжээний өөрчлөлт хийх цаг болсон. ■

СЭТГҮҮЛЧ-ШИНЖЭЭЧ АЖИЛД АВНА

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

-Эдийн засагч мэргэжилтэй
-Дүн шинжилгээ, сувалгаа хийх чадвартай
-Мэргэжлээрээ ажилласан туршлагатай
-Нийтлэл бичих сонирхолтой
-Англи хэлний өндөр мэдлэгтэй байх

ҮНДСЭН ҮҮРЭГ:

-Эдийн засгийн мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ, судалгаа хийж, нийтлэл бичих

Утас: 7011-5476, 94016797

web:www.mongolianeconomy.mn
e-mail: info@mongolianeconomy.mn

***"Mongolian Economy"* сэтгүүлийн редакци**

ЕРТӨНЦ

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

Р.ГАНТУЛГА

“Deloitte” судалгааны байгууллагын таамаг

“Deloitte” судалгааны байгууллагын эдийн засагчид АНУ, БНХАУ, ОХУ, Япон, Евробүс, Англи, Энэтхэг, Бразил зэрэг орны эдийн засаг энэ оны гуравдугаар улиралд ямар байх талаар өөрсдийн таамгийг дэвшүүлжээ.

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн хурд ерөнхийдөө тааруухан байгаа бөгөөд Европын хувьд хямралаас дөнгөж гараад байгаа талаар сүүлийн үед мэдээлэх болсон. АНУ-ын эдийн засгийн өсөлт тооцоолсноос харьцангуй доогуур, харин хөгжиж буй голлох орнуудын эдийн засгийн өсөлт удаашралтай байна. Үүний зэрэгцээ дэлхийн санхүүгийн зах зээл эмзэг, тогтворгүй байгаад АНУ-ын мөнгөний бодлогод гарах гэж буй өөрчлөлт, Японы шинэ бодлого, БНХАУ-ын банкны салбарын тогтворгүй байдал зэрэг нөлөөлж буй.

АНУ: Энэ жилийн сүүлийн хагаст тус улсын эдийн засгийн өсөлтийн хурд тааруухан байх бөгөөд энэ нь ирэх онд илүү сайн үзүүлэлттэй байхын үндэс байж болох талтай. Сүүлийн үед тус улсад орон сууцын үнэ огцом нэмэгдэх болжээ.

Евробүс: Европын Төвбанкны бодлогын нөлөөгөөр Европын санхүүгийн ихэнх зах зээл сайжирч буй шинж тэмдэг байгаа ч Европын эдийн засаг хямралын “шаварт” суусан хэвээр байх бололтой. Экспортоос



хамааралтай Европын эдийн засгийн хувьд тогтвортой өсөлтийг цаашид бий болгохын тулд эрэлтийн өөр эх үүсвэр хайх, ялангуяа шинээр гарч ирж буй зах зээл рүү хандах нь амин чухал болоод буй. Европын эдийн засгийн сэргэлтэд нөлөөлөх гол хүчин зүйл бол евробүсийн ДНБ-д хамгийн их хувийг эзэлдэг хэрэглэгчийн зан төлөв аж. Европын хэрэглэгчид сүүлийн таван жил гаруйн хугацаанд санхүүгийн, евробүсийн, эдийн засгийн гэсэн гурван том хямралаас үүдсэн эдийн засгийн хүндхэн нөхцөл байдалтай тулгараад байгаа билээ.

Япон: Ерөнхий сайд Шинзо Абэгийн бодлого буюу “Абэномикс” нь тус улсын эдийн засаг болон санхүүгийн орчинд огцом өсөлтийг авчирч буй. Өдгөө эдийн засгийн гүйцэтгэлээ сайжруулж буй нь богино хугацаанд хэрэгжих боломжтой аж. Учир нь хөрөнгийн үнийн өөлчлөлт, бизнесийг нэмэгдүүлж, хэрэглэгчдийн итгэлийг сэргээх зэрэг нь тус улсын эдийн засгийг хөдөлгөгч гол хүч юм. Эдийн засгаа урт хугацаанд сайжруулахын тулд эдийн засгийн жинхэнэ өөрчлөлт хийх шаардлагатай бөгөөд ингэхийн тулд улс төрийн буй тодорхойгүй байдлаа шийдвэрлэх хэрэгтэй аж.

Их Британи: Энэ оны сүүлийн хагаст тус улсын эдийн засаг дунд зэргийн хурдтай, харин ирэх онд нэлээд өсөх хандлагатай байгаа аж. Гэхдээ тус улсын хувьд 2015 он хүртэл дундаж өсөлтийн хэмээс гавихгүй бололтой.

Энэтхэг: Тус улсын эдийн засаг таамаглаж байснаас доогуур өсөлттэй байгаа боловч Энэтхэгийн Засгийн газрын хувьд эдийн засагтаа тулгараад буй санхүү, мөнгөний бодлогын асуудлыг шийдвэрлэхэд хангалттай

нөөц, боломж байхгүй байгаа гэж үзэж байна.

Бразил: Эдийн засаг нь хамгийн хурдацтай өсч буй орнуудын нэг бөгөөд өдгөө эдийн засгаа өсгөх гэж байдгаараа чармайж байна. Хувийн хэрэглээ болон экспортын эрэлт буурсан, бүтэц, зохион байгуулалтын асуудал зэрэг нь Бразилийн эдийн засгийн гүйцэтгэлд саад учруулж буй. Мөн тус улсад өнгөрсөн зургадугаар сард болсон олон нийтийн эсэргүүцэл тодорхой хэмжээний сорилт үүсгээд байгаа аж.

Эх сурвалж: www.deloitte.wsj.com

БНХАУ – Эдийн засгаа сайжруулахын тулд авч буй арга хэмжээ

HSBC банкны судалгаагаар БНХАУ-ын аж үйлдвэрийн салбар өнгөрсөн сард дахин сэргэжээ. Тус улсын захиалгын индекс (Purchasing Managers' Index – PMI) өнгөрсөн долоодугаар сард 47.7 оноотой байсан бол өнгөрсөн сард 50.1 болж өссөн байна. Энэхүү индекс нь эдийн засгийн эрүүл мэндийг хэмждэг гол хэмжүүр бөгөөд тус улсын хувьд сүүлийн дөрвөн сарын хугацаанд анх удаа 50-иас дээш оноо авсан нь энэ аж. БНХАУ он гарснаас хойш уналттай байгаа эдийн засгийн өсөлтөө сэргээх үүднээс тодорхой арга хэмжээ авсаар иржээ. Үүнд, нэмүү өртгийн албан татварыг тэглэх, сард 20 мянган юаниас доош орлоготой жижиг бизнес эрхлэгчдийг орлогын албан татвараас чөлөөлөх зэрэг арга хэмжээ авчээ. Дээрхийг хэрэгжүүлснээр зургаан сая орчим жижиг хувийн хэвшилд үр өгөөжөө өгч, олон сая хүнийг ажлын байраар хангаж, ашиг, орлогыг нь нэмэгдүүлнэ хэмээн БНХАУ-ын Засгийн газар мэдэгджээ. Үүний зэрэгцээ гаалийн бүрдүүлэлтийн журмыг хөнгөвчлөх, үйл ажиллагааны хураамжийг бүрмөсөн чөлөөлж, жижиг, дунд хувийн хэвшлийнхний экспортын үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа аж.

Эх сурвалж: www.bbc.co.uk

Тэгвэл ОХУ ....

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин дэд бүтэц, тэр дундаа транс-Сибирийн төмөр замын ажилд олон тэрбум ам.доллар зарцуулахаа өнгөрсөн зургадугаар сард албан ёсоор мэдэгдэж байсан. Уг төмөр замыг Ази, Европыг холбосон чухал ач холбогдолтой болгох тал дээр дорвитой ажил хийхээр болжээ. Тус улс Европын байгалийн шингэрүүлсэн хийн гол нийлүүлэгч байсан боловч, нэг талаар өрсөлдөгч гарч ирсэн, нөгөө талаар эрчим хүчний хандлага өөрчлөгдсөн зэргээс Европын зах зээл муудаж, улмаар ОХУ-ын хувьд БНХАУ зэрэг гуравдагч зах зээлийг эрэлхийлэх болсон. Энэ байдал цаашид үргэлжилбэл ОХУ-ын хамгийн хүчирхэг газрын тосны компани болох "Газпром" байгалийн шингэрүүлсэн хийн экспортод тэргүүлэх байр сууриа ч алдах магадлалтай юм. Ерөнхийлөгч Путин Оросын бизнесийн орчинг сайжруулж, зогсонги байдалд орсон хөрөнгө оруулалтыг сэргээхэд чиглэсэн дорвитой алхмууд хийхээ мөн мэдэгджээ.

"ОХУ голлох экспортын бүтээгдэхүүний үнэ удаан хугацаанд тогтворгүй, хүндэн нөхцөл байдалтай байсаар ирсэн бөгөөд энэ асуудлыг цаашид бүрэн шийдвэрлэнэ" хэмээн Путин хэлсэн байна.

"Роснефть" төрийн өмчит компани БНХАУ руу 360 сая тонн газрын тос нийлүүлэх 25 жилийн хугацаатай 270 тэрбум ам.долларын үнэлгээтэй гэрээ байгуулжээ. Мөн тус улсын Засгийн газраас "Новатек" газрын тос үйлдвэрлэгч хувийн компанид Хятадтай 20 тэрбум тонн байгалийн шингэрүүлсэн хий нийлүүлэх гэрээ байгуулах зөвшөөрөл олгоод байгаа аж. Энэ нь Ерөнхийлөгч Путиний байгалийн шингэрүүлсэн хийгээ "либералчилах" сонирхолтой байгааг батлан харуулсан хэрэг болжээ.

ОХУ Үндэсний баялгийн сангаасаа 13.7 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг дэд бүтцийн гурван томоохон төсөлд хийхээр төлөвлөж буй. Эдгээр нь Москва – Казаныг холбосон хурдны зам барих, Москва хотыг тойрсон тойрог замуудын гадуур шинээр тойрог автозам барих, мөн транс-Сибирийн төмөр замыг шинэчлэх гэсэн төслүүд юм. Үүнээс гадна жижиг хувийн хэвшлийнхэнд зориулсан зээлийн хөтөлбөрийг дэмжихээр зорьж буй. Хөтөлбөрийн хүрээнд жижиг бизнес эрхлэгчдийг татвараас чөлөөлөх бөгөөд зээл авах үйл явцыг хөнгөвчлөх аж.

Түүнчлэн тус улсын Төвбанк зээл авах боломжийг улам нэмэгдүүлэх, арилжааны банкуудын сангийн зардлыг бууруулахад чиглэсэн дунд хугацааны дахин санхүүжилт хийх шинэ механизм боловсруулах зэрэг арга хэмжээг аль хэдийнэ аваад эхэлжээ.

Тус улсын баялгийн сан нийт 87 тэрбум ам.долларааар хэмжигдэх бөгөөд үүнээс тэн хагасыг нь дэд бүтцийн хөрөнгө оруулалтад зарцуулах боломжтой гэж үзэж буй. Бүх төсөл болон хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх бөгөөд ОХУ-ын Засгийн газар хамтарсан хөрөнгө оруулагч, мөн батлан даагч гэсэн үүргийг давхар хүлээх аж. Гэхдээ зарим санхүүжилтийн асуудал эцсийн байдлаар хараахан шийдэгдээгүй байгаа бөгөөд ирэх арванхоёрдугаар сард шийдвэрлэнэ хэмээн ОХУ-ын хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд мэдээлсэн байна.

ОХУ-ын Төвбанкны дэд ерөнхийлөгч асан, өдгөө Эдийн засгийн сайд Алексей Валентинович Улюкаев тус улсын эдийн засгийн гүйцэтгэл тааруухан үзүүлэлттэй байгаа учраас эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн санхүү, мөнгөний бодлогын хэрэгжилтийг дэмжиж буйгаа илэрхийлжээ.

Москвагийн брокерийн "Атон" компанийн ТУЗ-ын хараат бус гишүүн Берни Сукер "Таваарын ханш нэмэгдэж л аз таарахгүй юм бол, нөгөө талаас улс төрд хэрэгтэй өөрчлөлтийг нь хийгээгүй цагт ОХУ-ын эдийн засаг хурдацтай өсөх боломжгүй" гэжээ. Тэрбээр тус улсад тулгараад буй хамгийн гол асуудал бол эдийн засагтаа биш, харин улс төрийн зогсонги байдалд оршиж буй гэж үзэж байгаа нэгэн.

Эх сурвалж: www.ft.com, www.reuters.com

Олон улсын валютын сангийн таамаг

Олон улсын валютын сан (ОУВС) энэ онд дэлхийн эдийн засгийн өсөлт өнгөрсөн оны түвшинтэй адил буюу гурван хувь байна хэмээн таамаглаж байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт өнгөрсөн оны эхний хагаст 2.5 хувь байсан бол энэ оны эхний улиралд ялимгүй өссөн хандлагатай байгаад үндэслэн дээрх таамгийг дэвшүүлжээ. Дэлхийн эдийн засгийн гүйцэтгэл төдийлэн сайнгүй байсанд нөлөөлсөн гурван хүчин зүйлийг өмнө нь дурдсан. Харин Японы эдийн засгийн өсөлт харьцангуй сайн байсанд тус улсын хэрэглээ, цэвэр экспортын огцом өсөлт зэрэг голлон нөлөөлжээ. Түүнчлэн тус улсын Засгийн газар экспортоо сайжруулахын тулд өнгөрсөн оны сүүл үеэс иенийн ханшаа 20 хувиар бууруулж, мөнгөний зах зээлдээ иенийн нийлүүлэлт хийсэн байна.

АНУ-ын эдийн засгийн өсөлт энэ онд 1.75 хувь, ирэх онд 2.75 хувь, Японы эдийн засгийн өсөлт энэ онд хоёр хувь, ирэх онд 1.25 хувь, харин евробүсийн хувьд энэ онд хямралаас гарах шинжгүй бөгөөд -0.5 хувь, ирэх онд өсөлтийн түвшинд нэг хувьд ч хүрэхгүй байх аж. Ийнхүү эдийн засгийн өсөлт тааруухан байх шалтгааныг ОУВС дээр дурдсан хүчин зүйлээс гадна болон зарим голлох бүс нутагт бодлогын хэрэгжилт хойшлогдох төлөвтэй байгаа, мөн энэ оны эдийн засгийн сэргэлт удаашралтай байгаатай холбон тайлбарлаж байгаа аж. Эдийн засгийн өсөлтийн өнөөгийн байдал ямар байсан болон хэтийн төлөв хэрхэх талаар дэвшүүлсэн таамгийг доорх хүснэгтээс харна уу.

Шинээр гарч ирж буй зах зээл, хөгжиж буй орнуудын хувьд энэ онд өсөлтийн түвшин таван хувь, ирэх онд 5.5 хувь байна хэмээн ОУВС таамаглаж буй бөгөөд энэ нь өнгөрсөн дөрөвдүгээр сард тус сангаас гаргасан “Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв”-т тусгасан таамгаас харьцангуй доогуур үзүүлэлт болж байна. Үүний улмаас бүх бүс нутагт эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөв харьцангуй тааруухан үзүүлэлттэй байх магадлалтай. Тухайлбал, BRICS –ийн орнуудын өсөлтийг 0.25-0.75 хувиар доош бууруулсан бөгөөд БНХАУ-ын эдийн засаг 2013-2014 онд 7.75 хувийн өсөлттэй байх аж. Өмнөд Африк, Нигери улсын хувьд дотоодын эдийн засгийн асуудлууд, нөгөө талаас гаднын эрэлт сул байгаатай холбоотойгоор эдийн засгийн өсөлт нь ерөнхийдөө тааруухан байх төлөвтэй гэжээ.

Нэгтгээд хэлэхэд, энэ онд дэлхийн эдийн засгийн өсөлт дунджаар гурван хувь байх бол ирэх онд 3.75 хувь болж нэмэгдэх хандлагатай байна. Доошоо чиглэсэн хуучин, шинэ эрсдлүүд хэтийн төлөвт давамгайлж байгаа бөгөөд хөгжингүй орнуудын хувьд санхүүгийн эрсдэл (tail risk) багассан ч цаашид боломжит эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд нэмэлт арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай юм. Иймээс ч АНУ өрийн босгоо үе үе нэмэгдүүлэх болж, евробүс санхүүгийн хүнд нөхцлөөс урьдчилан сэргийлэхийн тулд “do what it takes” арга хэмжээ авах болсон юм.

Эх сурвалж: www.imf.org

Орнууд	Таамаг				Өмнөх болон одоогийн таамгийн зөрүү		IV –IV улиралд		
	2011	2012	2013	2014	2013	2014	2012	2013	2014
Дэлхийн өсөлт	3.9	3.1	3.1	3.8	–0.2	–0.2	2.6	3.5	3.7
Хөгжилтэй орнууд 1	1.7	1.2	1.2	2.1	–0.1	–0.2	0.7	1.8	2.2
АНУ	1.8	2.2	1.7	2.7	–0.2	–0.2	1.7	2.0	3.1
Европын орнууд	1.5	–0.6	–0.6	0.9	–0.2	–0.1	–1.0	0.3	1.1
Герман	3.1	0.9	0.3	1.3	–0.3	–0.1	0.3	1.1	1.2
Франц	2.0	0.0	–0.2	0.8	–0.1	0.0	–0.3	0.5	0.6
Итали	0.4	–2.4	–1.8	0.7	–0.3	0.2	–2.8	–0.9	1.4
Испани	0.4	–1.4	–1.6	0.0	0.0	–0.7	–1.9	–0.7	0.0
Япон	–0.6	1.9	2.0	1.2	0.5	–0.3	0.4	3.5	0.2
Их Британи	1.0	0.3	0.9	1.5	0.3	0.0	0.2	1.1	1.7
Канад	2.5	1.7	1.7	2.2	0.2	–0.2	1.0	2.0	2.4
Хөгжилтэй бусад орон 2	3.3	1.8	2.3	3.3	–0.1	–0.1	2.0	3.0	3.2
Хөгжиж буй орнууд 3	6.2	4.9	5.0	5.4	–0.3	–0.3	5.0	5.6	5.6
Төв, Зүүн европын орнууд	5.4	1.4	2.2	2.8	0.0	0.0	0.8	3.6	2.5
Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл	4.8	3.4	2.8	3.6	–0.6	–0.4	1.3	3.3	2.9
ОХУ	4.3	3.4	2.5	3.3	–0.9	–0.5	2.0	3.6	2.5
ОХУ-аас бусад орон	6.1	3.3	3.5	4.3	0.0	–0.3	. . .	. . .	. . .
Хөгжиж буй орнууд	7.8	6.5	6.9	7.0	–0.3	–0.3	6.9	7.0	7.0
БНХАУ	9.3	7.8	7.8	7.7	–0.3	–0.6	7.9	7.9	7.6
Энэтхэг	6.3	3.2	5.6	6.3	–0.2	–0.1	3.0	6.0	6.6
ASEAN-5	4.5	6.1	5.6	5.7	–0.3	0.2	9.1	5.5	5.1
Өмнөд Америк, Карибийн тэнгис	4.6	3.0	3.0	3.4	–0.4	–0.5	2.8	2.9	3.5
Бразил	2.7	0.9	2.5	3.2	–0.5	–0.8	1.4	2.6	3.5
Мексик	3.9	3.9	2.9	3.2	–0.5	–0.2	3.3	3.6	2.4
Ойрхи Дорнод, Хойд Америк, Афганистан, Пакистан	3.9	4.4	3.1	3.7	–0.1	0.0	. . .	. . .	. . .
Хойд Африк	5.4	4.9	5.1	5.9	–0.4	–0.2	. . .	. . .	. . .
Өмнөд Африк	3.5	2.5	2.0	2.9	–0.8	–0.4	2.3	2.3	3.0
Санамж бичиг									
Европын холбоо	1.7	–0.2	–0.1	1.2	–0.1	–0.1	–0.6	0.7	1.3
Ойрхи Дорнод, Хойд Америк	4.0	4.5	3.0	3.7	–0.1	0.1	. . .	. . .	. . .
Валютын зах зээлийн ханшид суурилсан дэлхийн өсөлт	2.9	2.4	2.4	3.2	–0.1	–0.2	1.8	2.8	3.1

СУДАЛГАА

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2013 ОНЫ ТӨЛӨВ

"Мандал Ассет менежмент" компаниас энэ оны эхний хоёр улиралд Монголын макро эдийн засгийн эрүүл мэнд ямар түвшинд байсныг голлох зургаан үзүүлэлтээр үзүүлж, нэгээс долоо хүртэлх оноо (1–хамгийн тааруухан, 7–хамгийн сайн)-гоор харуулсныг сонирхуулж байна.

Энэ оны эхний хагаст Монголын эдийн засаг үйл явдал, өөрчлөлт, өөдрөг үзлээр дүүрэн байв. Гэхдээ эдгээр нь үргэлж зөв зүйтэй, үндэслэлтэй, бодитой байсан гэж хэлэхэд хэцүү. Шаардлагатай зарим арга хэмжээ авахгүй бол эдийн засгийн суурь үзүүлэлтүүд оны эцэст тааруухан гарч болзошгүй байна. Үүний зэрэгцээ, өмнө нь Монгол Улс хүнд байдлаас харьцангуй богино хугацаанд гарч чадсаныг онцлох нь зүйтэй болов уу.

2013 оны эхний хагаст дэлхийн эдийн засгийн орчин ямар байв?

Дэлхийн эдийн засгийн өсөлт энэ оны эхний хагаст төдийлэн сайжрахгүй хэмээн эдийн засагчид таамаглаж байсан нь үнэний хувьтай байв. Эхний хагасын байдлаар санхүүгийн байгууллагууд оны эцэс гэхэд эдийн засгийн өсөлт ямар байх талаар өөрсдийн таамгаа ялимгүй бууруулж тооцсон бөгөөд дэлхийн эдийн засгийн өсөлтийг дунджаар 2.6 хувь, АНУ-ыг хоёр хувь, Евробүсийг -0.1 хувь, БНХАУ-ыг 7.6 хувь гэж тус тус таамаглажээ.

Нэгдүгээрт, хөгжиж буй голлох орнуудын эдийн засгийн өсөлт таамаглаж байснаас харьцангуй доогуур үзүүлэлтэй байсан. Үүнд хэд хэдэн шалтгаан байсан бөгөөд нөлөөлөл нь янз бүр байсан. Тухайлбал дэд бүтцийн хүрэлцээ, хүчин чадал бага, гадаад эрэлт тааруухан, таваарын үнэ ханш буурсан, санхүүгийн тогтвортой байдлын асуудал зэргийг дурдаж болно. Зарим тохиолдолд бодлогоор дэмжих асуудал тааруухан байсантай ч холбоотой. Хоёрдугаарт, евробүсийн эдийн засаг тооцоолж байснаас гүнзгий хямарсан бөгөөд энэ нь сул эрэлт, алдарсан итгэл, тааруухан тайлан тэнцэл зэрэг нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж, санхүүгийн хүндхэн нөхцөл байдлыг бүр дордуулсантай холбоотой. Гуравдугаарт, АНУ-ын эдийн засагт зарим нэг нааштай шинж тэмдэг илэрсэн ч эдийн засгийн өсөлт удаашралтай байгаа аж.

2013 оны ДНБ-ий өсөлт

	Дэлхий		АНУ		Евробүс		БНХАУ	
	2013	2014	2013	2014	2013	2014	2013	2014
Fitch	2.40	3.40	2.80	3	0.90	1.50	7.50	7
Goldman Sachs	3.3	4.10	2	2.90	-0.10	0.90	7.50	7.70
Standard Chartered	2.30	3.40	2.10	2.50	0.40	0.60	7.70	8.20
Citibank	2.60	3.20	1.80	1.70	1.10	0.70	7.40	7.10
Дэлхийн банк	2.20	3	2.00	2.80	-0.60	0.90	7.78	7.74
АХБ			2.00	2.60	-0.50	1.20	7.70	7.50
ОУВС	3.10	3.80	1.70	2.70	-0.60	0.90	7.80	7.70


Эх сурвалж: Дээр дурдсан байгууллага 2013 оны 6-7 дугаар сар

Монголын эдийн засаг 2013 оны эхний хагаст


Өнгөцхөн харахад таагүй нөхцөл үүссэнийг эс тооцвол Монголын эдийн засаг энэ хугацаанд сайн өсөлттэй байсан гэж хэлж болох. Гэхдээ эдийн засагт суурь бүтцийн ерөнхий байдал тааруухан хэвээр байгаа юм.

Доор үзүүлсэн графикт энэ оны эхний хоёр улиралд Монголын макро эдийн засгийн эрүүл мэнд ямар түвшинд байсныг голлох зургаан үзүүлэлтээр үзүүлж, нэгээс долоо хүртэлх оноо (1–хамгийн тааруухан, 7–хамгийн сайн)-гоор харуулав. Макро эдийн засаг 4.8 оноо авсан нь эерэг гүйцэтгэлийг харуулж буй. Хоёрдугаар улирлын үзүүлэлт өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад сайжирсан (1.3 оноогоор


Макро эдийн засгийн эрүүл мэндийн матриц




Гаднын шууд хөрөнгө оруулалт (ам.доллараар)



Инфляци (хувиар)



Гадаад худалдааны үлдэгдэл, ДНБ-д эзлэх хувиар



нэмэгдсэн) боловч эхний улирлаас буурсан (0.7 оноогоор буурсан) байна.

Инфляци буурсан, валют солих ханш тогтвортой байсан, чанаргүй зээлийн хэмжээ буурсан зэрэг нь нааштай үр дүн гарахад түлхэц болжээ.

Харин дотогшоо чиглэсэн үзүүлэлт нь ДНБ-ий өсөлтийн түвшин аажмаар буурч байгаа, гадаад худалдааны өр нэмэгдсэн, улсын төсөв алдагдалтай байгаа зэргээс үүдэлтэй.

2013 оны эхний хагасын эдийн засгийг бүрдүүлэгч гол хүчин зүйл юу байв?

Таамаглаж байсанчлан энэ онд Монголын эдийн засагт нөлөөлөх голлох цөөн хүчин зүйл байв. Үүнд улс төрийн тогтворгүй байдал, “Оюутолгой” болон гаднын шууд хөрөнгө оруулалттай холбоотой асуудал багтана. Өнгөрсөн хагас жилд тодорхойгүй байсан олон зүйл ойлгомжтой болж эхэлсэн ч харамсалтай нь тодорсон дүр зураг төдийлөн тааламжтай бус байна.


Ерөнхийлөгчийн сонгууль, улс төрийн хүрээнд эрх тэгш болж өнгөрсөн. Гэхдээ Засгийн газрын мөрийн хөтөлбөр цаашид гүйцэд хэрэгжих боломжтой эсэх нь баталгаагүй хэвээр байна.

Харамсалтай нь “Оюутолгой” болон түүний үйл ажиллагаатай холбоотой асуудлууд хэрхэхийг эцсийн байдлаар шийдээгүй байна. Энэ нь нийт эдийн засаг болон хөрөнгө оруулалтад дарамт үүсгэсэн. Үүний уршгаар хууль, эрх зүйн орчинтой холбоотой асуудалд зарим ахиц гарсан ч хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж чадахгүй болж, өмнө нь уул уурхайн салбараас бусад салбарт ирдэг байсан түлхэц үндсэндээ арилсан байна.

Улсын төсвөөс болон “Чингис” бондын эх үүсвэрээс хийх хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ эдийн засагт Засгийн газрын гүйцэтгэх үүрэг улам нэмэгдэх болжээ. Мөн Монголбанкны бодлогын хөтөлбөрөөр дамжуулан эдийн засаг дахь Засгийн газрын оролцоо ихсэж байгааг бид бэлхнээ харж буй.

Инфляцийг онилсон Монголбанкны мөнгөний бодлого тодорхой үр дүнд хүрсэн (инфляцийн түвшин нэг оронтой тоо болж буурсан) боловч

ам.доллар, төгрөг солих ханш



- цаашид тогтвортой байх эсэх нь эргэлзээ төрүүлэхийн зэрэгцээ бодлого тууштай биш болж, суларч байна. Энэ нь мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж, бодлогын хүү буурч буйтай холбоотой.

Энэ оны эхний хагаст худалдааны эргэлт есөн хувиар буурч, худалдааны алдагдал одоогийн байдлаар нэг тэрбум ам.долларт хүрээд байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт багасч, экспортын орлого муудсан зэрэг нь гадаад валютын эсрэг төгрөгийн ханшийг сулрахад хүргэжээ. Эдийн засагт 1.5 тэрбум ам.долларын Чингис бонд ханшийг сулруулахгүй байхад дэмжлэг үзүүлнэ гэж төсөөлж байсан ч эдийн засагт төгрөгөөр нийлүүлэгдсэн тул төсөөлөл биелсэнгүй.

Энэ оны эдийн засгийн өсөлтийн талаарх таамгаа бид арваас найман хувь болгон бууруулж байгаа болно. Цаашид “Оюутолгой”-н үйлдвэрлэл ДНБ-д дэмжлэг болох ч бусад уул уурхайн төслүүд ялангуяа жижиг уул уурхайн төслүүд багасах нь тодорхой. Уул уурхай, гаднын шууд хөрөнгө оруулалтаас хэт их хамааралтай байдал зэрэг эдийн засгийн бүтцийн сул байдал энэ онд үргэлжилсэн хэвээр байх нь. Гэхдээ эдийн засагт үзүүлэх улс төрийн хүчин зүйл бүр ч их байх болов уу. Хувийн хэвшлээс төрийн өсөн нэмэгдэж буй оролцоо руу, уул уурхайн салбарын өсөлтөөс дэд бүтэц, логистик, барилгын салбарын эзлэх илүү их хувь хэмжээ рүү, мөн гаднын шууд хөрөнгө оруулалт (FDI), гаднын байгууллагын хөрөнгө оруулагчид (IFI)-аас санхүүжсэн эдийн засгаас худалдааны бондоор санхүүжсэн эдийн засаг руу том шилжилтүүд хийгдэх нь. Суурь хүчин зүйлсийн тогтвортой байдал анхаарлын төвд хэвээр байх болно.

Инфляцийг бууруулахад гаргасан ахиц, дэвшил энэ оны хоёрдугаар хагаст үргэлжлэх төлөвгүй байна. Орон сууцны үнийн өсөлт (ипотекийн хөнгөлөлттэй зээлүүдээс үүдсэн), төгрөгийн сул ханш, нэгэнт тодорхой болсон эдийн засгийн тогтворгүй байдал нь тодорхой гарз, хохирол учруулах бөгөөд инфляцийг нэг оронтой тоонд барьж тогтооход хүндрэлтэй байх болно. Инфляци ойролцоогоор арван хувь буюу түүнээс дээш байх болов уу хэмээн таамаглаж байна.

Орлого бүрдүүлэх ажил урагшилж өгөхгүй байгаагаас энэ оны сүүлийн хагаст төсвийн санхүүгийн тогтвортой байдал гол санаа зовоосон асуудал байх болно. Засгийн газар зарим төслийн санхүүжилтийг зогсоож, одоогийн зардлыг танах шаардлагатай тулгарах болно.

Энэ оны эхний хагаст арилжааны банкуудын зээлийн хүү 1.2 суурь оноогоор (нэг хувийн өөрчлөлт 100 basis points буюу суурь оноотой тэнцүү) буурч, дунджаар 17.9 хувь болжээ. Зээлийн өсөлтийн түвшин нэмэгдэж, банкны хөрвөх чадвар богино хугацаатай байгаа бөгөөд цаашид өсөх боломж хязгаарлагдмал. Зээлийн хүүгийн түвшинд 18 хувьтай байх таамаг дэвшүүлж байна.

Валютын ханш болон түүний эрэлт, нийлүүлэлтээс гадна макро эрсдэлийг бүхэлд нь харж байгаа хүлээлтээс мөн хамааралтай. Нэгэнт эдийн засгийн өсөлт өдгөө тааруухан байгаагаас хүмүүс ам.доллар худалдан авах хандлагатай болсон нь төгрөгийн ханшийг улам сулрахад хүргэж байна. Бидний таамаглаж буйгаар энэ оны эцэс гэхэд ам.долларын төгрөгтэй харьцах ханш 1700-д хүрнэ.

Банкны салбар гэнэтийн шоконд өртөхгүй байх дархлаа буюу баталгаа байхгүй. Том банкуудын аль нэгнийх нь үйл ажиллагаа доголдоход л энэ нь бусаддаа шууд халдварлах сөрөг талтай. Бүх банк хангалттай сайн хөрөнгөтэй байх шаардлагатай бөгөөд чанаргүй зээл бага байх боловч нэмэгдэх эрсдэл өндөртэй юм. ■

2013 оны гол үзүүлэлтүүдийн урьдчилсан таамаг

Үзүүлэлт	2013 (2012 оны сүүлийн таамаг)	2013 (2013 оны 7-р сарын таамаг)
ДНБ-ий өсөлт (хувиар)	10*	8
Инфляци (хувиар)	10	10
Зээлийн хүү (хувиар)	18	18
Ам.доллар төгрөг солих ханш, энэ оны эцэст	1250	1700
Чанаргүй зээл (хувиар)	8	8

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР

ЭКСПОРТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Б.АЛТАЙ

Экспортгүй эдийн засаг хөлгүй гэж үздэг. Өөрөөр хэлбэл, импортын үлэмж хэрэглээнээс хамаарсан орон хэзээд үнийн өсөлтөд автаж байдаг гэх. Үүний зовлонг бид мэдэхээрээ нэг болсон. Гэсэн ч сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд “шинэ салхи” сэвэлзсэнгүй ээ. Импортод найдсан Монголын үе үеийн Засгийн газар экспортыг дэмжинэ гэж лоозогнодог. Импортыг орлох экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих асуудлыг ч хөнддөг. Түүний жишгээр Шинэчлэлийн Засгийн газрын тэргүүн ч мөн адил саяхан экспортыг түлхүү дэмжинэ гэж мэдэгдсэн. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамнаас Европын холбооны нийтлэг зарчим, хэм хэмжээ, стандартыг Монгол Улсад нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлэхээр мөрийн хөтөлбөртөө тусгасан нь анхаарал татлаа. Төсвийн данс улайсаж, гаднын хөрөнгө оруулалт царцсан нь экспортын үнэ цэнийг эргэн сануулав бололтой. Ийм цаг үед экспортыг дэмжихэд чиглэсэн “Үндэсний үйлдвэрлэгчдийн экспортын чадамжийг сайжруулах зөвлөх үйлчилгээ” сэдэвт сургалт энэ оны наймдугаар сарын 19-21-нд Улаанбаатар хотод боллоо. Тус сургалтыг Европын холбооны жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих төсөл болон Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас санаачлан анх удаа зохион байгуулаа. Сургалтын зорилго нь монголчууд экспортод нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зах зээлээ олж танин мэдэхэд туслах. Цаашилбал, эдийн засаг нь өөрөө өөрийгөө тэтгэх, экспортлогч орон болох үүд хаалгыг ийн дэлгэж байгаа хэрэг юм. Загас өгөх бус, загас барих аргыг заахаар Европын сэргээн босголт хөгжлийн банкны Бизнесийн зөвлөх үйлчилгээ хөтөлбөр хөгжиж буй эдийн засагтай орнуудад ийн гараа сунгажээ. Тус хөтөлбөрийг Төв Азийн хоёр оронд хэрэгжүүлж байгаагийн нэг нь манайх.

Эскпортыг дэмжих, тэр тусмаа жижиг, дунд үйлдвэрлэлийн экспортыг дэлхийн энд хүргэх сургалтад Монголын 25 зөвлөх номын дуу сонссон юм. Тэднийг өрсөлдөөнт байдлаар сонгон шалгаруулсан бөгөөд зөвлөх компаниудын зүгээс үйлчлүүлэгч компанидаа экспортын чадамжыг нэмэгдүүлэх үйлчилгээг санал болгодог эсхүл энэхүү үйлчилгээг нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байгаа эсэхийг харгалзан үзжээ. Дээрх зөвлөхүүд нь Монголын Менежментийн зөвлөхүүдийн институтын гишүүд аж. Тэд гурван өдрийн сургалтад хамрагдасны сацуу олж авсан мэдлэг, чадвараа “ажлын талбар”-т нь шалгуулна. Энэ нь гурван сарын хугацаанд дотоодын үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг экспортын зах зээлд бэлтгэх, тэдний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд “гол дүр” бүтээж, заавар зөвлөгөө өгөх юм. Үүний дараагаар гарсан үр дүнгээ Европын сэргээн босголт хөгжлийн банкны Бизнесийн зөвлөх үйлчилгээ хөтөлбөрт танилцуулах юм байна. Энэхүү хөтөлбөр нь дэлхийн 25 оронд хэрэгжиж байгаа аж. Монгол Улсад хэрэгжиж буй тус хөтөлбөрийн ерөнхий менежер Ц.Оюунжаргал “Системтэй мэдлэг экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ” хэмээн онцолсон юм.

Төгрөгийн сулрал, ам.долларын ханшийн чангарал буюу одоо манай зах зээлд үүсээд буй нөхцөл байдал дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, ажлын байраа хадгалах, өрсөлдөх



Экспортын зөвлөх үйлчилгээний сургалт. 2013.08.19

чадвараа нэмэгдүүлэх таатай боломж гэж харж болох. Хэдий болтол идэж, уух, өмсөх зүүхээ бусдад даатгаад, хүний гар харан царайчлах билээ. Ингэж яриад бид өдгөө 20 гаруй жилийг үджээ. Одоо л хийж, бүтээхгүй бол оройтох нь.

СЭЗДС-ийн Хэрэглээний математик, Статистикийн тэнхимийн эрхлэгч Ч.Наранчимэг “Уул уурхайг дан ганц шүтэхгүйгээр дотоодынхоо импортын хэрэгцээний тодорхой хувийг хангахуйц бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зүй ёсны шаардлага. Үүнийг цаг үе, зах зээл ч шаардаж байгаа. Нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь нэн тэргүүний анхаарал хандуулах асуудал. Эдийн засгаа дархлаатай болгохын тулд дунд болон урт хугацаандаа үйлдвэржилтийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэх нь оновчтой” хэмээн ярьсан юм. Эдийн засгаа тэтгэх экспортыг зөвхөн уул уурхайгаар сэтгэж үл болохыг тэрбээр учирласан.

Монголын Менежментийн зөвлөхүүдийн институтын ТУЗ-ийн дарга Э.Энхбат “Хөгжиж буй улсад үндэсний зөвлөх бэлтгэх сонирхол хөгжингүй орнуудад түгээмэл байна. Нөгөө талаас гаднын зөвлөх өндөр үнэтэй байдаг. Хэчнээн сайн гаднын зөвлөх ирээд ажилласан ч үндэсний зөвлөхтэй хамтран ажиллахгүйгээр амжилтад хүрдэггүй. Учир нь гаднын зөвлөх богино хугацаанд ирж байгаа учраас тухайн орны талаар бүрэн дүүрэн мэдээллээр хомс байдаг. Харин үндэсний зөвлөхийн давуу тал нь орчин болоод нөхцөл байдлаа илүүтэй мэдрэх учраас дутууг нь нөхөж өгдөг. Үндэсний зөвлөх хөгжсөнөөр тухайн орон мэдлэгийн дархлаатай болно” хэмээн тайлбарласан юм.

Манай улсын хувьд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор импортоор оруулж буй жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэлд татварын хөнгөлөлт чөлөөлт үзүүлж байсан тал бий. Мөн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бага хүүтэй, урт хугацааны зээлийг ч олгож байгаа. Гэсэн ч экспортыг орлох бүтээгдэхүүн гадаад зах зээлд төдийлэн амжилттай байр суурыа олж чадахгүй байгаа нь менежменттэй холбоотой гэж мэргэжлийн хүмүүс тайлбарлаж байна. Хэчнээн дэлхийн таалалд нийцэх, стандарт хангасан, органик Монгол брэнд гэж онцлоод ч зах зээлээ танин мэдээгүйгээс амжилт олохгүй байгаа.

Европын сэргээн босголтын банкны Экспортыг дэмжих зөвлөх үйлчилгээний сургалтын сургагч багш Роберт Понтэйжн “Монгол Улсын хувьд сонирхолтой цаг үе тохиож байна. Хэдий уул уурхайн бүтээгдэхүүнээ шууд борлуулж, ашиг олж байгаа ч эдийн засгийн бусад салбар нь хэлбэр дүрсээ олох гэж байгаа нь анхаарал татлаа. Нэмүү өртөг бий болгоод экспортын зах зээлд гаргах амаргүй. Гэхдээ Казахстан, Монгол сайн жишээ болж гарч ирэх төлөв бий” хэмээн өгүүлсэн юм. Манай улсын экспортын өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд дэмжлэг үзүүлж буй байгууллага нь Европын холбоо билээ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлж, тодорхой салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоно” гэж тэмдэглэсэн байдаг.

ТЭД БИДНИЙ ТУХАЙ

“ЧИНГИС” БОНД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ТААЛАГДАХАА БОЛЬСОН

Р.ГАНТУЛГА

Financial Times сонинд нийтлэгдсэн нийтлэлийг орчуулан хүргэж байна



“Чингис” бондтой холбоотой бөөн шуугиан, сенсаац дэгдээгээд байсан үе саяхан. Өнгөрсөн хорь гаруй жилийн хугацаанд Олон улсын валютын сан (ОУВС)-гийн ачаар эдийн засаг, санхүүгийн салбар нь таван ч удаа аврагдаж байсан түүхтэй Монгол Улс өнгөрсөн оны арваннэгдүгээр сард Испанийн зээлийн зардлаас ч доогуур үнэ ханш бүхий 1.5 тэрбум ам.долларын бонд гаргасан бөгөөд шинээр гарч буй зах зээлийн бондыг авах сонирхолтой хөрөнгө оруулагчид ихээр хошуурч байв.

Уг бондын өртөг тухайн үедээ Монгол Улсын эдийн засгийн тавны нэгтэй дүйцэж байжээ. Гэвч мөнгөнд умбаж байдаг,



Эх сурвалж: Capital IQ

өгөөжийн төлөө яахаас ч буцахгүй хөрөнгө оруулагчид сайн мэдэхгүй, цоо шинэ зах зээл рүү үсрэн орсон нь ямар нэг сайны шинж биш байв.

Тухайн үед төрж байсан тээнэгэлзэл харвасан сум шиг өнгөрсөн найман сарын хугацаанд зөв байсан нь нотлогдлоо. Нийт 1.5 тэрбум ам.долларын өртөгтэй "Чингис" бондын 500 сая ам.долларыг нь таван жилийн хугацаатай гаргасан бөгөөд одоогийн байдлаар нэг ам.долларын эсрэг 0.92837 ам.долларын ханшаар арилжаалж буй. Харин хөрөнгө оруулагчдын зүгээс уг бондыг гаргаж байх үед 4.125 хувийн өгөөжтэй байлгах шаардлага тавьж байсан боловч өгөөж нь өдгөө зургаан хувь хүрээд байгаа аж.

"Чингис" бондын нэг тэрбум ам.долларыг арван жилийн хугацаатай гаргаж байх үед өгөөж нь 5.125 хувь байсан бол одоогийн байдлаар долоон хувь хүрч, нэг долларын эсрэг 0,87245 ам.доллараар арилжаалагдаж байна.

Ийнхүү "Чингис" бондын өгөөжийн өсөлт АНУ-ын Сангийн яамны тооцоолж байснаас хол зөрүүтэй нэмэгджээ. АНУ-ын тооцоолсон арван жилийн өгөөж өнгөрсөн тавдугаар сард 160 суурь оноо (bps – basic points) байсан бол өнөөдөр 265 суурь оноо болж өссөн байна.

"Renaissance Capital" ОХУ-ын санхүү, хөрөнгө оруулалтын банкны ахлах эдийн засагч Чарльз Робертсон "Чингис" бондыг гаргах үед ихээхэн дэмжиж байжээ. Тэрбээр "Монгол Улс дэлхийн хамгийн хурдацтай өсч буй эдийн засаг бүхий орнуудын нэг бөгөөд бодлогын орчин нэн сайжирч буй. Монголын хувьд Испани шиг бондын үүргээ биелүүлэхгүй байх нөхцөл байдал үүсэх бараг боломжгүй" хэмээн "Wall Street Journal"-д хэлсэн байна.

Шинээр гарч ирж буй орнуудын улсын болон компанийн өрийн хувьд гэнэт өөрчлөлт гарч, засвар хийгдээд явчихвал гайхаад байх зүйлгүй юм байна. Өнгөрсөн онд гаднын орнуудаас "Чингис" бондыг сонирхсон хөрөнгө оруулагчдын тоо гэнэт өссөн боловч энэ оны эхээр маш тааруухан ашиг өгчээ.

Харин АНУ-ын хувьд Холбооны Төвбанк нь их хэмжээгээр бонд худалдан авах хөтөлбөрөө удахгүй дуусгавар болгох гэж байгаа учраас бондын хүүгийн өндөр ханш хөрөнгө оруулагчдын хувд нэгэнт утгаа алдсан байна.

"Western Assets" менежментийн компанийн шинээр гарч ирж буй зах зээлийг хариуцсан мэргэжилтэн Роберт Абад "Өнөөгийн бодит нөхцөл байдал бондын үнэ цэнэ ямар болохыг дахин батлан харууллаа. Олон улсын хөрөнгийн зах зээл рүү хялбархан орж ирэх боломжгүй, зээлийн хэвийн мөчлөгтэй орнуудаас ихээр гаргах болсон бондын өгөөжийг хялбархан хүртэх гэсэн эрмэлзэл нь эцэстээ хөрөнгө оруулагчдын үнэ цэнэ болон эрсдэлийн талаарх мэдрэмжийг харалган болгосон хэрэг боллоо" гэжээ.

Тэрбээр "Зээлийн ямар ч түүх байхгүй, олон улсад танил болоогүй аливаа улс нэг тэрбум ам.доллар буюу түүнээс дээш үнэлгээтэй 5-6 хувийн өгөөжтэй зах зээлийн үнэлгээтэй бонд гаргах нь бодит бус бөгөөд бондыг худалдан авсан нь буруу байсныг өнгөрснийг эргээд харахад л хангалттай" гэсэн байна.

Монгол Улсын арван тэрбум ам.доллартай тэнцэх эдийн засаг дэлхийд хамгийн хурдацтай өсөлттэй орнуудын нэгд тооцогддог ч зэс, нүүрс, алт зэрэг байгалийн арвин нөөц, баялгаа хав дарж, улмаар улс төрийн тогтворгүй байдал үүсч, хөрөнгө оруулагчдын итгэл алдархад хүрч буйн зэрэгцээ Оюутолгойн талаар "Рин Тинто"-той тун ээдрээтэй харилцаатай байгаа нь Монгол Улсын цаашдын хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлөх аюултай.

Бонд худалдан авч, өдгөө хохироод буй хөрөнгө оруулагчид ганцхан Монголоор дуусахгүй. Замби улсын Засгийн газраас арван жилийн хугацаатай гаргасан 500 сая ам.долларын өртөгтэй бондыг өнгөрсөн оны есдүгээр сард худалдан авсан хөрөнгө оруулагчид мөн хохирол амсаад байна. Уг бонд одоогийн байдлаар нэг ам.долларын эсрэг 0.89823 ам.доллараар арилжаалагдаж буй. Анх гаргаж байх үедээ 6.875 хувийн өгөөжтэй байсан бол өдгөө 8.158 хувь хүрээд байгаа аж.

Мөн Руанда улс арван жилийн хугацаатай 400 сая ам.долларын бонд гаргасан бөгөөд хөрөнгө оруулагчдын захиалгад дарагдан улмаар гурван тэрбум гаруй ам.долларыг хөрөнгө оруулалтыг татсан байна. Харин одоогийн байдлаар арилжаалах ханш нэг ам.долларын эсрэг 0.89 ам.доллар болсон бөгөөд анх гаргаж байх үеийн өгөөж 6.875 хувьтай байсан бол өнөөдөр 8.158 хувь болж өсчээ. Одоо уг бондыг худалдан авахад тохиромжтой байгаа бөгөөд бондыг гаргаж байх үед худалдан авсан хүмүүст төдийлэн ашиггүй болсон аж.

Гэвч тааруухан мэдээ үүгээр дууссангүй. Роберт Абад цааш нь үргэлжлүүлэн хэлэхдээ "Шинээр гарч ирж буй зах зээлүүдийн эргэн тойронд үүсч буй техникийн хөөсийг арилгаж, хөрөнгө оруулалтын зарчмыг дахин нэвтрүүлэх засвар, өөрчлөлт хийх, мөн гол цөм болсон орнуудын хөгжлийн гол төлөөлөгч болсон дээрх орнуудад бэлтгэл ажлыг зөв зохистой хангах цаашид илүү урт хугацаанд эрүүл оршин тогтноход нь тустай юм" гэжээ. Эдгээр засаж залруулах арга хэмжээ зарим хөрөнгө оруулагчийг хохироох магадлалтай аж.

Эх сурвалж: www.ft.com 2013.8.06

ХЭЗЭЭ, ХААНА, ЮУ

УЛААНБААТАР ХОТОД ЭНЭ САРД ЗОХИОГДОХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

МАСА ИГАТА, (“Frontier Securities” компанийн гүйцэтгэх захирал)

Улаанбаатар хотод энэ сард хэд хэдэн чухал хурал, уулзалт болно. Үүнд “Invest Mongolia”, “Discover Mongolia”, “Азийн банкны холбооны хурал”, “Дэлхийн эдийн засгийн форумын уулзалт”, “Хойд Америк-Монголын бизнесийн зөвлөлийн хурал” зэрэг багтана.

Эдгээр хурал, уулзалт бүгд чухал ач холбогдолтой бөгөөд Засгийн газрын бодлого тодорхойлогчид, хувийн хэвшил болон хөрөнгө оруулагчид өнгөрсөн зургадугаар сард болсон Ерөнхийлөгчийн сонгуулиас хойш нэг дор дахин цуглаж буй нь энэ. Хурал, уулзалт тус бүрийг хэлэлцэх асуудал, сэдвээр нь ангилж, эдгээр хурлаас хэрхэн мэдээлэл цуглуулах боломжтойг уншигчдад сийрүүлэн харуулахыг зорилоо.

“Invest Mongolia”



“Invest Mongolia” чуулга, уулзалт “Чингис хаан” зочид буудалд энэ сарын 2-3-нд болох бөгөөд дэлхийд нэртэй 60-70 илтгэгч лекц унших аж. Энэхүү арга хэмжээ нь Монголд зохиогддог томоохон арга хэмжээнүүдийн нэг мөн. Энэ жилийн хувьд доорх асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:

1. 2012 оны тавдугаар сараас хойш гаднын хөрөнгө оруулагчдын итгэл алдрах болсон бөгөөд Монгол Улс үүнийг хэрхэн сэргээх вэ?
2. Зээлжих зэрэглэл тогтоох агентлагууд Монголын банкны салбарын зэрэглэлийг яагаад бууруулах болов, Засгийн газраас гаргасан бондын зардлыг цаашид санхүүжүүлэхэд үзүүлэх нөлөөлөл
3. Ногоон эдийн засаг болон бизнесийн боломжууд
4. “Абэномикс” болон Японы санхүүгийн зах зээлээс үзүүлэх хүчтэй дэмжлэг
5. Уул уурхайгаас бусад салбар дахь бизнесийн боломжууд (үл хөдлөх, дэд бүтэц, хөдөө аж ахуй, тоног төхөөрөмж гэх мэт.)

Чуулга, уулзалтаар олон хэлэлцүүлэг өрнүүлдэг уламжлалтай. Тиймээс ч уран илтгэгчдийнхээ тоогоор ч дээгүүр ордог. Түүнчлэн зохион байгуулагчийн зүгээс илтгэгчдийг өндөр шалгууруар авсан бөгөөд мэтгэлцээн өндөр түвшинд явагдана. Мөн УУЯ, БОНХЯ, ЭЗХЯ-ны дэмжлэгтэй учраас яам тус бүрээс өндөр албан тушаалтнууд оролцоно гэсэн хүлээлттэй байна.

Гол ивээн тэтгэгчид нь “Quam Group”, “PricewaterhouseCoopers Audit” and “Moody’s Investor Services” зэрэг компани.

Хурлын зэрэгцээ хөрөнгийн зах зээл, сангаа арвижуулах болон санхүүгийн үйлчилгээ зэрэг талбарт бизнесийн харилцаагаа өргөжүүлэх сонирхолтой компаниудад зориулан үзэсгэлэн гаргаж байгаа болно.

Чуулга, уулзалтад оролцоход үнэ төлбөргүй. Гэхдээ арга хэмжээнд оролцох ногоон, цагаан, хөх тэмдгүүд нь төлбөртэй.

“Discover Mongolia”

“Discover Mongolia” форум нь Хүүхдийн ордонд есдүгээр сарын 5-6-нд зохиогдох бөгөөд уурхайн талбай руу хийх аяллыг 7-нд зохион байгуулах аж.

Энэ онд уламжлалт хэлбэрээс ялимгүй өөрөөр зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна. Уул уурхайн салбарыг бат бөх, үр өгөөжтэй болгон хөгжүүлэхэд салшгүй холбоотой гол асуудлуудыг шийдвэрлэхэд доорх хэлэлцүүлгийг өрнүүлж байна. Үүнд:

- Уул уурхайн салбарын тогтвортой хууль, эрх



зүйн орчин

- Уул уурхайн хөгжлийн шаардлага хангах дэд бүтцийн оновчтой шийдэл
- Байгаль орчинд ээлтэй уул уурхай
- Уул уурхайн хүний нөөц: Эрэлт, нийлүүлэлт
- Орон нутгийн түвшинд оролцогч талуудын оролцоог хангах

Дээрх таван хэсгээс гадна Япон, БНСУ, ОХУ, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд нарын дунд тусгай уулзалт зохион байгуулж байгаа бөгөөд уул уурхайн салбар дахь бүс нутгийн хамтын ажиллагааны талаар хэлэлцэх аж.

Мөн Австрали, Киргиз, БНАСАУ-ын Монгол Улстай уул уурхайн салбарт хамтран ажиллах хэтийн төлөвийн талаар олон улсын туршлага солилцох уулзалт болно.

Уул уурхайн хурлын зэрэгцээ геологи, уул уурхайн компаниуд болон уул уурхайн салбарт үйлчилгээ үзүүлдэг бусад компанийн үзэсгэлэн зохион байгуулж байна.

Цагаан тэмдэг бүхий бүртгэлийн хураамж 500 ам.доллар, ногоон тэмдэг бүхий бүртгэлийн хураамж 900 ам.доллар (бүх хэсэгт нэвтрэх эрх).

“Азийн банкны холбооны хурал”

Монголын банкны холбоо (МБХ) нь “Азийн банкны холбоо (АБХ)-ны 30 дугаар чуулган” олон улсын уулзалт, хурлыг “Blue Sky” зочид буудалд есдүгээр сарын 12-13-нд зохион байгуулах гэж байна.

Уг хурлыг АБХ-ны тэргүүн Лорензо В.Тан даргалах бөгөөд хурлын гол сэдэв “Ази тив: Дэлхийн эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр”.

АБХ-ны чуулганд гаднын экспертүүд уригдсан бөгөөд дэлхийн болон бүс нутгийн зах зээлийн голлох хөгжил Азийн банкны салбарт хэрхэн нөлөөлөх, эдийн засгийн өсөлтийг дэмжих ямар арга хэмжээг авах боломжтой талаар үзэл бодлоо солилцох аж. Түүнчлэн Ази, Номхон далайн бүсээс дэлхийн эдийн засгийн өсөлт, сэргэлтэд үзүүлэх нөлөөлөл, гүйцэтгэх үүргийг өөрчлөх зорилготой.

Төр, хувийн хэвшлийн төлөөлөл болсон илтгэгчид өөрсдийн үзэл бодлоо хуваалцахаас гадна “Дэлхийн макро эдийн засаг: Азийн банкны салбарын хувьд анхаарах хүчин зүйлс”, “Шинээр үйлдвэржин, тэлж буй орнуудад хөрөнгө оруулах боломж, тулгарч буй сорилтууд”, “Цахим сувгууд: Санхүүгийн салбарыг өөрчлөх хувьсгах нь” сэдвийн дор уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж буй.

Мөн банкны гүйцэтгэх удирдлагуудад зориулсан өндөр түвшний салбар хуралдаан зохиогдох бөгөөд өөрсдийн туршлагаас хуваалцаж, банкны салбарт тулгараад буй өнөөгийн стратегийн асуудал, амжилттай бизнес хийх арга барилын талаар хэлэлцэх юм.

“Discover ABA” гэсэн хэсэгт АБХ-ны гишүүн банкууд өөрсдийн зах зээлийн талаар танилцуулна.

Энэхүү уулзалт, хурлыг зохион байгуулж байгаа нь дэлхийн зээлжих зэрэглэл тогтоодог агентлагууд Монголын банкуудын зэрэглэлийг бууруулах болсон, мөн Хадгаламж банк дампуурсан гэх мэт асуудалтай байгаа өнөөгийн тулгамдсан үед цагаа олсон арга хэмжээ юм.

Гэхдээ хурлаар хэлэлцэх сэдвүүд хэт ерөнхий байгаагаас хэлэлцэх асуудлуудын гүнд хэр зэрэг орохыг бид хэлж мэдэхгүй. Азийн бусад оронд санхүүгийн байгууллагуудад хэрхэн хяналт, шалгалт тавьдаг талаар АБХ-ноос туршлага солилцож, зөвлөгөө авна гэдэгт найдаж байна.

“Дэлхийн эдийн засгийн форум”

Дэлхийн эдийн засгийн форумын Монголд хийх уулзалт Их Тэнгэр болон “Blue Sky” зочид буудалд энэ сарын 14-15-нд болох бөгөөд зохион байгуулагчийн үзэж буйгаар Монгол Улс хөгжлийн шийдвэрлэх үедээ байгаа аж. Түүнчлэн Монгол Улсын цаашдын хөгжил, цэцэглэлтэд янз бүрийн тодорхойгүй хүчин зүйлс нөлөөлж буй. Үүнд гаднын хөрөнгө оруулалтын нөхцөл байдал, таваарын тогтворгүй ханш, хоёр хөрш оронтойгоо цаашид хадгалах геополитикийн харилцаа гэх мэт.

“Дэлхийн эдийн засгийн форум”-аас зохион байгуулж буй Монголын ирээдүйн талаарх стратегийн ач холбогдол бүхий уулзалтаар Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчид, тус форумын стратеги ба салбарын түншүүд болон бусад оролцогч талууд уулзалт хийж, Монгол Улсын цаашдын эдийн засгийн хөгжлийн асуудлаар хэлэлцэх гэж байна.



Энэхүү уулзалт нь Дэлхийн эдийн засгийн форумаас Монгол Улсад зориулсан төслийн хувилбарыг гаргаж, улмаар уулзалтаас гарсан үр дүнг ирэх онд Davos-Klosters-т болох “Дэлхийн эдийн засгийн форум”-ын ээлжилт хуралдаанд танилцуулах зорилготой. Энэ нь Монгол Улсын цаашдын хөгжлийн чиглэлд нөлөөлөх боломжтой бөгөөд уулзалтад дэлхийд нөлөө бүхий уран илтгэгчид, төрийн өндөр албан тушаалтнууд оролцох аж.

Түүнчлэн уг форумын зарим салбар хуралдаан олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийнхэнд нээлттэй биш бөгөөд учир нь форумаас гарах зарим дорвитой шийдвэрийг уулзалтын дараа олон нийтэд танилцуулах зорилготой аж.

“Хойд Америк-Монголын бизнесийн зөвлөлийн хурал”

“Хойд Америк-Монголын бизнесийн зөвлөл (NAMBC) –ийн Хөрөнгө оруулагчдын 16 дугаар хурал” “Кемпински” зочид буудалд энэ сарын 24-26-нд болно. Уг зөвлөлийн даргаар БОНХ-ийн сайд С. Оюун томилогдсон бөгөөд тэрбээр хурлын гол сэдэв болох “Ногоон хөгжил бол тогтвортой хөгжил” сэдвээр “Хотжилт ба Улаанбаатар хотын хөгжил” сэдвээр Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл тус тус илтгэл тавих аж. Мөн “Монголын уул уурхайн ирээдүй”, “Хөрөнгө оруулалт ба Монголын эдийн засаг” гэсэн



сэдвээр хуралдаан, хэлэлцүүлэг зохион байгуулах гэж байна.

Энэхүү Хөрөнгө оруулагчдын хурал нь Монгол, Канадын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойтой давхцаж байгаа аж. Энэ арга хэмжээ УИХ-ын намрын чуулган эхлэхээс хэдхэн хоногийн өмнө болж байгаагаараа онцлог юм. Учир нь УИХ-ын намрын чуулганаар хэлэлцэгдэх Ашигт малтмалын тухай шинэ хуулийн төсөл, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон бусад хууль, бодлогын боловсруулалт зэрэг нь уул уурхай болон бусад салбар дахь гадна, дотнын хөрөнгө оруулагчдын хувьд хүлээлт үүсгээд буй чухал асуудал аж.

Уг зөвлөлийн гишүүн бус оролцогчийн бүртгэлийн хураамж 1600 ам.доллар.

Монголын уул уурхай болон бусад салбарыг сонирхож буй ялангуяа АНУ болон Канадын хөрөнгө оруулагчдад энэ арга хэмжээ ихээн ач холбогдолтой. Гэхдээ зөвхөн Хойд Америкийн хөрөнгө оруулагчид бус, бусад бүс нутгийн хөрөнгө оруулагчид уг хуралд оролцох үүд хаалга нээлттэй. Бүртгэлийн хураамж харьцангуй үнэтэй тул бусад арга хэмжээг бодвол оролцогчдын тоо харьцангуй цөөн байх болно. Гэхдээ зочид төлөөлөгчид нь чанар талаас гадна сонирхолтой чөлөөт хэлэлцүүлэг болон асуулт, хариултын цуврал хэсгүүд маш сонирхолтой байх болно.

Дүгнэлт

Юуны өмнө дээрх уулзалт, хурлууд нь гаднын хөрөнгө оруулагчдын хувьд Монгол Улсын Засгийн газрын бодлого тодорхойлогчдын гаргасан бодлогуудыг ойлгон таньж мэдэхэд маш чухал ач холбогдолтой юм. Улстөрчид өнөөгийн нөхцөл байдал хурцадмал байгааг сайн ойлгож байгаа гэдэгт бид найдаж байна. Гэхдээ ойрын ирээдүйд чухам ямар арга хэмжээ авах гэж байгаа талаар тодийлэн тодорхойгүй хэвээр.

Хоёрдугаарт, дээрх арга хэмжээнүүдэд оролцоноор хөрөнгө оруулагчдын хувьд хамгийн сүүлийн үеийн бизнесийн боломж, эрсдэлийг ойлгоход маш дөхөмтэй болох юм.

Гуравдугаарт, Монголын компаниудын хувьд дээрх арга хэмжээнд оролцоноор гаднын хөрөнгө оруулагчидтай уулзах сайхан боломж олдоно. Гаднын хөрөнгө оруулагчид энэ онд ширүүхэн нөхцөл байдалтай тулгараад буй. Ерөнхийдөө тэд Монголд хийж буй өөрсдийн бизнесийн талаар маш нухацтай эргэцүүлэн бодож, хэтийн төлөв ямар байх талаар маш анхаарал, болгоомжтой хандаж буй нь тодорхой.

Ямар ч байсан дээрх хурал, уулзалт нь Засгийн газрын бодлого тодорхойлогчдын хувьд гаднын хөрөнгө оруулагчид болон хувийн компаниудын хэрэгцээ, шаардлагыг ойлгох, Засгийн газрын түвшинд харилцан зөвшилцөлд хүрсний дараа холбогдох шаардлагатай арга хэмжээг яаралтай авах хэрэгтэй гэдгийг сайтар ойлгоход дөхөмтэй байх болно. ■



Худалдаа, хөгжлийн банкны гүйцэтгэх захирал, Монголын банкны холбооны дэд ерөнхийлөгч

БАНК

Б.МЭДРЭЭ: БАНКНЫ САЛБАРЫН НИЙТ ХӨРӨНГӨ НЬ ДНБ-ИЙ 85 ХУВИЙГ ДАНГААРАА БҮРДҮҮЛДЭГ

Азийн банкны холбооны 30 дугаар чуулган Монголд анх удаа зохион байгуулагдах гэж буйтай холбогдуулан Худалдаа, хөгжлийн банкны гүйцэтгэх захирал,Монголын банкны холбооны дэд ерөнхийлөгч Б.Мэдрээтэй ярилцлаа.

-Монголын Банкны холбоонооос зохион байгуулж буй Азийн банкны холбооны 30 дугаар чуулганы талаар тантай ярилцахаар урилаа. Энэ чуулганы ач холбогдол болоод манай улсад үзүүлэх эерэг нөлөөллийг Та хэрхэн харж байгаа вэ?

-Азийн банкны холбоо хэмээх байгууллагатай Монголын банкууд харилцаа холбоо тогтоож, туршлагаас нь судлаад багагүй хугацаа өнгөрсөн байна. Энэ удаагийн 30 дугаар чуулган Монгол Улсад зохиогдохоор болсонд бид маш өндөр хэмжээнд ач холбогдол өгч хүлээж авч байгаа. Энэ бол манай банкны салбарын өсөлт хөгжил олон улсын хэмжээнд хүрсэний тод томруун илрэл гэж хэлж болно. Өнөөдөр манай

Банкны салбарын нийт хөрөнгө нь манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний

85

хувийг дангаараа бүрдүүлдэг.

санхүүгийн зах зээл дээр хамгийн сүүлийн үеийн бүтээгдэхүүн үйлчилгээ, дэвшилтэт технологи, чадвартай сайн боловсон хүчнүүд банкны салбарт ажиллаж байна. Товчоор хэлбэл, Монгол Улсын эдийн засгийн хөгжилд банкууд хамгийн чухал үүргээ гүйцэтгэж байгаа. Чуулганаар Ази, Номхон далайн бүс нутгийн санхүү, банкны салбарын шилдэг төлөөллүүд Монголд цугларч, туршлага, ололт амжилтаа хуваалцана, цаашлаад Монгол Улсын банкны салбар олон улсад харилцаагаа тэлэх боломж гарч ирнэ, олон улс дахь нэр хүнд ч өснө.

Олон улсын өргөн хэмжээний том чуулганыг зохион байгуулж буй Монголын банкны холбоонд бид баяр хүргэх ёстой. Энэ ажилд арилжааны банкууд холбоог дэмжээд, хамтран зохион байгуулалтад оролцоод явж байгаа.

-Чуулганы үеэр ямар асуудлуудыг түлхүү авч хэлэлцэх вэ?

-Энэ сарын 12, 13-нд хоёр өдрийн турш салбар хуралдаан явагдана. Чуулганы гол уриа буюу ерөнхий сэдэв нь “Ази бол дэлхийн эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр” гэсэн агуулгатай байгаа. Ерөнхийдөө дэлхийн эдийн засагт гарч байгаа хүндрэлүүд юу байна, тэр нь Азид яаж нөлөөлөх, байгалийн баялаг ихтэй Ази тивийн хөгжлийн тулгамдсан асуудлууд, цаашдын сорилт болоод боломжууд, санхүүгийн салбарт орчин үеийн технологийн дэвшлийг Азийн банкууд хэрхэн нэвтрүүлсэн, цаашдаа улам сайн хөгжүүлэх зэрэг олон улсын туршлагаа улс орнууд хуваалцана. Зөвхөн санхүү, банкны төлөөллүүд ч гэлтгүй Ази, Номхон далайн бүс нутгийн хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгч, Монголын арилжааны банкууд, санхүүгийн байгууллага, төр засгийн бодлого тодорхойлогчид оролцох учраас үр дүнг бид маш өндөрөөр харж байгаа. Монголын банкны салбарыг олон улсад таниулах том үйл ажиллагаа гэж хэлж болно.

-Монголын банкууд олон улсад хэр танигдсан гэж та боддог вэ. Ер нь банкуудын өнөөгийн байдлын талаар туршлагатай банкирын хувьд санаа бодлыг тань сонсъё?

-Манай банкууд хөрөнгийн хувьд олон улсын банкуудтай харьцуулахад жижиг ч гэлээ сүүлийн 20 жилд хамгийн үсрэнгүй хөгжсөн салбар шүү дээ. Монгол Улсаас анх удаа олон улсад бонд арилжаалсан байгууллага нь арилжааны банк, Ази, Европт дэлгэрч байгаа банкны бүтээгдэхүүн үйлчилгээ бүгд Монголд байна. Чамлаж болохгүй сайн үзүүлэлтүүд арилжааны банкуудад бий. Монголын эдийн засгийн том ачааг үүрч байгаа банкны салбарын нийт хөрөнгө нь манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 85 хувийг дангаараа бүрдүүлдэг.

-Монголын банкны холбооны дэд ерөнхийлөгчийн хувьд тус холбоо гишүүн банкуудаа нэгтгэх, хамтын ажиллагааг дэмжих тал дээр хэрхэн ажиллаж байгаа вэ?

-Монголын банкны холбоо бол бизнесийн байгууллага биш, харин салбарын бодлогыг хамтдаа хэлэлцэж, мэргэжил нэгт хүмүүс хамтран асуудлаа шийдвэрлэдэг мэргэжлийн холбоо гэдгийг энд онцолмоор байна. Арилжааны банкуудын нягт хамтран ажиллах, өсөн хөгжихөд холбоо маш чухал үүрэгтэй ажиллаж байгаа. Жишээ нь, холбооны дэргэд Эрсдэлийн удирдлага, Хууль, Хүний нөөц, Тусгай актив, Маркетинг зэрэг мэргэжлийн зөвлөлүүд ажилладаг. Энэ нь банкууд хамтдаа асуудлаа тодорхойлж, зөв шийдлээ эрэлхийлэх боломжийг бүрдүүлж өгч байгаа юм.

Мөн Засгийн газраас хэрэгжүүлж буй найман хувийн орон сууцны зээлийн хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэх, нөхцөлүүд нь ямар байх нь зүйтэй талаар банкууд хэлэлцэн, санал шийдлээ холбогдох байгууллагад хүргүүлж, хамтран ажиллахад манай холбоо чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ удаа ч гэсэн чуулганыг арилжааны банкуудтай хамтран зохион байгуулж байгаа зэргээс холбооны үйл ажиллагаа сайн байгаа гэдгийг хэлэх байна.

-Найман хувийн зээл зорилтот бүлэгтээ хүрч чадаж байгаа юу. Зээлийн явц болон эх үүсвэрийн хангалтын талаар мэдээлэл өгөхгүй юу?

-Арилжааны банкууд Монголбанктай хамтраад найман хувийн зээлийн үйл ажиллагааг маш амжилттай зохион байгуулж, харилцагчиддаа хэвийн олгоод явж байгаа. Эх үүсвэрийн хувьд хангалттай байна. Үнэхээр шаардлагаа хангаад ирж байгаа харилцагчиддаа аль болох шуурхай олгох талаас нь ажиллаж байна. Найман хувийн хүүтэй зээлийг зорилтот бүлэг болох дундаж орлоготой иргэддээ олгож эхэлсэн эхний 42 хоногт нийт арилжааны банкуудын дээрх зээлд хамрагдсан зээлдэгчдийн 25 гаруй хувийг ХХБ-ны зээлдэгчид эзэлж байгаа талаар Монголбанкны тоон мэдээ гарсан байсан. ■

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

УУЛ УУРХАЙН ШИЙДЭЛ ЮҮ БАЙХ ВЭ?

Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт огцом уруудсантай холбоотой эдийн засгийн хурдацтай өсөлт саарахад хүрээд буй. Ийм үед ямар бодлогын арга хэмжээ авч, асуудлыг шийдэх гарц юу байна вэ гэдэг талаар албаны хүмүүсийн байр суурийг сонирхлоо.



Д.Зоригт
/УИХ-ын гишүүн/:

-Хамгийн чухал нь хөрөнгө оруулалтын орчноо тодорхой болгож, хөрөнгө оруулагчдын итгэлийг эргүүлэн олж авах хэрэгтэй. Хөрөнгө оруулалтын орчны тухай хуулийн төсөл дээр миний бие нэлээд удаан ажиллалаа. Тэгэхээр хамгийн түрүүнд уг хуулийг батлах шаардлагатай байна. Хөрөнгө оруулалтын тухай хуулиар татварын орчинг тогтворжуулж, гол гол татварын хувь хэмжээг нэмэхгүй байхаар тусгасан. Мөн гадаад дотоод, том жижиг гэлтгүй нийт хөрөнгө оруулагчдад зориулж гаргаж буй учраас хөрөнгө оруулагчдын алдарсан итгэлийг сэргээхэд томоохон түлхэц болно. Үүний дараагаар Засгийн газар энэ чиглэлд тусгайлан төлөвлөгөө гаргаж ажиллах ёстой. УИХ учирч болзошгүй эдийн засгийн хүндрэлээс урьдчилан сэргийлэх хамгаалалтын арга хэмжээ авахаар ажиллаж байна. Ингэхдээ хууль эрх зүйн актууд дээр ажиллаж, системтэй бодлого гаргаж ирэх хэрэгтэй.



О.Чулуунбат
/Эдийн засгийн, хөгжлийн яамны дэд сайд/:

-Хууль эрх зүйн орчноо сайжруулж, бизнес хөрөнгө оруулалтад таатай болгох хэрэгтэй. Өнөөдөр эдийн засгийн идэвхтэй байдал суларсны гол шалтгаан бол хууль эрх зүйн орчин муудсан явдал. Мөн Монголын төр илүү анхаарах ёстой нэг зүйл бол төрийн залгамж чанар. Манайх энэ тал дээр нэлээд учир дутагдалтай ажиллаж байгаа. Гэрээ хэлцэл хийсэн л бол түүнийгээ ягштал биелүүлдэг, мөрддөг тийм л үндэстэн, ард түмэн байх ёстой. Манайхыг дэлхийн зах зээл дээр хууль эрх зүйн бойжилтгүй улс гэж нэрлээд байна шүү дээ. Бойжилттой болохын тулд энэ талын боловсролтой болох хэрэгтэй. Тэгэхгүй бол зах зээл дээр бидэнтэй ярилцах, биднийг хүндэтгэх хүн байхгүй болж байна. Монголчуудын сайхан уламжлал байдаг. Бид гадна, дотнын ямар ч хүнтэй наймаа хийгээд алдсан ч, оносон ч хэн хэндээ сайныг ерөөгөөд хүндэтгэлтэй ханддаг.

Монголын төр Оюутолгой, “Чалько”-той өмнө нь гэрээ хийсэн. Тэрийг мөрдөх ёстой. Асуудал байвал Монголын эрх ашгийг хамгаалж ажилласан, хэлэлцээр хийсэн С.Батболд, Д.Зоригт, С.Баярцогт нараас эхлээд асууя л даа. Ямар зарчим баримталж, яаж энэ гэрээг байгуулсан юм бэ. Дотооддоо тэгж яриагүй мөртлөө гаднаас ирж гэрээ хийсэн хүнийг буруутгаад байхаар гадаад зах зээл биднийг ойлгохгүй байна шүү дээ. Тэгэхээр ийм залгамж чанартай, монгол хүний ёс жудаг, уламжлалаа харуулсан бодлоготой болмоор байна шүү дээ.



Н.Алгаа/
Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал/:

-Богино болон урт хугацааны гэсэн хоёр асуудал байна л даа. Өөрөөр хэлбэл, урт хугацааны бодлогоо өнөөдөр эхэлсэн нь зөв. Хөрөнгө оруулалтын тухай хуулиар эхлэлийг нь тавибал тогтвортой байдлыг хангах сайн жишиг болно.

Богино хугацааны арга хэмжээний хувьд Ашигт малтмалын тухай хуульд дөрөв дэх шинэчилсэн найруулга хийх шаардлага байхгүй. Миний бодож байгаагаар өмнөх гурван удаа шинэчилэн найруулсан хуулиас юу нь муу, юу нь сайн байсан бэ гэдгийг шүүгээд, тэрийгээ 2006 оныхоо хуульд байгуулаад явах нь цаг хожино.

Мөн хувийн өмчийг нийтийн өмчтэй адилтгаж үзнэ гэж Үндсэн хуульд биччихсэн байгаа хэрнээ хувийн өмчийн эрх нь хамгаалагдахгүй байна. Уг нь дор хаяж шүүхийн шатанд эрх нь хамгаалагддаг байх ёстой. Өнөөдөр төрийнх нь хамгаалалттай хувийнх нь хамгаалалтгүй байна шүү дээ.



Ч.Отгочулуу
/Уул уурхайн яамны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга/:

-Манай улс тавхан жилийн дотор уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, экспортоороо дэлхийд эхний тавд орж чадсан. Цаашдаа ч ахина. Маш хурдтай өсч байгаа аливаа өөрчлөлтийг удирдах, зохицуулахад суралцах хугацаа их шаарддаг юм байна. Хятадын эдийн засаг үргэлж өсч, манай нүүрсийг байнга өндөр үнээр авч байдаг биш юм байна гэдгийг ойлгуулж байна. Тэгэхээр цаашаа Япон, Солонгос руу яаж гаргах юм, нүүрсээ яаж боловсруулах юм, зөвхөн нүүрс, зэс хоёр дээрээ түшиглэх юм уу, алт, төмөр, жонш, газрын ховор элемент, газрын тос гээд олон төрөлтэй болгох уу гээд бодож төлөвлөх ажил их. Бид дээрх олон төрлийн ашигт малтмалын талаар судалгаа хийж байгаа. Улсын төсвөөс долоо орчим тэрбум төгрөг гаргаад, энэ улсын газрын хэвлийд юу юу байгаа юм бэ гэдгийг тодорхой болгох геологийн ажлын зураглал хийж байгаа. Гэхдээ энэ нь хайгуул биш, хайгуулын өмнөх зураглалын ажил юм. Хайгуулын хувьд одоохондоо хувийн хэвшлийнхэндээ найдахаас өөр арга байхгүй. Хувийн хэвшлийнхэн эхлээд та нар нэг зураг үзүүлээч гэдэг. Тэрийг нь улс бэлдэх талаар маш сайн ажиллаж байгаа.

Хууль эрх зүйн хувьд мэдээж нэг хуульд өөрчлөлт оруулаад л хөрөнгө оруулалтын орчин сайжирчихна гэж байхгүй. Дээр хэлсэн геологи хайгуулын ажлуудаас эхлээд Ашигт малтмалын хуулиар зохицуулагдах асуудлууд, Газрын тосны, Төсвийн тухай хуулиудаар зохицуулагдах асуудлуудыг зангидсан бодлого гаргаад, холбогдох хуулиуд нэг нэгэнтэйгээ зөрчилдөөд, ойр ойрхон өөрчлөгдөөд байхааргүйгээр зохицуулалтыг хийж байгаа.



Б.Лхагжав:
/"Үндэсний соёмбо" хөдөлгөөний тэргүүн/:

-Аль болох зөөлөн бодлого явуулж, санхүүгийн өршөөл нэн даруй үзүүлэх хэрэгтэй. Ингэснээр тайлан тооцооны асуудлыг цэгцэлж, нууц тайлан гаргадаг асуудал шуударна. Дээр нь бид зөвхөн гадаадын хөрөнгө оруулагч гэлтгүй дотоодын аж ахуйн нэгж эрхлэгчдийнхээ урам зоригийг дэмжих хэрэгтэй. Ингэхдээ ажлын байраа хадгалж үдсэн компаниудын цалингийнх нь фондны хэмжээгээр татварын хөнгөлөлт үзүүлэх бодлого баримаар байна. Өмнө нь хавтгайд нь хөнгөлдөг байснаа болих хэрэгтэй. Тэгээд энэ зах зээлийг зөөлөн чөлөөтэй орхиход л Засгийн газрын том тус болно.

Мөн ашигт малтмалын тухай хуулийг өөрчилж, зөвшилцөлд хүрч чадахгүй байгаа бол ойрын таван жилд тус хуулийг 2006 оныхоо хувилбараар нь мөрдөнө гэж зарлах хэрэгтэй. Түүнчлэн Ерөнхий сайд Хятадын талтай очиж, уулзаж нүүрс , ашигт малтмалын экспортдоо барих бодлогоо тодорохой болгож, гэрээ хэлэлцээр хийгээч ээ. Төсвийн орлогын дийлэнх хувийг бүрдүүлдэг нүүсний үнэ унаад , зарагдахгүй болчихоод байхад Засгийн газар гол нийлүүлэгч оронтойгоо хэрхэн хамтарч ажиллах талаар шийдэлд хүрэх ёстой шүү дээ. Ингээд зүгээр суугаад байж таарахгүй. ■



Шог зургийг А.Амарсайхан

ХУУЛЬ

ТӨРИЙН ДОН

Э.ЗОРИГТ

Монголын төр “гаж дон”-той. Тэр “дон” гэх өвчин нь хэзээний архаг хууч гэхэд хилсдэхгүй. Учир нь бүх зүйлийг төрийн оролцоотой хийх гэдэг эрх баригчдын буруу хандлага эдийн засагт тахал мэт тарахсаар. Үүнийх нь үр дүнд дээд хурдаараа урагшилж байсан эдийн засаг гэнэт л тоормосоо гишгэв. Эдийн засаг гэх машины хөдөлгүүр болсон уул уурхайн өсөлт хөрж, хөдөлгүүрийн тэжээл болох хөрөнгө оруулалт саарсан мэдээ өдгөө хаа сайгүй. Хөдөлгүүр хөрж, хөрөнгө оруулалт алсарч байгаа гол шалтгааны эхэнд нөгөө л төр засгийн буруу бодлогын уршиг бичигдэнэ.

“Урт нэртэй” хуулийн урт холын аян

Төрсөн түүх, өгсөн нэр, туулсан замынх нь аль аль нь урт “Гол, мөрний урсац, бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” гэх хууль гарсан цагаасаа л хэл амны бай болсон. Уг хуулийг гараад удаагүй байхад ам чилээх шахсан нэрийг нь хүртэл хэлэхээс төвөгшөөж “Урт нэртэй” хэмээн хочилсон. Өнөөдөр Монголын эдийн засгийн тулгуур болсон уул уурхайн салбар уруудахад нөлөөлсөн зүйлүүдийн нэг “урт нэртэй” хууль гэдгийг салбарын үйлдвэрлэгчдийн зүгээс хэлж буй. Хуулийн уг санаа нь уул уурхайн салбарын байгаль орчин сүйтгээд орхидог жишгийг халах зорилготой байсан. Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Д.Дамба “Байгаль орчноо хамгаалах, »

экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах, уул уурхайн үйлдвэрлэлд сүйтгэгдсэн газар шороог нөхөн сэргээх, унаган төрхөнд нь оруулах чиглэлээр төр засгаас тавьж байгаа бодлого чиглэлийг бид эсэргүүцэхгүй, хүлээн зөвшөөрнө. Гагцхүү түүнийг хэрэгжүүлэх арга механизм нь буруу байна шүү дээ. Үр дагавар нь ямар гарах вэ, ямар хор хохирол учрах вэ, эдийн засгийн ямар үр дагавартай вэ гэдгийг хууль батлахаасаа өмнө тооцоолоогүй" гэсэн юм.

Урт нэртэй гэж нэрлэдэг энэ хуулийн хүрээнд 1391 тусгай зөвшөөрөл хөндөгдсөнөөс 391 олборлолтын тусгай зөвшөөрлийг хамруулсан. Үүнээс 260 орчим тусгай зөвшөөрлийн буюу алтны шороон ордуудын үйл ажиллагааг зогсоосон гэх мэдээлэл бий. Энэ нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хувьд таагүй мэдээ байсан талаар хэлэх хүн олон. Тухайлбал, Ашигт малтмалын хуульд зааснаар тусгай зөвшөөрлийг Засгийн газрын шийдвэрээр цуцлах юм бол тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн төлбөр олгоно гэсэн байдаг. Гэтэл дээр дурдсан 260 орчим аж ахуйн нэгжид тэр их мөнгийг хаанаас өгөх вэ. Татвар төлөгчдийн мөнгөнөөс л хумслана. Энэ мэт улс төрийн "гаж дон" архагшиж, нэг талыг хэт барьсан бодлогогүй бодлогууд гаргаж, олон хүнийг айлгах болсон.

Юу, юу, яасан гэнэ ээ?

2006 оны Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр оруулсан Стратегийн ордын тухай ойлголт олныг гайхшруулж дуусаагүй байтал дээрх "урт нэртэй" хууль 2009 онд батлагдсан. Гэтэл стратегийн гэх үгийн утгыг бүрэн тайлж амжаагүй, "Урт нэртэй" хуулийнхаа учир утгыг ойлгоогүй байж байтал Ерөнхийлөгчийн санаачилгаар Ашигт малтмалын тухай хуулийг дахин шинэчлэх болсон нь усны шувуу шиг хөрөнгө оруулагчдыг үргэчихсэн. Гаднынхан "гамшгийн" гэж тодотгоод амжсан эл хуулиар өнөөх л нөхөн сэргээлт, орон нутгийн оролцоо, уул уурхайн компаниудын хариуцлагын талаар үг үсэггүй дурдсан боловч уул уурхайн компаниудын эрх ашгийн талаар дуугараагүйгээр зогсохгүй өмчөө төрд булаалгах таагүй нөхцөл бүрдсэн гэх. Адаглаад орлогоос татвар авах зарчмаас эрс хазайж олборлосон бүгдээс ашиг авахаар заасан байх жишээтэй. "Үндэсний соёмбо" хөдөлгөөний тэргүүн Б.Лхагважав "Уул уурхайн салбарын гол хууль нь өөрчлөгдөнө гэхээр хэн Монголд хөрөнгө оруулаад явж байх вэ дээ" гэв. Мөн "Цөмийн энергийн тухай хууль" батлагдаж, гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд Монгол Улсын Засгийн газрыг шүүхэд өгөөд, Олон улсын арбитрт заргалдсан. Хайгуулын ажиллагааг зогсоож, хөрөнгө оруулагчид Монголын хөрсөнд хөрөнгөө буллаа. Цаашилбал 2006 онд батлагдсан Гэнэтийн ашгийн гэх тодотголтой 68 хувийн татвараас эхтэй Монголын татварын таагүй орчин уул уурхайн салбарын хувьд шүдний өвчин болчихоод байгаа нь нууц биш

Гэнэтийн ашгийн 68 хувиас болоод манай алтны салбар хүнд цохилтод орсон. Хэдийгээр тус хуулийг хүчингүй болгосон ч алдаа нь заларч амжаагүй байхад Өсөн нэмэгдэх рояалти татвар гэгч зүйл шинээр гараад ирсэн. Үр дүнд нь олон улсын хөрөнгийн бирж дээрх Монголтой холбоотой хувьцааны үнэ навс уначихаад байна. УИХ-ын гишүүн Д.Зоригт "Татварын таагүй орчин хөрөнгө оруулагчдыг алдах бас нэг гол шалтгаан. Үүнтэй холбоотой уул уурхайд хөрөнгө оруулсан бүхэн тодорхой хэмжээний алдагдал хүлээж эхлээд байна. Энэ нь юугаар илэрдэг вэ гэхээр Монголд үйл ажиллагаа явуулдаг Австрали, Торонто, Нью-Йорк зэрэг томоохон хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компаниудын хувьцааны үнэлгээ сүүлийн хоёрхон жилийн дотор 77-93 хувиар унаад байна. Ийм улсад хэн хөрөнгө оруулахыг хүсэх вэ" гэлээ. Энэ мэт ар араасаа ундарсан учир дутагдалтай олон хуулийн учрыг нь олоход ихээхэн төвөгтэй.

Монголд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль байснаас хязгаарлах тухай хууль гэж байгаагүй. Тэр хууль нь ч өөрийн гэсэн эерэг үр дүн өгсөн. Гэтэл үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль баталсан. Хэдийгээр гадаадын цөөнгүй оронд ийм төрлийн хууль үйлчилдэг ч нөхцөл, шалгуур, хэрэгжилт нь тодорхой бөгөөд бодитой байдаг тул гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд тоглоомын дүрэм ойлгомжтой байдаг. Уул уурхайн сайд Д.Ганхуяг "Уг нь шинээр баталсан хуулийн зорилго нь их зөв. Гэтэл батлахдаа хүндрүүлээд нийгэмд буруу ойлголт бий болгочихлоо. Уг нь ашигт малтмалын салбар дахь төрийн оролцоог багасгамаар байна.

Гэтэл тус салбарт гаднын төрийн өмчит компани ихээр хөрөнгө оруулах нь манай үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж улс төрийн маргаан үүсч болзошгүй. Тиймээс тус хуулиар гаднын төрийн өмчит компаниудын хөрөнгө оруулалтыг зохистой түвшинд байлгах зорилттой байсан. Гэтэл хууль батлахдаа нийт хөрөнгө оруулагчдыг үргэчихсэн" хэмээн учирласан удаатай. Ийнхүү хөрөнгө оруулагчид эхний асуултынхаа хариултыг ч бүрэн авч чадаагүй байтал тэднийг дээрх мэт эцэс төгсгөлгүй таагүй мэдээгээр бөмбөгдсөөр л. . .

Итгэл бөхтөл үлээсэн салхи

"Оюутолгой" бол монголчуудын төдийгүй олон улсын хөрөнгө оруулагчдын итгэлийн галыг бадраагч байсан гэхэд хилсдэхгүй. Гэтэл гэрээнд өөрчлөлт оруулах тухай он жил дамжин яригдаж, Оюутолгойн хөрөнгө оруулалт зогссоны уршгаар далд уурхайн үйл ажиллагаа зогссон. Нийтлэлч Баабарын нэгэн нийтлэлд "Оюутолгойн зэс, алтыг ашиглахаар гадныхны байгуулсан компанийн хувийг заавал авна гэсээр байгаад Монголын Засгийн газар 34 хувийг нь өр тавьж байгаад эзэмшсэн. Татвар роялтийг нь аваад ашгийн хагасыг нь хүртдэг олон улсын жишиг байхад шүү дээ. Монгол ухаан ч дэлхийнхээс өөр л дөө! Одоо үүсэх бүх асуудал эндээс гаралтай" гэжээ. Төр нэгэнт шийдвэрээ гаргаад Засгийн газар нь гэрээ байгуулсан бол түүнийгээ

зайлшгүй хэрэгжүүлээд явах ёстой. Гэтэл сонгууль болж, засгийн эрх солигдоход өмнөх бүх хууль тогтоомж нь өөрчлөгдөөд байж болохгүй. Ингээд байвал гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх нь бүү хэл, Монголыг олж харах ч үгүй.

Хүлээлт

Дээр дурдсан уул уурхайтай холбоотой олон хууль эдийн засгийн тамирыг шавхаж, хямрал хаалга тогшоод байгаа энэ үед юу хийх вэ. Үүний тулд УИХ-ын ээлжит бус чуулганаар Ашигт малтмалын тухай хууль болон Хөрөнгө оруулалтын орчны тухай хуулийн төслийг оруулахаар төлөвлөгдөөд байгаа сураг бий. Ашигт малтмалын анхны хууль 1994 онд батлагдаж улмаар 1997 онд нүүрээ угааж, нөгөө хувцасаа өмссөн. Түүний дараа 2006 онд дахин "мэс засалд" орсон түүхтэй. Ашигт малтмалын анхны хуульд байгалийн эрдэс баялаг ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байх эрхийг нээж, төр өмчлөгч хэмээн хуульчилжээ.

Түүнчлэн ашигт малтмалыг хайх, ашиглах зөвшөөрлийг гадаад, дотоодын хуулийн этгээдэд олгох, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, иргэд Монгол Улсын газрын баялгийг эзэмших, ашиглах эрхийг нээсэн хөтөч хууль юм. Тэгвэл 1997 оны хуулиар гаднын хөрөнгө оруулагчдад илүү таатай, зах зээлийн боломжийг нээж, Монголын эдийн засгийг дэлхийд газарчилсан хууль болсон гэж уул уурхайн салбарын үйлдвэрлэл эрхлэгчид үнэлдэг.

Тэгвэл 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өмнөх хоёр хуулийн нэгдэл гэж салбарынхан дүгнэдэг. Эргэн харвал, Үндсэн хуулийн дараа орох уул уурхайн салбарын эцэг хууль өнгөрсөн 20 жилийн хугацаанд гурвантаа дүрээ өөрчилж, үүргээ тодорхой хэмжээнд чамлахааргүй биелүүлж иржээ. Гэтэл дөрөв дэх өөрчлөлтийг хийх шаардлага байсан уу гэдгийг эргэн харахад илүдэхгүй болов уу. Шинэчилсэн найруулга хийгээд хууль тогтоогчдын шалгуураар орохоор зэхэж буй Хөрөнгө оруулалтын орчны тухай хуульд өнөөдрийн гаргасан алдаа, үүссэн асуудлыг шийдвэрлэх, өнөө маргаашийг биш 10, 20 жилээр алсыг харсан зохицуулалтыг хийсэн сайн хуулийн төсөл болсон гэдгийг уг хуулийн төсөл дээр ажилласан Эдийн засгийн хөгжлийн яамны дэд сайд О.Чулуунбат, УИХ-ын гишүүн Д.Зоригт нар хэлж буй. О.Чулуунбат "Хөрөнгө оруулалтын хуулийг гадаад, дотоодын том жижиг гэлтгүй нийт хөрөнгө оруулагчдад зориулан гаргаж буй. Тиймээс татварын орчинг тогтворжуулахаар байгаа. Мөн хууль эрх зүйн орчинг урт хугацаанд тогтвортой байх талаар тусгасан" гэв. Хэдийгээр хуулийг хэлэлцэх цаашлаад хөрөнгө оруулагчдад эээлтэйгээр батлах нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж магадгүй ч энэ бол ердөө л эхлэл. Цаана нь дээр дурдсан Урт нэртэй хууль, Цөмийн энергийн тухай хууль, Төрөөс баримтлах Эрдэс баялгийн талаарх бодлогын баримт бичиг, Оюутолгойн гээд олон асуудлыг шийдэхгүй бол хөрөнгө оруулагчид тийм ч хурдан эргэж ирэхгүй. Уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа "Нэг хуульд өөрчлөлт оруулаад л хөрөнгө оруулагчдын итгэл сэрэгчихгүй. Хамгийн гол нь манайх зах зээлийн эдийн засагтай орны хувьд бизнес дэх төрийн шууд оролцоог зохицуулах үүрэг үүнь түлхүү чиглүүлэх хэрэгтэй байна" гэв. Улс төрчид л түүхий хууль "үйлдвэрлэдэг". Тиймээс тэдний бүх зүйлийг төрийн оролцоотойгоор хийх гэсэн буруу бодлоос ангижрах цаг болсныг Монголын эдийн засаг харуулаад байна. ■

ТАТВАР

ТАТААСЫН ТОГТОЛЦОО



Б.ҮҮРИЙНТУЯА

Малаа бусдынхаас ялгахын тулд тамгалж, чихний үзүүрийг нь имлэдэг малчин ардынхаа ухаанаас Монголын төр засаг суралцвал яасан юм бэ. Төр засаг ард иргэд, аж ахуйн нэгжээс элдэв нэртэй олон арван татвар хүчээр хураадаг ч зориулалтаар нь зарцуулж буй эсэх нь эргэлзээ төрүүлдэг. Ер нь тодорхой татвар, хураамжуудаа "имлэх" буюу юунд зориулахыг хуульчлан оноож, "ээмэг зүүвэл" өнөөгийн нийгмийн өмнө тулгамдаж буй олон асуудлын шийдвэр зөв чиглэлд орох боломжтой.

/Эдийн засагч Д.Жаргалсайхан/

Уул уурхай. Манайхны амны уншлага болж буй энэ салбарын хөгжил Монголын эдийн засгийн “амин дэм” нь болох учиртай. Гэтэл дэм болох нь битгий хэл, дэмжлэг хүсэхэд хүрээд буй шалтгааныг холоос хайх хэрэггүй болов. Гэтэл өнөөдөр уул уурхай уналтад ороогүй, эдийн засаг хямраагүй гэсэн үгсийг хээв нэг хэлээд сууж буй эрх баригчид албан тасалгааныхаа цонхоор бус үүдээрээ шагайгаад нэг сонирхоосой. Учир нь эл салбарт үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд хөрөнгө оруулагчдаа алдаад зогсохгүй татварын өр нь зузаарсаар байна.

Угтаа бол Засгийн газар экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор уул уурхайн салбараа тэргүүлэх цолоор тодотгож, татварын болоод бусад хөнгөлөлт үзүүлэх замаар бизнесийн таатай орчин бүрдүүлэхээр ажиллаж байна гэх. Үүгээр ч зогсохгүй төсвийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох үүднээс уул уурхайн салбарын татварын түвшинг оновчтой түвшинд тогтоох зэргээр татварын бодлогоор дэмжих тухайгаа тунхагласан.

Монгол Улсын Ашигт малтмалын газрын судалгааны хэлтэс Монголын уул уурхайн салбарын албан татварын нийт хэмжээг олон улсынхтай харьцуулсан судалгаа хийсэн байдаг. Жагсаалтад энэ төрлийн татварын хэмжээ нь 62.9 хувьтай Үзбекстан муу нэр зүүж яваа бол 28.6 хувиар Швед улс албан татварын хамгийн бага хэмжээтэй хэмээн сайшаагджээ. Манай улсын албан татварын нийт хэмжээ 32.9 хувьтай гарч олон улсын уул уурхайн салбарын хувьд татварын дарамт бага буюу гадаадын хөрөнгө оруулалтын таатай нөхцөлтэй гэсэн дүгнэлтэд хүрчээ. Тэгвэл дэмжье, тэтгэе гэсэн ч өөдлөхгүй байгаа уул уурхайн салбар шалдаа бууж буйн шалтгаан юу вэ?



Нөхцөл байдал

Хөрөнгө оруулалт татарсан, дэлхийн зах зээлийн ханш уруудсан, хууль эрх зүйн орчин таагүйгээс ийм уналтад орлоо гэсэн олны яриа улиг болсон. Иймд үүнийг дэлгэрүүлэх нь илүүц. Харин эдгээр асуудлаас гадна татвар хэлбэрээр улсын төсөвт орох мөнгөн дүнгийн асуудлыг сөхөх хүн ховор. Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа “Уул уурхайн салбарыг мөнгөний машин мэтээр ойлгож нэмэлт, өөрчлөлт нэрээр татварын хэмжээг нэмдэг байж таарахгүй. Татвар гэдэг нь бизнесийн үйл ажиллагааг боож, дарамтлах бус дэмжих үүрэгтэй. Гэтэл олон янзын зохиомол татварыг бий болгосоор байна” гэсэн юм. Уул уурхайн компаниудын борлуулалтын үүд нарийсч орлогогүй шахам болсон энэ үед гаалийн хураамжууд татварын хэлбэрт шилжсэн нь олсон хэдээ хилээр гаргах гэж буй дотоодын компаниудаа зах зээлээс “арчиж” буйг салбарынхан онцолж байна. Татварын ерөнхий газрын харьяа Улсын төсвийн орлого, хяналтын газрын Эрдэс баялгийн татварын хэлтсийн дарга Н.Эрдэнэмядаг “Монгол Улсын татварын хувь хэмжээг бусад, тухайлбал Скандинавын орнуудтай харьцуулбал тун бага. Таатай нөхцөлтэй. Гэхдээ хууль эрх зүйн орчин тогтворгүй байгаа нь асуудлын цөм болж байна” гэв.

Уул уурхайн салбарынхны хэлж буйгаар жишиг үнэ гээчийг тогтоосон нь өрөнд унаж, өтөнд идэгдэх нөхцөл болсон аж. Учир нь экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний зах зээлийн үнэ Засгийн газрын тогтоосон жишиг үнээс хямд байгаа. Энэ талаар Н.Эрдэнэмядаг “Жишиг үнийг зөвхөн Монголд тогтоогоод байгаа юм биш. Казахстан, Индонезд ч гэсэн жишиг үнэ бариад явж байна. Хэрэв зах зээлийн үнэд бодит өөрчлөлт ороод, горимын дагуу явж байвал бид үүнийг өөрчлөх бүрэн боломжтой. Гэтэл манайд үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниуд бүтээгдэхүүнээ өөр өөр үнээр борлуулдаг. Бид тэдгээр үнийг жишээд тухайн ханшийг гаргасан” гэлээ. Тэгэхээр жишиг үнийн бодлого уян хатан болж таарах нь. Тэгтэл дэлхийн жишгээр явж буй энэ бодлого дотоодын жижиг гэлтгүй томоохон компаниудын нуруун дээрх ачааг улам бүр хүндрүүлж байгааг юу гэж ойлгох вэ. Тухайлбал, угаасан нүүрсээ 46 ам.доллараар экспортолж буй “Энержи Ресурс” 75 ам.долларын жишиг үнэ тооцуулж татвараа төлж байгаа бол МАК тонн тутмыг 80 ам.доллараар борлуулах угаасан нүүрсний экспортдоо 96 ам.доллараар тооцсон татвар төлж байна. Алдагдалтай атлаа ашиг олсон мэт төлбөр ногдуулж байгаа нь тэдний “амьсгал хураахыг” хүлээхтэй адил. Үндэсний томоохон гэгдэх компаниуд ийн татварын өрийн дарамтад орсоор байхад хөлөө олох гэж буй “шинэков”-уудын тавилан шийдэгдсэн мэт. Өнөөдөр тэд цаг наашлахыг хүлээхээс өөр итгэлгүй сууна. Үүнээс гадна уул уурхайн компаниудын хамгийн их мөнгө зардаг шатахуун, ус, цахилгааны төлбөрт хэт өндөр татвар ногдуулдаг нь салбарынхныг тал бүрээс нь “зулгааж” буй хэрэг гэдгийг Н.Алгаа онцлов.

Өнгөрсөн онд экспортын орлогын 51 хувийг бүрдүүлж байсан нүүрсний экспорт өдгөө 10 сая орчим тонн болтлоо татарсан. Энэ нь Монголын нүүрсний нөөц багассантай бус нийлүүлэгчид нь зах зээлд өрсөлдөх

хүчгүй болсонтой шууд холбоотой.

Бодлогогүй бодлого

“Татварын сайн тогтолцоо хүлээн авагч улсын хууль эрх зүйн орчны чухал үзүүлэлт” хэмээн Нидерланд улсын Гадаад харилцааны сайд онцолсон байдаг. Харин Монголын уул уурхайн салбарт үйлчилж буй татварын тогтолцоонд хувийн хэвшлийнхний өгч буй үнэлгээ “F”. “Уул уурхайн салбарт нийцсэн бодлого алга” эсвэл “Муу байна. Тэр дундаа эдийн засгийг хөдөлгөж буй салбарынх нь татварын бодлого хамгийн муу нь” хэмээн салбарын төлөөлөгчид гомдоллодог. Тэд төрийн бодлого төрдөө, татварынх нь төсөвтөө үйлчилдэг тогтолцоо бизнест нэмэр болохоосоо илүү нэрмээс болж байгааг ч учирладаг.

Үндсэн хуульд заасан эрхийнхээ хүрээнд төр хувийн болоод нийтийн өмчийг хамгаалах үүрэгтэй. Гэтэл хувийнх, хувьсгалынх гэж алагчилж татварын хэмжээг ногдуулж байгааг дэмжлэг гэхэд бэрх. “МІН” группын ерөнхийлөгч Д.Жаргалсайхан “Уурхай ашиглаад 100 төгрөгийн ашиг оллоо гэхэд түүний хэдэн хувийг Монголд шингээх талаар бодох нь зүйтэй. Энэ нь заавал төрийн өмчийн хэлбэрээр байх албагүй. Үйлдвэрлэл, үйлчилгээ цаашилбал татвар хэлбэрээр байж болно шүү дээ. Гол анхаарах зүйл гэвэл эдгээр нь үндэслэлгүй байж болохгүй” гэсэн юм. Тэрбээр “Татварын бодлогыг сайжруулахаас гадна элэгдэл, хорогдлын бодлогоор хэмждэг барууны аргыг нэвтрүүлэх хэрэгтэй. Түүнээс биш ашгаа ч хүртэж амжаагүй байхад татвар авна гээд дайрч болохгүй” гэдгийг онцолж байлаа. Энэ асуудалд Н.Алгаа “Татварын тогтолцоог сайжруулахын тулд бодлогоо өөрчлөх шаардлагатай. Монголд бизнесээ дэмждэг, хөгжүүлдэг бодлого үгүйлэгдэж байна. Татварын хувь хэмжээ, дарамтыг багасгахад бизнес чөлөөтэй болдог. Хамгийн ойрын жишээ дурдахад алтны экспортод 68 хувийн татвар ногдуулсан. Энэ шийдвэр хувийн секторт хүнд цохилт болсон. Энэ их татварын дарамтын тэд дийлэхгүй шүү дээ. Эцэстээ энэ нь ямар ч татваргүй, хяналтгүй явдаг сүлжээний бизнесийг өөгшүүлсэн хэрэг болж хувирсан” гэв.

Татварын бодлогогүй бодлого энэ хүрээд зогссонгүй. Чөлөөт зах зээлд шинэ тоглогч болох зорилготой Монгол Улс 1990-ээд онд хөрөнгө оруулагчдад үүдээ цэлийтэл нээсэн. Гадаадын хөрөнгө оруулалт татах үүднээс Монголын Засгийн газар 30 гаруй оронтой Давхар татварын гэрээ хийсэн байдаг. Хамгийн сүүлд Нидерланд улстай ийм төрлийн гэрээг үзэглэж тус орноос санхүүжилт “хүүдийлэх” хүлээлттэй байлаа. Монгол Улсаас эх үүсвэртэй ашиг, орлогоос Засгийн газар 20 хувийн татвар авах учиртай. Гэтэл “Рио Тинто”-гийн харьяа “Turquoise Hill Netherlands” гэх мэт Нидерланд улсад бүртгэлтэй тоймгүй олон уул уурхайн компани ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болоод үйлчилгээний орлого, хүүгийн орлогын татвар зэргээс мултарч байсан нь манай улсыг “молигодсон” хэрэг болсон.

Олон улсын валютын сан, Олон улсын эдийн засаг, хамтын ажиллагааны байгууллага мөн Үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагааг судалдаг олон улсын SOMO байгууллагаас “Нидерланд, Монголын хамтарсан Давхар татварын гэрээ нь Монголын татварын орлогод сөргөөр нөлөөлж байгаагаас үзвэл бусад оронтой хийсэн 30 гаруй ийм төрлийн гэрээг дахин хянах, заримыг нь цуцлах хүртэл арга хэмжээ авах шаардлагатай” гэсэн судалгааны тайлан гаргасан байдаг. Түүнчлэн хөгжиж буй Бразил, Казахстан зэрэг 28 оронд үйл ажиллагаа явуулдаг Нидерланд улсад бүртгэлтэй үндэстэн дамнасан корпорациуд Давхар татварын гэрээний ачаар жилд нэг тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний татварын төлбөр хэмнэдэг болохыг дурдсан байна. Хожуу ухаарсан монголчууд 2011 онд Нидерланд, Люксембург, Кувейт болон Арабын Нэгдсэн Эмират улстай хийсэн тус төрлийн гэрээнүүдийг цуцалсан юм.

Тэгээд...

Дээрх мэт бодлоггүй алхмынхаа балгаар “тогтворгүй” нэр зүүсэн Монголын Засгийн газарт өнөө, маргаашаа аргацаах байдлаар хөгжилд хүрэхгүй. Татварын тогтолцоог сайжруулж, олон улсаас төвлөрүүлж чадаагүй татварын алдагдлаа дотоодын хэдэн компаниийн “амиар” бүү нөхөөч гэдгийг хэн хүнгүй хэлдэг. Чухам яаж вэ гэдэг дээр маргасаар.

Татварын ерөнхий газрын харьяа Улсын төсвийн орлого, хяналтын газрын Эрдэс баялгийн татварын хэлтсийн дарга Н.Эрдэнэмядаг “Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай уулзалт хийж, санал бодлыг нь сонсдог. Тэдний саналд үндэслэн бодлогоо тодорхойлох, сайжруулахын төлөө явж байна. Татварын тогтолцоонд сайжруулах зүйл байгаа гэдэгтэй санал нэгдэнэ. Татвар төлөгчид ийн хэлж буй нь зөв. Энэ дагуу бид шат дараатай арга хэмжээ авч байна” гэлээ. Мөн тэрбээр “Уул уурхайн салбарт татварын бодлогыг сайжруулахын тулд татвар төлөгчтэйгөө нягт хамтран ажиллах нь нэн тэргүүний гарц байх болов уу. Хоёрдугаарт, туршлага хуримтлуулах буюу олон улсын алдаа оноог нь судлах явдал. Гуравдугаарт, боловсон хүчнээ чадваржуулах. Эдгээрийг шийдвэрлэж байж татварын тогтолцоо сайжирна” хэмээсэн юм.

Хувийн хэвшлийнхний зүгээс Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн дээрх асуудлуудыг бодлогын бичиг баримтад зангидах нь зүйтэй хэмээн холбогдох сайд нарт үүрэгдсэнд ам сайтай байна. Гагцхүү үр дүн нь зөв байгаасай хэмээн хүсэж байгаагийн зэрэгцээ бичиг баримт гаргачихаад түүнийгээ зөрчдөг, хариуцлага хүлээдэггүй тогтолцооны нэг жишээ бүү болоосой хэмээн ажиж буй.

Уул уурхайд түшиглэсэн өндөр өсөлттэй эдийн засаг өнөөдөр огцом газардаад байгаа энэ үед зөвхөн уул уурхайн салбарынхан ч гэлтгүй Монголын хувийн хэвшлийнхэн засаг төр бизнесийн орчныг зөвөөр ойлгож зохицуулж, журамлаж, татварын уян хатан бодлого тогтоогоосой, бага орлоготой, үйл ажиллагаагаа дөнгөж эхэлж буй компаниудыг хөл дээрээ бостол татварын олон давхар хураамжаар бүү дарамтлаасай гэсэн хүлээлттэй сууна. ■

АСУУДАЛ

БИД ӨВДЖЭЭ



Б.ТУЯА

Дэлхийн зах зээл гэх нүсэр айлын нялх жаалуудын нэг Монгол Улсын хувьд суралцах зүйл их. Тус айлын “хайртай хүү” нь болох боломж манай улсад бүрэн бий. Гэвч хөлд ч ороогүй атлаа гүйх гэж зөрүүдлэх нь манай улсын эдийн засгийн эрүүл мэндэд уршиг удаж байна. Олон улсын судлаачдын үздэгээр баялагт суурилсан эдийн засагтай орнуудад тулгардаг хамгийн нийтлэг алдаа бол тухайн улсын хууль эрх зүйн болон бизнесийн орчны тогтворгүй байдал мөн эх орны баялгаа үндсэрхэг үзлээр “хамгаалах” гэсэн оролдлого байдаг аж.

Уул уурхайд түшиглэх орнууд “Голланд өвчин”-өөр өвдөх нягууртай гэдэг. Тэгвэл “Голланд өвчин”-ийг анагаах ухааны вирустай адилтган бодвол дундад зуунд хөгшин Европт дэлгэрсэн тахалтай ижил аж. Олон улсад “дундад зууны” хэмээгдэх тус өвчнөөр монголчууд хэдэн жилийн өмнө өвдсөн. Харамсалтай нь үүнээсээ илааршиж амжаагүй байхад өөр нэг халдвар авсан нь “Resource nationalism” буюу үндсэрхэг үзлээр эх орныхоо хөгжлийн гарцыг боох алдаа юм. Өвчний тэргүүний хам шинж нь тухайн орны Засгийн газрын өр зузаарсан эсвэл уул уурхайн бүтээгдэхүүний үнэ тэнгэрт хадаж эхлэхэд хууль эрх зүй болон бизнесийн салбар дахь Засгийн газрын оролцоо ихсэх хэлбээр илэрдэг. Иймхүү уул уурхайн салбарын татварын хувь хэмжээ, төрлийг үндэслэлгүй нэмэх, экспортын өндөр хураамж авах, “зөвшөөр эсвэл яв” гэсэн шаардлага тавих зэргээр Засгийн газар үндсэн үүргээ зөрчсөн үйлдэл гаргадаг болохыг “Ernst and Young Global” компанийн “Business risks facing mining and metals 2012-2013” судалгаанд дурджээ.

Манай улсад уул уурхайн бүтээгдэхүүн стратегийн чиглэлтэй болохоос өмнө, тухайлбал 1950-1970 оны үед Чили, Мексик тэргүүтэй Америк тивийн орнууд, Кувейт, Катар зэрэг Арабын орнууд “Resource nationalism”-ээр халдварлаад авсан. Улмаар эрчим хүчний эх үүсвэр газрын тос, нүүрсний зах зээлийн “хойморт” суух хүсэл нь эдийн засгийн бүтэлгүйтэл болж, тэд хатуухан сургамж авсан билээ. Мэдээлэл сайтай хүн амжилтад ойр байдаг гэдгийн дагуу дэлхийн бусад орон ч тэдний алдаанаас суралцаж өөрсдийгөө “вакцинжуулж” байлаа.

Монгол өдгөө дээрх орнуудын жимээр юу ч мэдэлгүй эсвэл мэдсэн ч үл ойшоон алхана. Нийтлэлч Баабар “Түүхий эдтэй орон нэг ч төгрөг гаргалгүйгээр татвар, роялти, газрын болон ашиглалтын төлбөрөө стандартаар аваад явахад буй болсон ашгийн тэн хагасыг хүртдэг аж” хэмээн нэгэн нийтлэлдээ дурдсан байдаг. Гэтэл манай төр засгийн “шунал” арай өөр зүйл хүсэх.

Дээрх үзлийг өөгшүүлэгч бас нэгэн хүчин зүйл бол чадваргүй боловсон хүчин. Чили улс “Resource nationalism” өвчнөөр удаан шаналаагүй. Учир нь тэдэнд олон жилийн туршлагаас гадна мэргэшсэн боловсон хүчин байв. Харин манайд газрын хэдэн зуун метрийн гүнд орших баялгаас өөр юу байна вэ.

Дэлхийн уул уурхайн салбар 2020 он гэхэд ажиллах хүчний хомсдолд орох аж. Хомсдолын шинж тэмдгүүд Австрали, Өмнөд Африк, Канад зэрэг уул уурхайн томчуудад хэдийнэ илэрсэн. “The Mining Industry Human Resource Council” олон улсын байгууллагын судалгаагаар дэлхий даяар уул уурхайн салбарт ажиллаж буй нийт хүний 60 мянга нь 2020 он гэхэд тэтгэвэрт гарах аж. Харин тэдний орон зай болоод тухайн үеийн хэрэгцээг нөхөхийн тулд 100 мянган шинэ ажилчныг бэлтгэх хэрэгтэй гэнэ. Түүнчлэн газрын тосны салбарт 2014 он гэхэд 24 мянган ажиллах хүч шаардлагатай болох талаар Канадын “Petroleum Human Resources Council”-аас анхааруулжээ.

Ингээд үзэхэд манай улсын уул уурхай болон төрийн удирдлагын өнөөгийн байдал 1950-иад оны дэлхийн уул уурхайн салбарын үед хүрээд гацчихаж. Хэрэгцээт технологи, хүний нөөцгүй атлаа “хүсэхгүй бол яв” хэмээн зөрүүдлэн сууна. Үүний балагаар Монголд өгөөжөө өгөөд эхлэх байсан хэд хэдэн томоохон төсөл гацаанд орж, хөрөнгө оруулахад бэлэн байсан гаднын бизнесмэнүүд ачаагаа баглаад эхэлжээ. Нийтлэлч Баабарын хэлснээр олон улсын стандартаар эхэлсэн процесс нутгийн “эх оронч” жимээр хөгжин эцэст нь ард түмэн хоосордог аж.

Энэ бүх “амбийц”-ийн дүнд бусдад сургамж болох гашуун түүх л Монголд үлдэх вий. ■

Уул уурхайн салбарын ТОП 10 эрсдэл

2008	2012
1. Чадварлаг боловсон хүчний дутагдал	1. Ресурс национализм
2. Салбарын уналт	2. Чадварлаг боловсон хүчний дутагдал
3. Дэд бүтэц	3. Дэд бүтэц
4. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	4. Зардлын инфляци
5. Цаг уурын өөрчлөлт	5. Төслийн гүйцэтгэл
6. Үнийн өсөлт	6. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
7. Боловсруулалт багасах	7. Үнэ болон валютын тогтворгүй байдал
8. Ресурс национализм	8. Менежментийн асуудал
9. Эрчим хүчний баталгаат хангамж	9. Хувь эзэмшил, орлогын хуваарилалт
10. Төрийн зохицуулалт нэмэгдэх	10. Авлига, хээл хахууль

Уул уурхайн салбарт сүүлийн таван жилд эхний 10-т багтаж буй эрсдэлүүд

Эх сурвалж: “Ernst and Young Global”



DISCOVER MONGOLIA

МОНГОЛ УЛС ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДГҮЙГЭЭР УУЛ УУРХАЙГАА АШИГЛАЖ ЧАДАХ УУ

Монголын баялаггүй бол дэлхий өлсөх үү

Дэлхийн улс орнууд ашигт малтмалаа олборлож, ашигласаар хэдэн зууныг үдэж буй. “ABS and MinEx Consulting” байгууллагын тооцоолсноор 2000-2010 онд дэлхий даяар дунд зэргийн 485, манай “Эрдэнэт” шиг 245, Оюутолгой шиг 47 орд нээсэн гэнэ. Ганцхан Монголд л том орд нээгдээд байгаа юм биш гэдгийг дээрх тоо харуулав. Ийм байтал Монголын баялаг байхгүй бол дэлхий нийт турж үхэх юм шиг аяглаж байгаа нь хэр зөв бол? Монголын Оюутолгой, Тавантолгойтой толгойгүй улс орнууд хөгждөгөөрөө хөгжинө.

Дэлхий даяар нэг жилд 40 орчим тэрбум тонн ашигт малтмал, газрын тос олборлодог гэх тоо бий. Үүний хажууд Монголын гаргаж байгаа бүтээгдэхүүний хэмжээ далайд дусал төдийхөн. Энэ оны эхний долоон сарын байдлаар Монгол Улс 3.4 тонн алт, найман сая тонн нүүрс экспортолсон. Мэдээж өөр төрлийн эрдэс экспортолдог ч тэр нь их биш. Энэ оны эхний улирлын байдлаар Монгол Улсын ДНБ өнгөрсөн оны мөн үеэс 7.2 хувиар өссөн нь гурван жилийнхээ хамгийн муу үзүүлэлтэд очоод буй.

Эрчээ аваад байсан Монголын эдийн засгийн өсөлтийн хурд саарч байгааг батлах тоо үүгээр зогссонгүй. Эдийн засаг агшихад нүүрсний үнэ буурсан, БНХАУ-ын эрэлт багассан нь нөлөөлсөн тухай Уул уурхайн сайд саяхан дуулгасан. Урд хөршийн эрэлт багассан нь үнэн хэдий ч тус улсад бүтээгдэхүүнээ нийлүүлэхээр Монголтой өрсөлдөж буй орны тоо олширсон хэрэг.

Үүлэн чөлөөний нар

Уул уурхайн сайдын “Хэт халсан эдийн засаг аажмаар хөрж, өсөлт хэвийн, тогтвортой түвшиндээ эргэн ирж байгаа бодит байдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй” гэсэн үгс биднийг “зүүднээс сэрээв”. 2010 онд Австралид үер болсны “ачаар” тус улсын нүүрсний нийлүүлэлт огцом буурсан. Ийнхүү “хар алт”-ны эрэлт өсөж, нийлүүлэлт хумигдсан даруйд үнэ өсөх нь тэр. Энэхүү үүлэн чөлөөний нарнаар Монголын нүүрсний экспорт хүчээ авч, эдийн засаг ч 17 хувиар өссөн билээ. 2011 онд манай улсын “хар алт”-ны экспорт 27.5 хувиар нэмэгдэн, 21.3 сая тоннд хүрснийг “The Sydney Morning Herald” сонинд “Монгол БНХАУ-ын нүүрсний импортын зах зээлийг Австралиас булааж байна” гэж бичиж байлаа. Одоо бол Австрали, Мозамбик, ОХУ урд хөрш дэх нүүрсний нийлүүлэлтээрээ Монголын өмнө явна. Бидний хамгийн том өрсөлдөгч Австралийн нүүрсний олборлолт сэргэн өмнөх байр суурия эзлэв. Дээрх улсууд БНХАУ-ын “ааш”-ийг дагасан бодлого баримтлах болсон гэлтэй. Зах зээл дэх нүүрсний үнэ эргэн өсөж бидэнд таатай нөхцөл бүрдсэн ч Мозамбик, Канад, Австралийн орон зайг эзлэх нь юу л бол. Тэдгээр улсаас БНХАУ-ын далайн тээврээр боомт дээр ирж буй тонн нүүрсний тээвэрлэлтийн зардал хол, ойроосоо шалтгаалан 15-25 ам.доллар байгаа аж.

Харин манай улсын хувьд Ганц

модны боомт дээр аваачихад л 20 орчим “ногоон” зарцуулна. Иймээс БНХАУ-тай шууд хил залгаа ч зах зээл дэх сайн өрсөлдөгч болж чадахгүй байна. Монгол нүүрсээ боловсруулж, БНСУ, Япон руу гаргана л гэх. БНХАУ-ын Нүүрсний үйлдвэрлэлийн ассоциацынхан нүүрсээ нийлүүлэх гэрээг Азийн орнуудтай хийсэн сурагтай. Ер нь уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурах мөчлөгийн үед тэсэж үлдэх бололцоогоо улс орнуудын Засгийн газар урьдчилан хардаг аж. Угаасаа урд хөрш нүүрсний асар их нөөцтэй учраас бидэнд хадаг барин ирэхгүй нь мэдээж. Том тоонд дасаж эхлээд байсан монголчуудын хувьд эдийн засгийнхаа 20, экспортын орлогын 90 хувийг бүрдүүлдэг уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчид руу хялайх нь алдагдалтай гэдгийг уруудаж буй үзүүлэлт бэлхнээ харуулж байна. Тухайлбал, энэ оны эхний хагасын байдлаар Монгол Улсад бүртгэгдсэн шууд хөрөнгө оруулалт өмнөх оныхоос 43 хувиар буурсан. Иймээс 2013 оны уул уурхайн салбарын орлогын төлөвлөгөөг хэт өөдрөг төсөөлснөө хүлээн зөвшөөрөх хэрэгтэйг салбарын сайд нь мэдэгдээд байгаа.

Монгол Улс энэ онд 30 сая тонн нүүрс борлуулна гэж зарласнаа 20 болгон бууруулсан. Харин одоо бол 10 саяас хэтрэхгүй төлөв харагдаж байгаа. 1997 онд дэлхийн хайгуулын хөрөнгө оруулалтын нэг хувийг татах юмсан гэж монголчууд мөрөөдөж суусан гэдэг. “Metals Economics Group”- ийнхний тооцсоноор, 2004 онд дээрх тоо дөрвөн хувьд хүрсэн нь том амжилт ч 2011 оны байдлаар дэлхийн уул уурхайн хайгуулын зардлын 18 хувь нь Канад, нийман хувь нь АНУ, таван хувь нь Чили, 13 хувь нь Австрали, зургаан хувь нь Өмнөд Африкт ногдсон гэх судалгаа гарчээ. Дэлхийн уул уурхайн салбарт хийж буй хөрөнгө оруулалтыг бүртгэдэг тус байгууллагын тооцоолсноор 2011 онд урд хөрш дээрх салбартаа 611 сая ам.доллар татсан байх юм. Товчхондоо, хөрөнгө оруулагчдын “хараа”-нд зөвхөн Монгол өртдөггүй аж. Гадаадын томоохон компаниуд бусад оронд дор хаяж 3-4 төсөл хэрэгжүүлдэг юм байна. Нэг төслөөс олсон мөнгөөрөө нөгөөхөө санхүүжүүлдэг зарчмаар уул уурхайн бизнес хөгждөг нь зүй тогтол. Монголчуудтай хэл амаа ололцохгүй байгаа “Rio Tinto” дэлхийн зургаан тивийн 40 улсад хөнгөн цагаан, зэс, алмаз, эрчим хүч, төмрийн хүдэр, нүүрс, уран, алтны олон төсөл хэрэгжүүлж ирсэн түүхтэй.

Би биш бол өөр хэн ч биш

Дэлхийд алдартай Жонс Хопкинсын их сургуулийн эдийн засгийн лекцийн үеэр “resource nationalism”-аар “өвчилж”, эдийн засаг нь суларсан орнуудын жишээг дурдахад Венесуэл, ОХУ, Казахстан зэрэг улстай зэрэгцэн Монгол багтчихсан байна гэнэ. ОХУ нь цэргийн их хүчтэй, том гүрэн, харин Венесуэлийн уул уурхайн салбар олон жил хөгжөөд, өндөр технологитой болж амжсан бол Монголд үндсэрхэх үзлийн “өвчний” эсрэг ямар ч хамгаалалт байхгүй аж. Тэгэхээр Голланд улсаар “овоглодог” өвчин байдаг шиг Монголын тодотгол “resource nationalism” болж магадгүй юм. Одоогоор уул уурхайн баялгаа өөрсдөө ашиглах хөрөнгө, техник технологи, туршлага бидэнд алга. Ямар ашигт малтмалаа хүрзээр зөөлтэй биш. Газрыг нэг метр тууш өрөмдөхөд л 100-120 ам.доллар зарцуулдаг гэх тооцоо бий. Эрсдэл их, зардал өндөр энэ салбарт хөрөнгө оруулагчдыг орж ирэхэд нь “дээрэлхэх” нь хэр зөв бэ. Тоглоом эхэлчихсэн байхад дүрмийг нь өөрчилж, Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг богино хугацаанд баталсан нь өнөөх “resource nationalism” өвчин туссаныг батлах шиг. Уул уурхайдаа оруулах хөрөнгө оруулалт нь байхгүй байхад монголчууд “Би биш бол өөр хэн ч биш” гээд ийнхүү гэдийж сууна. Дэлхийд том тооцогдох “BHP Billiton, “Vale” Монголыг орхиж явсан. Гаднынхан манайд орж, гарах нь чухал бус хөрөнгө оруулалтыг нь Монголд “аргамжиж” үлдээх нь чухал биш гэж үү.

Гинжин өр ба зүсээ хувиргасан бонд

Оюутолгойн экспорт, “Чингис” бондоос санхүүжих төслийн ачаар манай улсын ДНБ өснө гэсэн гэнэн мөрөөдөл цөөнгүй хүнд бий. Гэтэл Оюутолгойн үнэ цэнийн 80 хувийг агуулах далд уурхайн бүтээн байгуулалтын ажил таг зогсчихоод байна. Мөн бондын мөнгөнөөс санхүүжих төслүүд үр ашгаа богино хугацаанд өгөх боломжгүй. Гадаадын хөрөнгө оруулалт багассанаас үүдэн ам.доллар “ховрын бараа” болов. Энэ нь инфляцид нөлөөлөхгүй гэх баталгаа хаана байна? ОХУ биднийг өрөвдөөд газрын тос нийлүүлэх үнээ хэвээр байлгасан ч төлбөрөө бид “ногоон”-оор хийх учраас ханшийн зөрүү бензиний үнийг хөөрөгдөхийг үгүйсгэх аргагүй. Улмаар өргөн хэрэглээний барааны үнэ өсөх гээд үр нөлөө нь гинжин хэлбэрээр “халдварлана”.

Саяхан Уул уурхайн яамны Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга “Валютын ханш шатахуун импортлогч компаниудад хүндээр тусаж байгаа. Гэхдээ бид компаниудтай байнгын холбоотой байгаа. Түр зуурын валютын ханшийн өөрчлөлтөөс улбаалан үнээ шууд өсгөхгүй байх талаар компаниудтай тохирсон” гэж ярьсан байна билээ. Шатахуун импортлогч компаниуд хэр удаан “гүрийж” чадах юм бол. “Монгол нүүрс” ассоциацийн гүйцэтгэх захирал Т.Наран “Зах зээл судлаачид өрсөлдөх чадварын хувьд Монголыг худалдан авагчид ойр, ашигт малтмалын чанар өндөр, ардчилсан засаглалтай хэмээн үнэлдэг” тухай ярьж байв. Нөгөөтэйгүүр, БНХАУ эдийн засгийн өсөлтөө хангахад 48 төрлийн ашигт малтмал хэрэгтэй байдгаас 27-г нь дотоодоосоо 100 хувь хангаж чаддаггүй юм байна. Үлдэх 21 төрлийн ашигт малтмалыг гадаадаас авдгийн тодорхой хэдэн төрөл нь Монголд бий аж.

Хөрөнгө оруулалтгүйгээр бид юу хийж чадах вэ. Бонд гаргаж мөнгөтэй болсон нь гаднынхны мөнгийг авчирч байгаа хөрөнгө оруулалтын “зүсээ” хувиргасан нэг хэлбэр. Гаднынхан уул уурхайн салбарт эрсдэлээ үүрээд хөрөнгөө оруулах бол Монгол Улс бондын мөнгөө тогтсон хугацаанд хүүтэй нь төлөх учиртай. Хөрөнгө оруулагчдыг хөөсөн, “савчсан” бодлого барьсаар байвал тэд Монгол руу дахин зүглэхгүй. Монгол ганцаараа уул уурхайн баялагтай нь биш шүү дээ. ■

Эх сурвалж:
“Өнөөдөр” сонин.

ИНФО ГРАФИК

ДЭЛХИЙГ ХӨДӨЛГӨГЧ АФРИК

Б.ЖАРГАЛ

Хамгийн ядуу гэх нэрийг олон зууны туршид “өргөн” яваа Африк тив угтаа бол тун баян. Иймч учраас дэлхийн эдийн засгийн хөдөлгөгч хүч болдог аж. Зөөврийн компьютераас эхлээд гар утас, автомашин, нисэх онгоц гээд бидний амьдралд энгийн үзэгдэл болсон бүтээгдэхүүний гол түүхий эдийн дийлэнх хувийг тус тивээс олборлодог байна. Тэгэхээр дэлхийн хөгжил Африкаас улбаатай гэхэд хэтрүүлсэн хэрэг болохгүй болов уу.

Африкийн байгалийн баялаг тус тивийн орнуудын экспортын чухал хэсгийг бүрдүүлдэг. Энгийн ардад төдийлэн хүртээлгүй байдаг ч байгалийн баялаг ихтэй тус тивийн эдийн засгийг дэмжих тулгуур болдог нь гарцаагүй.

АВТО МАШИН

Өдөр тутмын амьдралаа авто машингүйгээр төсөөлөхөд бэрх болжээ. Түүнээс ялгарах агаар бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах зорилготой катализаторт цагаан алт болон роди орсон байдаг аж. Эдгээрийн гол экспортлогч нь Африк юм.





1.411
унци цагаан алтны зах зээлийн ханш /2013 оны долдугаар сар/

1.000
унци родийн зах зээлийн ханш /2013 оны долдугаар сар/


дэлхийн үйлдвэрлэлд эзлэх хувь




128
метрик тонн /цагаан алт/ 2012



170
тонн алт 2012



8.2M
карат очир алмаз 2011



255M
метрик тонн нүүрс 2011



Тухайлбал, Өмнөд Африк дээрх үнэт металлын гол нийлүүлэгч төдийгүй алт, очир эрдэнэ, нүүрс болон төмрийн хүдэр боловсруулдаг аж.

Сүүлийн 10 жилийн хугацаанд тус улсын уул уурхайн салбар ДНБ болон экспортын орлогод 200 тэрбум ам.доллар оруулсан байна. Түүнчлэн 513 мянган иргэнийг ажлын байраар хангажээ.



513.000
хүн уул уурхайн салбарт ажилласан /2011 он/

408 тэрбум
ам.долларын үндэсний нийт бүтээгдэхүүн /2011/

ГЭРЭЛ ЦАХИЛГААН

Эрчим хүч, цахилгаангүй амьдралыг төсөөлөхийн аргагүй. Тэгвэл Африкийн орнууд эрчим хүчний эх үүсвэр болох нүүрс, байгалийн хий төдийгүй дэлхийн ураны хэрэгцээний 14 хувийг бүрдүүлдэг.



дэлхийн үйлдвэрлэлд эзлэх хувь

НИГЕРИ 8%

НАМИБИ 6%

МАЛАВИ 2%

38 ам.доллар/фунт

ураны оксидын зах зээлийн ханш /2013 оны долдугаар сар/

Намиб улсын хувьд эдийн засаг нь уул уурхайн бүтээгдэхүүний экспортоос шууд хамааралтай. Уранаас гадна цайр, алмаз эрдэнэ нийлүүлдэг аж. 2011 онд тус улсын алмаз эрдэнийн экспорт 714 сая ам.доллараар хэмжигдсэн бол ураны нийлүүлэлт 558 сая ам.долларт хүрчээ. Ийнхүү тус онд Намибийн уул уурхайн салбарын бүтээгдэхүүний экспорт улсынхаа ДНБ-ий найман хувийг бүрдүүлсэн байна.

12.5 тэрбум ам.доллар

Дотоодын нийт бүтээгдэхүүн /2011 он/

ҮНЭТ ЭДЛЭЛ

Очир эрдэнэ буюу алмаз нь зөвхөн эмэгтэйчүүдийн сайн найз биш аж. Эдийн засгийн “best friend” болж буй эл эрдэнийн дэлхийн нийт хэрэглээний талаас илүү хувийг үйлдвэрлэдэг Африк тив дэлхийн цагаан алтны хэрэгцээний дөрөвний гурвыг хангадаг.



дэлхийн үйлдвэрлэлд эзлэх хувь

БОТСВАНА 19%

ЗИМБАБВЕ 16%

КОНГО УЛС 7%

ӨМНӨД АФРИК 7%

АНГОЛ 7%

БУСАД 1%

6.270 ам.доллар

4/4 карат алмаз зах зээлийн үнэ

Ботсвана улс нь үнэт чулууны үйлдвэрлэлээрээ дэлхийн хоёр дахь том нийлүүлэгч. Дундаж орлоготой улсын тоонд багтах эл улсын эдийн засаг алмазны аж үйлдвэрт тулгуурладаг. 2011 онд тус улсын төсвийн орлогын тал хувийг тус салбар бүрдүүлжээ.

17.3 тэрбум

ам.доллар ҮНБ

22.8 сая

карат алмаз /2011

4.34 тэрбум

ам.доллартай тэнцэх алмазны экспорт

75 хувь

алмазны экспортын ашиг

ЗАЙ


Дэлхий нийт дахивар бүтээгдэхүүн хэрэглэхийг эрмэлзэх болсонтой холбоотойгоор дахин цэнэглэх боломжтой зай (цэнэг хураагуур) түлхүү ашиглах болсон. Эл бүтээгдэхүүний “амь” болох кобальт мөн Африк тивээс гарах бөгөөд зах зээлийн асар их эрэлтийг бий болгож байна.



дэлхийн үйлдвэрлэлд эзлэх хувь



13.50 ам.доллар/фунт
кобальтын зах зээлийн ханш /2013 оны долдугаар сар/



52.000
метрик тонн кобальт /2011/



19.25
сая карат алмаз /2011/



60-95
метрик тонн тантал /2011/



1.4 сая *хүн гар урлалын салбарт ажилласан*



Кобальтын нийлүүлэлтээрээ тэргүүлэгч Бүгд Найрамдах Ардчилсан Конго улс 2010 онд ДНБ-ийхээ 15.5 хувийг ашигт малтмалын орлогоор бүрдүүлсэн байдаг. Энэ нь 8.48 тэрбум ам.доллартай тэнцэх бөгөөд үүний 50 хувь нь кобальтын экспортоос оржээ.

15.7 тэрбум
ам.доллар үндэсний нийт бүтээгдэхүүн

НИСЭХ ОНГОЦ


Нисэх онгоцыг бүтээснээр дэлхийг хэрэх аялалын зам тэлэх болсон. Шувуу мэт нисэх хүмүүний хүслийг “биелүүлсэн” эл тээврийн хэрэгслийн хөдөлгүүрт кобальтаас гадна хромит ашигладаг. Түүнчлэн онгоцны ихэнх хэсгийг хөнгөн цагаанаар хийдэг билээ.





2.42 ам.доллар/кг
төмөр хромын хайлшны зах зээлийн ханш /2013 оны долдугаар сар/

0.8 ам.доллар/фунт
хөнгөн цагааны зах зээлийн ханш /2013 оны долдугаар сар/




52.000
метрик тонн кобальт /2011/



19.25
сая карат алмаз /2011/



60-95
метрик тонн тантал /2011/




Дэлхийн хөнгөн цагааны хүдрийн 50 орчим хувийг үйлдвэрлэдэг орон бол Гвиней. Үүгээр ч зогсохгүй төмрийн хүдэр, алт, алмаз эрдэнийн арвин нөөцтэй гэгддэг. 2011 онд тус улсын экспортын орлогын 95 хувийг бүрдүүлсэн ашигт малтмалын салбар нь ДНБ-ийхээ 25 хувийг даажээ. Ирэх 10 жилд тус улсыг дэлхийн төмрийн хүдрийн зах зээлийг “атгана” хэмээн таамагласан.


5 тэрбум
ам.доллар Дотоодын нийт бүтээгдэхүүн /2011 он/

ЦАХИЛГААН БАРАА

XXI зууны залсшгүй нэг хэсэг болсон цахилгаан барааны эд ангийг тантал хэмээх төмөрлөгөөр хийдэг аж. Африкийн зарим орны экспортын гол бүтээгдэхүүн болсон энэ төрлийн төмөрлөг нь Мозамбик улсад их хэмжээгээр байдаг. Гэсэн ч тус улсын эдийн засгийн тулгуур нь газар тариалан болж байгааг судлаачид онцолж байна.



дэлхийн үйлдвэрлэлд эзлэх хувь



262/кг
танталын хүдрийн зах зээлийн ханш /2013 оны долдугаар сар/



90-260
метрик тонн тантал /2011/



500
кг алт /2011/



600.000 *хүн гар урлалын салбарт ажилласан*


Мозамбик нүүрсний нөөц ихтэй. Түүнчлэн 2011 онд тус улсын хойд эрэгт их хэмээнний байгалийн хийн орд илрүүлсэн нь дэлхийн анхаарлын төв болж гадаадын хөрөнгө оруулалт татаж эхэлсэн. Йинхүү тус улсын эдийн засагт эерэг хүлээлт үүсгээд буй.




12.8 тэрбум
ам.доллар Дотоодын нийт бүтээгдэхүүн

ГАЗРЫН ТОС

2012 онд Африк тив дэлхийн газрын тосны аравны нэгийг нийлүүлсэн байдаг. Энэ нь өдөрт 9.4 сая баррель гэсэн үг юм.





102.47 ам.доллар/баррель
танталын газрын тосны зах зээлийн ханш /2013 оны 7 сар



2.5 сая
баррель газрын тос /өдөр/




80%
Газрын тосноос Засгийн газрын олсон ашиг



95%
газрын тосноос олох гадаад валют солилцооны ашиг

2011 онд л гэхэд тивээ төлөөлж Нигер улс дэлхийн газрын тосны хэрэгцээний гурван хувийг хангасан. Энэ нь тус улсын ДНБ-ий 15 хувийг бүрдүүлжээ.

Нигер улсын газрын тосны батлагдсан нөөцийг 37 тэрбум баррель гэх бөгөөд энэ нь 40 жилийн хэрэгцээг хангахуйц хэмээн тогтоожээ.



244 тэрбум
ам.доллар ҮНБ



ОЮУТОЛГОЙ

ГҮНИЙ УУРХАЙ МОНГОЛД

Б.ТОГТОХ

Оюутолгойн далд уурхайн хөрөнгө оруулалт түр зогссон ч Монголд гүний уурхайг хөгжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага үүсээд буй. Зөвхөн Оюутолгой ч бус олон, олон Оюутолгой Монголд буй учраас тэр. Тиймээс Уул уурхайн яамнаас далд уурхайн аюулгүй ажиллагааны стандарт, зохих журам, дүрмийг шинэчлэх ажлын хэсгийг байгуулжээ. Тус ажлын хэсэг нь Монголд гүний уурхайг хөгжүүлэх, хариуцлагатай уул уурхайн үндсэн зарчимд нийцэж ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэхээр зорьж байгаа аж. Хэдий уул уурхайн салбар уналтад орсон ч эрх зүйн орчныг тодорхой болгох, шинэ үеийн уул уурхайг дэлхийн түвшинд хүргэхээр холбогдох яамнаас ийн анхаарал хандуулжээ. Мөн Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд ч гүний уурхайн аюулгүй ажиллагаа, нөхөн сэргээлт, олборлох эрхтэй холбоотой заалт багтаж буй.

Манай улсын хувьд далд уурхайн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн баримт бичиг хомс бөгөөд цөөн хэдэн журам, дүрэм одоогоор үйлчилж байна. Тэдгээр баримт бичиг нь олон улсын стандарт болоод зохих шаардлагыг хангаж чадаагүйн зэрэгцээ өнөөгийн нөхцөлд “балчирдах” аж. Тиймээс хуучин дүрэм, журмаа шинэчлэх, сайн туршлага, стандартаар баяжуулах нь зүй ёсных гэх. Уул уурхайн яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга Ч.Отгочулуу “Гүний уурхайг хөгжүүлэх асуудлыг бодлогын түвшинд дэмжиж байгаа. Яамны зүгээс хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх асуудалд тууштай анхаарна” гэв. ▸▸

Зөвхөн дүрэм

Далд уурхай Монголд шинэ сэдэв биш ээ. Налайх, Бор-Өндөр, Их хайрхан, Бүрэнцогт. Хамгийн сүүлийнх нь Оюутолгой. Гэхдээ бидний төсөөлж буй далд уурхай Налайхаас хэдэн арав дахин том байх юм. Уурхайд шаардлагатай нийт хөрөнгө оруулалт 5.1 тэрбум ам.доллар. Нийгэм, эдийн засгийн топ сэдэв болоод буй тус уурхайн гүн нь 1500 орчим метр бөгөөд тэнд уул уурхайн үйлдвэрлэл өрнөнө. Өөрөөр хэлбэл, газар дор сүндэрлэж буй нүсэр байгууламж Оюутолгойн төслийн өнөөгийн үнэ цэнийн 80 хувийг агуулж байгаа.

Оюутолгойн Хюго Даммет, Херугагийн ордыг далд уурхайгаар ашиглана. Уурхайн үндсэн шалгуур нь эдийн засгийн үр ашиг сайтай байх, экологийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдсан байх, хөдөлмөрийн өндөр бүтээмжтэй байх ёстой. Тиймээс Хюго Дамметийн ордыг ашиглах далд уурхайг нээхийн тулд уурхайн дөрвөн босоо ам барьж байна. Өмнө нь далд уурхайд блокчлон олборлох арга хэрэглэсэн туршлага манайд үгүй. Тэгвэл Оюутолгойд дэлхий нийтэд түгээмэл сонголт болсон блокчлон олборлох аргыг анх удаагаа хэрэгжүүлэх гэж байгаа нь энэ. Тиймээс алхам тутам аюулгүй ажиллагааны дүрэм үйлчилнэ гэсэн үг.

Газар доорх цайны газар

Газрын гүнд уулын чулуулгийг өрөмдөх, тэслэх, ачих, зөөх уурхайн босоо амаар татаж газрын гадаргууд гаргаж овоолох, ухсан хонгилоо бетондож бэхлэх зэрэг нарийн төвөгтэй, хүнд ажил газрын гүнд хийгдэх юм. Уг ажлыг гүйцэтгэхийн тулд бетон зуурмагийн үйлдвэр барих, газрын гадаргаас цэвэр агаар уурхайн гүнд шахах, сорох агааржуулалтын систем байгуулах, цахилгааны шугам сүлжээ татах гээд бишгүй ажил бий. Мөн төмөр зам конвейерийн болон авто тээврийн хэрэгслийг газрын доор байрлуулж ашиглуулах шаардлага ч гарсаар. Түүнчлэн газрын гүнд засвар үйлчилгээний газар, сэлбэгийн агуулах, цайны газар, эмнэлэгийн хэсэг, хоргодох байр гэх мэт байгууламж барих аж.

"Жилд 58 сая тонн, хоногт 160 мянган тонн хүдэр олборлох хүчин чадалтай Оюутолгойн Хюяго Дамментийн далд уурхай нь өндөр ур чадвар, инженерийн нарийн тооцоо, туршлага, дадлага шаардана" гэж "Оюутолгой: эрт, эдүгээ, ирээдүй" номонд өгүүлжээ. Монголд хамгийн гүн хүдрийн уурхай нь 320 метрийн гүнтэй Бүрэнцогтын уурхай байжээ.

"Оюутолгой" компаниас "Шинэ төгсөгчдийн хөтөлбөр" хэрэгжүүлдэг. Уг хөтөлбөрөөр шинэ төгсөгчдийг "Рио Тинто" компанийн бусад улсуудад байрлах томоохон уул уурхайд ажиллуулж, дадлагажуулж байгаа юм. Тус хөтөлбөрт хамрагдан Австрали улс дахь Рио Тинто компанийн Нортпаркес уурхайд мэргэжил дээшлүүлсэн С.Тамир "Нортпаркес уурхайд блокчлон олборлох арга хэрэглэдэг. Оюутолгойн далд уурхайд ч бас энэ аргыг ашиглана. Уг технологийг зөв ашиглаж чадвал хамгийн бага зардалтай. Гэхдээ маш их тооцоолол, хэрэгтэй. Газрын гүнд ажилчдаа эрсдэлээс хамгаалж, аюулгүй ажиллуулахын тулд маш нарийн тооцоо судалгаа хийх шаардлагатай байдаг. Далд уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө, явагдаж байхад ч, дуусахад ч байнгын тооцоолол судалгаа хийдэг онцлогтой. Бүтээгдэхүүн гаргах зорилготой ч аюулгүй ажиллагаа хамгийн том шалгуур" хэмээн ярьсан.

Аврах алба

Чили, Канад, Австрали. Дэлхийн уул уурхайн жишиг болсон эдгээр оронд далд уурхай хөгжин цэцэглэж, блокоор нураах аргыг өргөн ашиглаж байна. Энэхүү аргын давуу тал нь бүтээмж өндөр, ашиглалтын зардал бага, уурхайн хүчин чадлыг дээгүүр тогтоож болдог аж. Мөн олборлолт эхлэхийн өмнө хүдрийн биетийн бага хэсгийг өрөмдөж тэслэх юм байна. Сул тал нь эхний үеийн зардал их, уурхай байгуулах хугацаа урт байдаг аж. Тус аргыг 1800-аад оноос уул уурхайн үйлдвэрт хэрэглэж эхэлжээ. Үүнээс гадна 2000 жилийн өмнө эртний Ромчууд барилгын чулуулгийг олборлоходоо ашиглаж байсан сонирхолтой баримт бий.

Орчин үед блокоор нураах ашиглалтын системийг Австралийн Нортпаркес, Америкийн молибдений Хендерсоны уурхай, ОХУ, Чили, Индонезийн зэс, алтны уурхайд хэрэглэж байна. Гүний уурхайд ажиллах нөхцлийг хангах анхдагч эх үүсвэр нь цэвэр агаар. Тиймээс агааржуулалтын системийг маш нарийн тооцоолсон байдаг аж. Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүү "Далд уурхай нь байгаль орчинд ил уурхайгаас илүү хохирол багатай байдаг. Тиймээс Оюутолгойн далд уурхайг яамны зүгээс дэмжиж байгаа. Далд уурхай хэзээд аюулгүй үйл ажиллагааг чанд сахин биелүүлэх учиртай. Эрсдэл өндөртэй учраас уул уурхайн аврах албыг байгуулах хэрэгтэй" гэв.

"Рио Тинто" загвар

Австралийн Брисбан. "Рио Тинто"-гийн далд уурхайн технологийн төвд дэлхийн хэмжээний мэргэжилтнүүд тухлан сууна. Тэд далд уурхайн олборлолтын загвар, бүтээн байгуулалт, үйл ажиллагааны техникийн асуудлыг судалж хөгжүүлж байдаг юм. Тухайлбал, нэг уурхайн зориулалтад тохирсон загвар, технологийг боловсруулан гаргах аж. Тус төвийн мэргэлжилтнүүд Оюутолгойн далд уурхайн төлөвлөлтийн багтай хамтран ажилладаг бөгөөд Оюутолгойн уурхайн нөхцөлд тохиромжтой дэвшилтэт технологийг боловсруулан нэвтрүүлээд байгаа аж. Оюутолгой нь дэлхийн зэсийн таван том үйлдвэрлэгчдийн нэг гэдгийг тэд андахгүй мэдэх. "Өдөр бүр хүн болгон ажлаасаа эрүүл, аюулгүй эргэн ирэхүйц осол аваар, өвчлөлгүй ажлын байрыг хамтдаа бий болгох". Энэ бол Оюутолгойн алсын хараа. Өөрөөр хэлбэл, өглөө гэрээсээ гарсан уурхайчин 1500 метрийн гүнд өдөржин ажиллаад оройдоо гэртээ инээмсэглэн орох асуудал нь далд уурхайн хамгийн том бөгөөд эхний зорилтот ажил. Үүнд чиглэсэн гүнийн уурхайг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчныг төр бүрдүүлэх үүрэгтэй юм. Аюулгүй орчныг хэрхэн бүрдүүлж, хяналт тавьж, дүрмийг хэрхэн мөрдөг талаар "Рио Тинто" компанитай хамтран бусад улс орон, уурхайд очиж туршлага судлах нь чухал ач холбогдолтой ажээ. ■

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ДАВХАР ЦОХИЛТ

Ч.ЛУТАА

Өглөөний сэрүүн агаар, болжмор шувуудын жиргээнээр хотын өглөө эхлэхтэй зэрэгцэн сэрүүлэг дуугарч хүмүүс сэрнэ. Эртэч нэг нь өглөөний цайгаа уугаад ажлын зүг хөлгийн жолоо зална. Зарим нь нойрмог нүдтэй нийтийн тээвэрт чихэлдэж, 8:00 эсвэл 9:00 цагтай уралдана. Учир нь хөдөлмөрлөсөн хүн л хоолтой залгаж, гэр бүлээ тэжээж, цаашлаад ирээдүйдээ хөрөнгө оруулж чаддаг өнөөгийн нийгэмд хүн бүр л ажлын зүг яарах учиртай. Цаг жигд цохилдог шиг нэгэн хэмт ажлын өдөр ийнхүү эхлэх нь тэр. Эгэл жирийн хүмүүсийн байдаг л нэг ажлын эл өдрүүдийг эдийн засгийн ухаанд “хөдөлмөрийн зах зээл” гэх нэршлийн дор судалдаг. Хүн амьдралынхаа гуравны нэгийг буюу сэрүүн өнгөрөөх цаг хугацааныхаа ихэнхийг ажлын байрандаа өнгөрөөдөг тул ажил олгогч, ажилтан хоёрын харилцаа аль болох хүнлэг, аюулгүй, зохистой ажлын байраар илрэх ёстой байдаг аж. Тэртээ өнгөрсөн зуунд хөдөлмөрийн харилцаанд ажил олгогчийн эрхийг хэт дээдэлдэг байсан. Тиймдээ ч эзэн нь боолоо, хаан нь албадаа захирч байснаас биш өнөө цагийн хөдөлмөрийн харилцаа гэж ухагдахууны талаар өчүүхэн ч ойлголт байсангүй. Харин өнөө цагт ажил олгогч нь хөдөлмөр эрхлэгч буюу ажилтныхаа эрхийг хамгаалах нь зайлшгүй асуудал болчихоод байна. Уг хамгаалах тогтлолцоог “хөдөлмөрийн аюулгүй байдал” гэж нэрлэдэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал сайн хөгжсөн орчинд ажилчид сэтгэл хангалуун, хөдөлмөрийн бүтээмжтэй, урт удаан хугацаанд ажиллаж чаддаг аж.



Налайхын нүүрсний уурхай

Монголчууд сонгодог утгаараа хөдөлмөрлөөд удаагүй. Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар засч залруулах зүйлс ч олон. Уул уурхайн их бүтээн байгуулалтыг дагасан ноу-хау, технологийн болон мэдлэгийн инноваци Монголд ихээхэн дэлгэрч байна. Уул уурхай урагшлахын зэрэгцээ түүнийг дагасан ханган нийлүүлэх болон бусад жижиг үйлдвэр хөгжиж, хөдөлмөрийн зах зээл улам л өргөжин тэлсээр. Засаг төр нь ч ажлын байр шинээр бий болгох улс төрийн зорилго дэвшүүлж байна. Үйлдвэрлэл хөгжих, ажлын байр нэмэгдэх нь сайн хэдий ч хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудлыг хамтад нь хөгжүүлэхгүй бол Монголын хөдөлмөрийн зах зээл давхар давхар цохилтод орж, эрүүл мэндийн асуудалтай хөдөлмөрийн насны иргэд олширч магадгүй аж. Тэр дундаа хөдөлмөрлөх хүчний нөөц дээд тал нь нэг сая хүрэхтэй үгүйтэй манай улсад хүн нэг бүрийг эрүүл, аюулгүй, урт удаан хугацаанд хэрхэн ажиллуулах вэ гэдэг чухал асуудал болоод байна.

Чухал салбарын цухал асуудал

Уул уурхайн болон барилгын салбарын цалин өндөр, монголчуудын дийлэнх хувь нь тус салбарт ажилладаг боловч хамгийн өндөр эрсдэлтэй ажлын байр юм. Графикаас харахад уул уурхайн салбарт үйлдвэрлэлийн осол аваар

хамгийн их байдаг нь харагдана. Товчхондоо, ажилдаа явсан аав эргэж ирэхгүй байх магадлал өндөр гэсэн үг. Гэхдээ салбарынхны хэлдгээр уул уурхайн салбар хөдөлмөрийн аюулгүй байдлын тал дээр харьцангуй үлгэр жишээ гэх. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын улсын ахлах байцаагч З.Мөнхтуул “2008 онд батласан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар албан байгууллага бүр ажлын байранд аюулгүй ажиллах дүрмийг зайлшгүй гаргах шаардлагатай. Тэр утгаараа уул уурхайн салбарт гаднын томоохон компаниуд үйл ажиллагаа явуулдаг учраас өөрсдийн орны туршлагыг оруулж ирдэг. Тухайлбал, “Рио тинто” компани Английн хөдөлмөрийн аюулгүй байдлыг Оюутолгойд нутагшуулж байна” гэсэн юм.

Гэхдээ л Монголын уул уурхайн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдлыг стратегийн түвшинд авч үзэх нь ховор. Ялангуяа Монголын үндэсний олборлогч компаниуд хөдөлмөрийн аюулгүй байдлын ямар ч стандартгүй байдаг тухай шүүмжлэх хүн олон. Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа “Монголчуудын хувьд хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай ойлголт тааруу. Социализмын үед хөдөлмөрийн аюулгүй байдлыг техникийн аюулгүй ажиллагааны дүрмээр л ойлгодог байсан болоод ч тэр үү уг ойлголтыг хүн өөртөө тусгаж ойлгох нь цөөн. Тухайлбал, тусгай хамгаалалттай гутал, шил зэргийг ажилчиддаа хөдөлмөрийн аюулгүй байдлыг нь хангах үүднээс өгдөг. Гэтэл тухайн ажилтан, ахан дүү эсвэл хэн нэгэнд ажлын хувцасаа өгчихөөд шаардлага хангаагүй ажлын хувцастайгаа хэнэг ч үгүй ажиллаж л байдаг. Дарга нар нь ч ажлын хувцасаа өмс гэж шаардахгүй. Харин гаднын компаниуд өөр” гэв.

Гэхдээ дотоодын компаниуд юу ч хийхгүй байна гэвэл өрөөсгөл. Германы олон улсын хамтын ажиллагааны “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөр /ЭТИС/, Уул уурхайн үндэсний ассоциаци, “Монголын алт” компани хамтраад Германы Эдийн засаг, технологийн яамны дэмжлэгтэйгээр Монголын уул уурхайн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдлын олон улсын стандартыг нэвтрүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэх зэрэг ажлыг эхлүүлсэн байна. “Монголын алт” компанийн хувьд компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог сайжруулан олон улсын шаардлагад нийцүүлэх цаашлаад дэлгэрүүлэх “OHSAS 18001” стандартыг ойрын ирээдүйд компанидаа нэвтрүүлэхээр зорин ажиллаж буй хамт олон юм. Тус компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хэлтсийн дарга Ч.Эрдэнэбаяр “Нэг талаас хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа гэдгийг олон улсад “соёл” болтол нь хөгжүүлж байна. Нөгөө талаас манай дотоодын компаниуд ажлын байрны аюулгүй байдал нь тухайн компанийн өрсөлдөх чадвар болоод ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах зэрэг олон давуу талыг бий болгодог гэдгийг анхаарах хэрэгтэй. Тиймээс хөдөлмөрийн аюулгүй байдал гэдэг ойлголтыг өнгөцхөн байдлаар сул зарлага гэж харж огт болохгүй” гэв.

Манай улсын уул уурхайн чиглэлийн хөдөлмөрийн аюулгүй байдлын тухайд дүрэм, стандарт, журмууд байдаг хэдий ч зарим нь хуучирсан, ерөнхий байдаг эсвэл чухал дүрэм байдаггүй зэргээс үйлдвэр, уурхай дээр ашиглахад хүндрэл үүсэх тохиолдлууд байдаг аж. Энэ утгаараа тус компани нь өөрийн үйл ажиллагааг сайжруулах үүднээс Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ГОУХАН)-тэй хамтран уул уурхайн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр бодлого, нормыг сайжруулахаар хөтөлбөр хэрэгжүүлж байна. Түүнчлэн энэхүү хөтөлбөрийн эцсийн үр дүнг аль болох нээлттэй байлгаж бусад ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй компани, аж ахуйн нэгжүүдтэй хуваалцана гэсэн чиглэлийг барин ажиллаж байгаа аж. Хөтөлбөрт ЭТИС, Уул уурхайн үндэсний ассоциаци болон МХЕГ-ын холбогдох мэргэжилтнүүд оролцож байгаа бөгөөд хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа сонирхсон компаниуд авч ашиглах боломжтой аж. Энэ бол Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд гаднаас шууд хуулсан англи, хятад, герман гээд янз бүрийн хөдөлмөрийн аюулгүй байдлын стандарт, нормыг барьж ажиллахаа больж нэгдсэн чиг шугамтай болох эхний алхам. “Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг”-ийн Компанийн нийгмийн хариулцлага хариуцсан мэрэгжилтэн О.Батболд “Монгол компаниуд үндэсний нэгдсэн стандарттай болж, түүнийгээ дагаж мөрдөх нь нэг талаар ажилчдынхаа эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг тодорхой стандартын дагуу хангаж, улмаар компанийн үйл ажиллагаа урт хугацаанд тогтвортой, өрсөлдөх чадвартай болох боломж юм. Нөгөө талаар тухайн компанийн урт хугацаанд хэрэгжих стартеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дотооддоо хийж байгаа томоохон хөрөнгө оруулалт гэж ойлгож болно. Энэ удаа “OHSAS 18001”-ийн хэрэгжилтэд Уул уурхайн үндэсний ассоциаци анхаарах болохоор үр дүн сайн гарна гэдэгт итгэлтэй байна” гэв. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг

Үйлдвэрлэлийн осол салбараар (2012 он)



Эх сурвалж: Санхүү, хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын газар

шинэчлэхээр ажиллаж байна. Одоо мөрдөгдөж байгаа хуульд өөр хоорондоо зөрчилдсөн ойлголт олон байдаг аж. Тухайлбал, хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл мэнд эсвэл хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуй гээд олон зөрүүтэй ойлголт байдаг гэнэ. Тиймээс эдгээр замбараагүй ойлголтыг хуулиар цэгцлэх учиртай гэнэ. Мөн уул уурхайн болон бусад салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар маш тодорхой зааж өгөх шаардлагатай аж.

Ч.Эрдэнэбаяр “Уул уурхайн компанийн хөдөлмөрийн аюулгүй байдлын мэрэгжилтнүүд хамгийн түрүүнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийг тодорхой болгох хэрэгтэй гэдэгт санал нэгддэг. Тухайлбал, тухайн ажилтан бүх зүйлийг заасны дагуу л хийх ёстой. Түүнээс биш, ажилтан өөрийнхөө дураар ажиллаж болохгүй. Ингэсэн тохиолдолд хариуцлагын тогтолцоо алдагддаг. Хэрвээ ажилтан хөлдөө мөрний хэмжээтэй зай авч зогсоод ажиллах ёстой бол тэгэх л ёстой. Хэрвээ сууж ажиллавал тухайн ажилтан хариуцлага алдсан хэрэг. Харин хөдөлмөрийн аюулгүй байдлын инженер тухайн ажилтныг дүрэм, журмаа дагаж мөрдөхийг шаардаж, хяналт тавьдаг байх хэрэгтэй” гэсэн юм.

Энэ бол эмгэнэл

Бүх зүйлийг нэг амьсгаагаар шийдчихэж болдоггүй болохоор хуулиа шинэчлээд, уул уурхайн компаниуд “OSHAS 18001”-ийг сайн дураараа хэрэгжүүлдэг боллоо гэвэл монголчуудын хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх ойлголтыг цэгцлэх боломжгүй аж. Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа “Хөдөлмөрийн аюулгүй байдал бол тогтолцоо гэдгийг сайн ойлгох хэрэгтэй. Ганц асуудлыг шийдээд л бүхэл бүтэн тогтолцооны асуудлыг нэг тийш болгож чадахгүй. Хамгийн түрүүнд монгол хүн бүрт “Би өөрөө өөрийнхөө хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангана” гэх ойлголтыг суулгах хэрэгтэй” гэв. Гаднын оронд тухайн хүн ажилд орохдоо ажил олгогч талаасаа хамгийн түрүүнд хөдөлмөрийн аюулгүй ажлын байрны талаарх дүрэмтэй нь танилцдаг. Гэтэл манайд арай өөр асуудалд анхаарал хандуулаад байдаг. Гэхдээ энэ нь зөвхөн хувь хүний буруу биш аж. Ч.Эрдэнэбаяр “Монгол Улсын хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартад бага, дундаас эхлээд их, дээд сургуульд хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар анхан шатны мэдлэг өгөх хичээл заах ёстой талаар заачихсан байдаг. Гэтэл энэ стандарт хэрэгждэггүй. Хэрвээ багаасаа энэ талаар заалгачихвал энгийн иргэн хүртэл хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар анхны мэдэгдэхүүнтэй болно. Барилгын компаниудын хариуцлагагүй үйл ажиллагаанаас болоод барилгын төмөрт цохиулан амь нас нь дээсэн дөрөөн дээр байгаа хүнийг тойрч зогссон хүмүүс утсаасараа бичлэг хийгээд байгаа болохоос биш анхны тусламж үзүүлж мэдэхгүй байсан. Үүнээс монголчуудын хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай ойлголт ямархуу байгааг төвөггүй харж болж байгаа юм. Энэ бол эмгэнэл” гэв. Хөдөлмөрийн аюулгүй байдал гэх ойлголт монголчуудын хувьд шинэ. Гэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдлын суурийг “цутгахад” нийт монголчууд оролцох аваас монгол хүн эх орондоо урт удаан хугацааны туршид аз жаргалтай амьдрах мөрөөдөл биелэх боломж нээгдэх ажээ. ■

САЙН ТУРШЛАГА

ҮНДЭСНИЙ СТАНДАРТ

Б.БАЯР

Шувуу жиргэж, зөгий дүнгэнэх хир буртаггүй үлэмжийн сайхан байгаль. Үе үе салхинд ганхах өвсний чичиргээ. Өглөөний наранд шүүдэртэх ногоон бүс. Тэнд урьд өмнө уурхай байсан гэхэд үл итгэнэ. Итгэхэд ч бэрх өнгө үзэмж нь тодорсон диваажин өмнөөс ийн тольдон угтана. Өвс, ногоо тэгширч хосолсон өөгүй сайхан цэцэрлэгт хүрээлэн. Угтаа хүний гараар бүтэж, унаган төрхөө олсон хангай нутаг хараа булаана. Хэзээ ч энд уул уурхай байгаагүй юм шиг, хэн ч энд надаас өмнө





Ажилчдын амрах байр нь Канад технологиор хийгдсэн, нүүдлийн зориулалттай

гишгээгүй мэт атар онгон санагдана. Ийм сэтгэгдэл төрүүлэхүйцээр нөхөн сэргээж чаджээ, тэд. Хэвлийдээ шархтай ч эрээн цэцгээр хучуулсан Бага хайлааст салхины чимээг эс тооцвол нам гүмхэн. Энэ бол “Уул уурхайн үндэсний олборлогч” компанийн бүтээл юм.

Уул уурхайн салбарт саар, сайны олон жишээ бий. Тэгвэл түүний сайн жишээг бататган буй “Уул уурхайн үндэсний олборлогч” компанийг онцлон танд хүргэж байна. Хариуцлагатай уул уурхайг ном ёсоор нь Монголд нутагшуулсан тус хамт олон энэ оны долдугаар сард нэг сая хүн цаг осол гэмтэлгүй ажилласны баяраа наадам лугаа өргөн дэлгэр тэмдэглэжээ. Нэг сая хүн/ цаг осол авааргүй ажиллана гэдэг амаргүй. Үүнд хүн бүрийн хичээл зүтгэл орсон нь мэдээж. Тэр тусмаа үндэсний уул уурхайн гэрээлэн олборлогч компани дээрх амжилтад хүрнэ гэдэг амар ажил биш ээ. Нөгөө талаас монголчууд уул уурхайн салбарт гаднынхантай өрсөлдөхүйц хэмжээнд өсөн бойжиж байгааг илтгэх мэт.

“Уул уурхайн үндэсний олборлогч” компани 2010 онд хувийн хөрөнгө оруулалтаар байгуулагдсан бөгөөд Байгаль орчиндээлтэй, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхээр зорьж яваа аж. Тэд ахархан хугацаанд амжилтаа ахиулж, хариуцлагатай уул уурхайн шинэ соёлыг түгээн дэлгэрүүлж явна. Тухайлбал, энэ сарын 13-14-нд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Германы техникийн хамтын ажиллагааны төсөлтэй хамтран “Уурхайн хаалт ба байгаль хамгаалал” чуулга уулзалтыг дээрх компани Бага хайлааст, Баянголын уурхайн бүсэд зохион байгуулах гэж байна. Тус чуулга уулзалт гурав дахь жилдээ болох гэж байгаа нь энэ. Уул уурхайн салбарт амжилттай ажиллаж буй компанийн уурхайд өртөөлөн буух тус чуулга уулзалт нь нөгөө талаасаа компанийн өсөлт хөгжлийг тодорхойлдог гэж хэлж болно.

“Уул уурхайн үндэсний олборлогч” компани Монголд төдийгүй дэлхийн нүүрсний зах зээлд нэр нь түгэх Тавантолгойн Баруун цанхийн уурхайд гэрээлэн олборлогчоор ажиллаж байгааг та дуулсан байх. “Олон улсын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлын түвшинг илтгэх OSHAS 18001: 2007 стандартыг компанидаа нэвтрүүлэн тохирлын гэрчилгээг авсан. Манай компанийн хувьд нэг сая хүн, цаг осол гэмтэлгүй ажилласан. Тэр тусмаа үндэсний компани нэг сая хүн цаг осол гэмтэлгүй ажиллана гэдэг том амжилт. Өмнө нь “Бороо гоулд”, “Оюутолгой” нэг сая хүн, цаг осол гэмтэлгүй ажилласан байдаг. Аюулгүй ажиллагаанд ажилчдын ухамсар, аюулгүй ажиллагааны хандлага их чухал” хэмээн тус компанийн Байгаль орчин, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн менежер Б.Батбагана хэллээ.

Уул уурхай хүний хүчийг бус техникийн хүчийг хэзээнээс шүтэж ирсэн байдаг. Тэгвэл сүүлийн жилүүдэд дээрх хандлагад өөрчлөлт гарч, хүнээ хөгжүүлэхэд ихээхэн анхаарах болжээ. Тэр тусмаа уурхайчны хандлага, ухамсар дээшилсэн тохиолдолд аюулгүй ажиллагааны дүрэм, журмаа зөрчих магадлал буурч, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сайн нөхцөл бүрдэж байдаг байна. “Уул уурхайн үндэсний олборлогч” компани нь байгаль орчны аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол зохион байгуулж, уурхайн хаалтын төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн тайлан төлөвлөгөө боловсруулах гээд чамгүй олон ажлыг нэг дор амжуулах нь хүчирхэг хүмүүн капиталын давуу тал гэлтэй. Батбаганын хэлснээр хариуцлагатай уул уурхайн компани гурван чиглэлд онцгой анхаарах ёстой аж. Үүнд, Байгаль хамгаалал, Аюулгүй ажиллагааг туйлаас эрхэмлэх, Орон нутгийн харилцаа буюу үр дүнтэй хамтын ажиллагааг төгс шийдсэн байвал шууд утгаар хариуцлагатай уул уурхай гэж хэлж болох нь ээ.

Ямар ч уул уурхайн компани



Бага Хайлаастын нөхөн сэргээлтийн талбай

ажилчдынхаа зөв хандлагад түшиглэж амжилтад хүрдэг байна. Тиймээс “Уул уурхайн үндэсний олборлогч” компани улиралд нэг удаа бүх нийтийн хурал зохион байгуулж, ажилчдынхаа санал хүсэлтийг сонсон бодит ажил хэрэг болгон иржээ. Ажилчдаа тав тухтай орчинд амраах, сайн чанарын, илчлэг сайтай хоол хүнсээр хангах, ажиллаж, амрах нөхцөлийг сайтар бүрдүүлэхээр ажиллаж байгаагийн нэг жишээ нь Монголд ганцхан буй нүүдлийн зориулалттай Канад модон ажилчдын амрах байр. Ямар ч нөхцөлд нүүлгэн шилжүүлж болдгоороо тус амрах байр Монгол гэртэй төстэй. Халуун, хүйтэн устай, тохилог эл хаус нь хаана ч очоод уурхайн талбайд барихад тохиромжтой аж.


“Уул уурхайн үндэсний олборлогч” компанийн гүйцэтгэх захирал Э.Энхболд “Монгол Улс нөөц боломжоо ашиглах учиртай. Манай компанийн хувьд одоогоор гурван төсөл дээр ажиллаж байна. Уул уурхайн салбар хэдий зогсонги байдалд орсон ч нөхцөл байдал учиргүй дордсон юм алга. Тиймээс хариуцлагатай уул уурхайн салбарт ажиллаж буй компани, аж ахуйн нэгж хосолмол байдлаар уурхайгаа ашиглахын сацуу нөхөн сэргээлтээ зэрэг хийгээд явуулбал цаг хугацаа болоод хөрөнгө мөнгөний хувьд илүү хэмнэлттэй” гэлээ.

Уурхайн талбарт алт, нүүрснээс илүү хүн чухал. Тэнд ажиллаж буй уурхайчны хүсэл мөрөөдөл, амьдрал, итгэл үнэмшил, ур чадвар бүр ч чухал. Тиймээс хүн төвтэй үйлдвэрлэл өрнөж байдаг уул уурхайн салбар нэгэн зуныг үдэж, ирэх намартай золгон байна. Гинжин хэлхээ үүсгэсэн уул уурхай олон зүйлээс хамааралтайг уншигч та эс андах. Зөвхөн дан ганц компани байгаад уул уурхай оршин тогтнохгүй. Тэнд туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, хууль эрх зүйн орчин, хөрөнгө оруулалт, ажиллах хүч гээд түмэн хүний хичээл зүтгэл, нөр их хөдөлмөрийн шимээр уул уурхай уул уурхай болох бус уу. Түүнээс олборлогч компани байлаа гээд өнөөдрийн амжилт буй болохгүй гэдгийг Э.Энхболд онцолсон юм.

Ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, ажиллагсдынхаа эрүүл мэнд болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг багасгах, үнэлэх соёлыг төлөвшүүлж буй “Уул уурхайн үндэсний олборлогч” компанийн ололт амжилт олон үйлдвэрлэгчдэд түгэн дэлгэрэх биз ээ. ■

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА УУЛ УУРХАЙН САЛБАРТ



С.БАТБОЛД
(Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн мэргэжилтэн)

Зөвхөн Монголд ч биш олон улсад уул уурхайн асуудал олон нийт, төрийн байгууллагуудын анхаарлын төвд байна. Олон оронд тухайн компани хайгуул хийхээсээ өмнө тогтвортой хөгжлийн талаарх бодлогоо тодорхойлоогүйгээс хэдэн сая долларыг салхинд хийсгэсэн жишээ байна. Манай улсад компанийн нийгмийн хариуцлага/КНХ/-ыг амжилттай хэрэгжүүлж байгаа олон сайн жишээ байгаа нь үүнийг огт хэрэгжүүлдэггүй гэж хэлж болохгүй. Харин энд хийсэн ажлаа бусдад бодитоор ойлгуулах мөн шинээр суралцах тал дээр хийх ёстой зүйл нэлээд байна.

Уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагыг хэрхэн ойлгох вэ? гэдэг асуулт манай нийгэмд байсаар. Энэхүү ойлголтыг үндэсний оролцогч талуудаар тодорхойлон гаргахаар Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрөөс 2011 онд уул уурхайн салбарын НХ-ын талаар ойлголт мөн хэрхэн хэрэгжүүлж буйг судлахаар хийсэн судалгаанд үндсэн сэдвүүдийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд: байгаль хамгаалал буюу хаагдсан уурхайнуудын нөхөн сэргээлтийн асуудал гэж үзэж байна. Хоёр дахь гол асуудлаар уул уурхайн компаниуд болон тэдний үйл ажиллагаанд шууд өртөж буй орон нутгийн хоорондох харилцаа дурдагдав. Үүнд орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд (“орон нутгийг хөгжүүлэх”) дэмжлэг үзүүлэх, уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэх ур дагавар, арга хэмжээний талаар орон нутгийнханд дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, чухал шийдвэрүүдийг гаргахад орон нутгийнхныг оролцуулах зэрэг асуудал хамаарна. Уул уурхайн холбогдолтой шийдвэр гаргах үйл явцад бүх талуудыг хамруулах нь уул уурхайн салбарын ил тод, хариуцлагатай үзэл баримтлалын үндэс суурь нь юм. Мөн уул уурхайн салбарын нийгмийн хариуцлагын бусад дурдагдсан бүрэлдэхүүн ▸▸

хэсэгт холбогдох татвар хураамжаа зүй зохистой төлөх замаар уул уурхайн салбараас нийгэмд оруулах эдийн засгийн хувь нэмэр, ийнхүү татвар хураамж төлөх болон лиценз олголтын үеийн ил тод байдал мөн компаниудын зүгээс ажилтнууддаа үзүүлэх нийгмийн хариуцлага буюу ажлын байрны аюулгүй байдал зэрэг байлаа. Түүнээс гадна Уул уурхай, металлын олон улсын зөвлөл (ICMM)-ийн стандарт, ISO 26000 стандарт болон Пол Коллиерийн Байгалийн нөөцийн тунхаг бичиг зэрэг холбогдох стандартыг мөрдөн ажиллах ёстой.

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад компани, бусад оролцогч талуудын удирдлага, шийдвэр гаргагчид уул уурхайн салбарын нийгмийн хариуцлагын үндсэн элементүүдийн талаар тодорхой төсөөлөл мэдлэгтэй боловч тэдгээр нь цогц биш, системчлэгдээгүй байгаа нь ажиглагдсан. Энэхүү ойлголт нь бодлогын болон эдийн засгийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үндэс суурь хараахан болж чадахгүй ч гэсэн үүнийг цаашид өргөжүүлэн тэлэх бүрэн боломжтой байна. Нэгтгээд хэлэхэд нийгмийн хариуцлага гэдэг нь байгаль орчин, эдийн засаг, нийгмийн асуудлуудыг цогцоор нь багтаасан эдгээр гурван сэдэв харилцан уялдаатай ойлголт гэдгийг бид мэдэрч аль нэг салбарыг орхилгүйгээр ажилладаг болох ёстой. Эдгээрийг биелүүлэн ажиллаж чадвал тухайн уул уурхайн компани олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөж олон улсад хэлж заншаад байгаа Нийгмийн лиценз гэдгээ авах боломжтой болох юм.

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг барууны компаниуд нь өнгөрсөн хорин жилийн туршид КНХ-ын стратеги бодлогоо тодорхойлох замаар нийгмийн хариуцлагыг байгууллагын менежментдээ системтэйгээр суулгасан бөгөөд байгаль хамгаалах, хүний эрхийг хамгаалах болон хөдөлмөр хамгаалах стандартуудыг сайн дураараа хэрэглэж байна. Тиймээс ч манай улсад үйл ажиллагаа явуулж буй барууны компаниуд нь дотоодын болон Хятад, Оросын компаниудтай харьцуулахад энэ тал дээр тэргүүлэх байр суурьтайгаар ажиллаж байна.

Дотоодын томоохон компаниуд ч гэсэн сүүлийн үед нийгмийн хариуцлагаа илүүтэйгээр хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд зарим компанийн төлөөллийн үзэж буйгаар энэ нь өрсөлдөх чадварыг нь дээшлүүлж байна. Тийм ч учраас уул уурхайн салбарын тэргүүлэх Монгол компаниуд өөрийн үйл ажиллагаандаа КНХ-ыг системтэйгээр нэвтрүүлэх чадавхыг бий болгосон бөгөөд урт хугацаанд нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэгч тэргүүлэгч компани болох, жижиг, дунд компаниудыг энэ үйл явцыг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой ажиллаж байна.

Нэн ялангуяа барууны мөн Монголын томоохон уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх илт сонирхолтой байдаг ба дээрх судалгааны хүрээнд уулзаж ярилцсан компаниудын хувьд КНХ-ын стратегийнх нь гол анхаарах асуудлууд нь ажлын байран дахь аюулгүй байдал, ажилчдын эрүүл мэнд, байгаль хамгаалал болон орон нутгийнхантай хамтран ажиллах, тэднийг шийдвэр гаргах үйл явцад оролцуулах зэрэг байв. Уул уурхайн компаниуд, орон нутаг хоёрын харилцааны асуудалтай Орон нутгийн хөгжил гэсэн сэдэв нягт уялдаатай байдаг. Компаниудын зүгээс уурхайн үйл ажиллагаа явуулж буй тухайн орон нутгийн захиргаанд санхүүгийн туслалцаа тогтмол үзүүлдэг бөгөөд үүнийг нь орон нутгийн дэд бүтцийг өргөжүүлэх, цэцэрлэг, сургууль, эмнэлэг гэх мэт төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад зарцуулдаг байна.

Түүнчлэн Монголд мэргэжилтэй боловсон хүчин дутагдалтай байгаагаас үүдэн уул уурхайн компаниуд тус улсын боловсролын чанарыг сайжруулах ихээхэн сонирхолтой байна. Тийм ч учраас зарим компани орон нутагт уул уурхайн холбогдолтой мэргэжил олгох мэргэжил дээшлүүлэх сургалтын арга хэмжээнүүдийг авч эхлээд байгаа юм.

Иймэрхүү дэвшилтэй арга хэмжээ, үйл ажиллагаанууд нэлээд байгаа боловч КНХ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөрүүд нь үндэсний болон барууны уул уурхайн компаниудын дунд төдийлэн бүрэн нөөц бололцоогоороо хэрэгжихгүй байна. Учир нь үүнийг дэмжих эдийн засгийн хөшүүрэг дутагдалтай байгаа юм. Бодлогын болоод эрх зүйн орчин дутагдалтай, тухайлбал хууль тогтоомж нь тодорхой бус, түүний захиргааны түвшин дэх хэрэгжилт хангалтгүй байгаа. Цаашилбал компаниуд өөрийн нөөц бололцоо, давуу талтайгаа уялдуулан авч ашиглахуйц нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого байхгүй зэрэг нь энд мөн шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна.

Шинжлэх ухаан, иргэний нийгэм болон үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд бэлэн зарим уул уурхайн компанийн хувьд нийгмийн хариуцлагын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн тулд уул уурхайн нийгмийн хариуцлагын үндсэн элементүүдийг болон эдийн засгийн хөшүүргийн тодорхой механизмыг өөртөө багтаасан баримт бичиг, хууль байх шаардлагатай гэж судалгаанд оролцсон талууд нэгэн дуугаар илэрхийлж байв. ■



“Бороо Гоулд” ХХК-ийн нөхөн сэргээлтийн талбай

1. MISA Gold Snow Rejuvenating Essence – Залуужуулах эссэнз

Арьсыг сэргээж өнгөлөг толигор болгоно
Арьсны бэрхшээлүүдийг арилгаж, залуужуулна
Мөн үрчлээний эсрэг болон цайруулах хоёрлосон үйлчилгээтэй

2. MISA Gold Snow Toner – Тоник

Үрчлээний эсрэг
Чийгшүүлэх
Арьсны тэнцвэртэй байдыг хадгална

3. MISA Gold Milky Emulsion – Эмульс

Гүн чийгшүүлэх, үрчлээний эсрэг үйлчилгээтэй
Арьсны залуу байдлыг хадгалж, гэрэлтсэн өнгөлөг болгоно
Нарны нөлөөнөөс болж хордсон арьсыг эрүүлжүүлнэ

4. MISA Gold Snow Rejuvenating Cream – Залуужуулах тос

Үрчлээний эсрэг болон цайруулах хоёрлосон үйлчилгээтэй
Арьсыг сэргээж өнгөлөг толигор гэрэлтсэн болгоно
Арьсны залуу байдлыг хадгалж, уян хатан болгоно

5. MISA Gold Snow Eye Cream – Зовхины тос

Зовхины арьсыг сэргээнэ
Өнгөлөг гэрэлтэй болгоно
Үрчлээний эсрэг болон цайруулах үйлчилгээтэй
Уян хатан чанарыг сайжруулж, залуу байдлыг хадгална



Хаяг: УИД-ийнзүүнталдMisshaнэрийндэлгүүр; салбар дэлгүүр:3-р хороолол, Apex ихдэлгүүрийн 1 давхар #104
Утас: 70113234, 99060318



ORIENTAL HERBAL ESSENTIAL SKIN CARE

Гол найрлага :

Цэвэр алт, зэрлэг хүн орхоодой - Гүн үрчлээ тогтож эхэлсэн арьсыг эрүүлжүүлнэ.

Хүн орхоодой, бүгын цусан эвэр, хилэн хөвд мөөг - Арьсны өнгийг сэргээж гэрэлтсэн болгоно.

Модны мөөг, хүн орхоодой - Суларсан арьсыг чангалж, цайруулна.

80 төрлийн ургамлын хандтай

20 насны сүүл үе, түүнээс дээш насныхан хэрэглэхэд тохиромжтой.